



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,  
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160  
Утас/Факс: (976-51) 26 75 33,  
Цахим шуудан: info@mojha.gov.mn,  
Цахим хуудас: www.mojha.gov.mn

2024.04.27 № 1/1994  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН  
ХОЛБООНЫ ЕРӨНХИЙЛӨГЧ  
П.ОДГЭРЭЛ ТАНАА**

Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.6 дахь заалтад заасны дагуу Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон Хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой зарим хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулан санал авахаар хүргүүлж байна.

Судлан үзэж саналаа ирүүлнэ үү.

Хавсралт: 35 хуудастай.



**Б.ЭНХБАЯР**

Дос. утга 5.2024  
151501476

**БАТЛАВ  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**

**Б.ЭНХБАЯР**

**ХҮНИЙ ЭРХ, ЭРХ ЧӨЛӨӨГ ХАНГАХТАЙ ХОЛБООТОЙ  
ЗАРИМ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ  
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл**

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ." гэж, Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Ох орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн." гэж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг гажуудуулж болохгүй." гэж тус тус хуульчлан тогтоосон.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 9 дэх заалтад "Монгол Улсын Засгийн газар нь хүний эрхийг хангах эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх арга хэмжээ авах," гэж, мөн хэсгийн 10 дахь заалтад "Монгол Улсын олон улсын гэрээг хэрэгжүүлэх, тэдгээрт хууль тогтоомжийг нийцүүлж, биелэлтийг хангуулах чиг үүргийг хэрэгжүүлэхээр заасан.

Түүнчлэн, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.3 дахь заалтад иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байхаар, Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар тус тус хуульчилсан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого"-ын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.5.1-д заасан хүний эрхийг хамгаалахад төр, иргэний нийгэм, бизнесийн байгууллагуудын санаачилга, оролцоо, хамтын ажиллагааг хөхиүлэн дэмжих, хамтран ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлж, хөгжүүлэх зорилтын хүрээнд "Хууль сахиулах байгууллагын үйл ажиллагаанд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлж, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоход чиглэсэн хөтөлбөр хэрэгжүүлнэ". гэж, "Засаглалын үйл ажиллагаанд иргэд эрх тэгш оролцон үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх боломж, чадавхыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх орчныг бүрдүүлнэ." гэж, "Нийгмийн бүлгүүд засаглалын үйл явцад тэгш оролцох боломжийг хангасан тогтолцоог бүрдүүлнэ." гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.4.7-д

"Эрүүгийн хууль тогтоомжийн эрх зүйн шинэчлэлийг гүнзгийрүүлж, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх тогтолцоо, бодлого, арга барилыг боловсронгуй болгоно." гэж тусгасан.

Олон улсын гэрээний тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсэгт "Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулна." заасан.

Мөн "Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн хэрэгжилтийг хангах, Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойд зориулсан Улсын Их Хурлын хүндэтгэлийн хуралдаантай холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2023 оны 114 дүгээр тогтоолын 2 дахь хэсгийн 3/ дэд заалтад олон улсын гэрээ конвенцод дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх ажлыг эрчимжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон.

**2.1.Практик шаардлага**

Монгол Улс 1961 оноос Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүн болсноос хойш Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний төрөлжсөн байгууллагаас батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 70 гаруй гэрээнд, үүнээс хүний эрхийн суурь 18 гэрээний 17-д нэгдэн ороод байна. Монгол Улсад шинэ Үндсэн хуулийн үзэл баримтлалд тулгуурлан хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, хүн эрхээ эдлэх, үүргээ биелүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн бие даасан 590 хууль хүчин төгөлдөр үйлчилж байна.

2020 оноос хойшхи хугацаанд эрх зүйн шинэчлэлийн хүрээнд хүний эрхийг хангах чиглэлээр эрүүгийн хууль тогтоомжийг боловсронгуй болгох, авлигатай тэмцэх цогц бодлого, шүүх эрх мэдлийн шинэтгэл, мэдээллийн ил тод байдлыг хангах, хүний хувийн мэдээллийг хамгаалах, төрийн үйл ажиллагааны шуурхай байдлыг хангахад чиглэсэн цахимын багц хуулиуд, боловсролын багц хуулиуд, нийгмийн даатгал, халамжийн багц хуулиуд, хөдөлмөрлөх эрх, хүүхдийг эрхийг хангах хамгаалах чиглэлээр холбогдох хуулиудын шинэчилсэн найруулгыг боловсруулж, Улсын Их Хурлаас баталж, хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагаанд тодорхой дэвшил гарган ажиллаж байна.

Монгол Улс 2023 онд Америкийн Нэгдсэн Улсын Freedom House олон улсын төрийн бус байгууллагын судалгаагаар улс төрийн эрх чөлөөний хувьд 40 оноо авахаас 36 оноо, иргэний эрх чөлөөний хувьд 60 оноо авахаас 48 оноо, нийт 100 оноо авахаас 84 оноо авснаар эрх чөлөөт улсын ангилалд багтаж байна.

Хэдийгээр нийтээр хүлээн зөвшөөрсөн хүний эрх, эрх чөлөөг хангах хамгаалах, эрх зүйн таатай орчин бүрдүүлж, хүний эрхийг хангах, хамгаалах байгууллагуудыг байгуулж үр дүн гарсан хэдий ч хүний эрхийн зөрчил, шийдвэрлэх шаардлагатай асуудлууд байсаар байна.

Монгол Улс амьд явах, халдашгүй чөлөөтэй байх, эрүүдэн шүүхээс ангид байх, шударга шүүхээр шүүлгэх, хохирлоо шударгаар барагдуулах, хувийн мэдээлэл халдашгүй байх, эвлэлдэн нэгдэх, жагсах, цуглах, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэлтэй байх зэрэг иргэний болон улс төрийн эрхийг бодитойгоор баталгаатай эдлүүлэх шаардлагатай байгааг хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцооноос зөвлөсөөр байна.

Монгол Улс хүний эрхийн олон улсын гэрээнд нэгдэн орохын зэрэгцээ Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн болон гэрээний механизмуудыг идэвхтэй ашиглаж хүний эрхийг хангах, хамгаалах үйл ажиллагааг тасралтгүй анхаарч ажиллаж байна.

Хүний эрхийн олон улсын гэрээнд нэгдэн орсноор тухайн гэрээ, конвенцуудыг бодитойгоор хэрэгжүүлэх, түүний биелэлтийг тодорхой хугацаанд тайлагнах үүргийг хүлээдэг. Монгол Улсын Засгийн газар хүний эрхийн нэгдэн орж соёрхон баталсан үндсэн гэрээ, конвенцын хүрээнд 1971-2023 онд нийт 57 илтгэл, Хүний эрхийн зөвлөлд Хүний эрхийн төлөв байдлын ээлжит нэгдсэн хэлэлцүүлэг /UPR/-т 3 илтгэлийг тус тус хүргүүлсэн байдаг.

Монгол Улсын хүний эрхийн төлөв байдлын талаарх үндэсний гуравдугаар илтгэлийг хэлэлцүүлсний мөрөөр НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар хүний нэр төрийг доромжлон харьцах, шийтгэхийн эсрэг арга хэмжээ авах чиглэлээр 11, хүүхэд, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс болон ахмад настан зэрэг хүн амын эмзэг бүлгийн иргэдийн эрх, ашиг сонирхлыг хамгаалах чиглэлээр 31, шийдвэр гаргах түвшинд эмэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр 4, гэр бүлийн болон жөндөрт суурилсан хүчирхийлэлтэй тэмцэх чиглэлээр 27, хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр 23, хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр 9, Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрхийг хангах чиглэлээр 3, ялгаварлан гадуурхах бүх хэлбэр, тэр дундаа ЛГБТИ хүмүүсийг ялгаварлан гадуурхахтай тэмцэх чиглэлээр 14, олон улсын гэрээнд нэгдэн орох, дотоодын хууль тогтоомжийг нийцүүлэх, хүний эрхийн гэрээний хэрэгжилтийг сайжруулах, хүний эрхийн олон улсын механизмтай хамтран ажиллах чиглэлээр 8, шүүхийн бие даасан, хараат бус байдлыг бэхжүүлэх чиглэлээр 8, Эрүүл мэнд, нийгмийн халамжийн үйлчилгээ хүртэх эрхийг хангах чиглэлээр 12, Хүний эрхийн Үндэсний Комиссын чиг үүргийг бэхжүүлэх чиглэлээр 10, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах чиглэлээр 5, бусад 16 зэрэг нийт 170 зөвлөмжийг өгснийг бид үргэлжлүүлэн хэрэгжүүлж ажиллах шаардлагатай байна.

НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан Ажлын хэсэг Монгол Улсын Засгийн газрын урилгаар 2022 оны аравдугаар сарын 3-14-ний өдрүүдэд Монгол Улсад ажиллаж хүний эрх чөлөөг дур мэдэн хасах асуудлыг шийдвэрлэхийн тулд тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт зөвлөснийг мөн анхааралтай хэрэгжүүлэх учиртай.

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс нь 2001-2024 онд Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний нөхцөл байдлын талаарх нийт 23 удаагийн илтгэлийг Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн хүний эрхийг хангах хууль эрх зүйн орчныг сайжруулах, хүний эрхийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, зөрчлийг арилгах, хүний эрхийг хамгаалахтай холбоотой саналыг танилцуулж, илтгэлийн мөрөөр авах арга хэмжээний талаар Улсын Их Хурлаас холбогдох шийдвэрүүд баталж ирсэн байдаг.

Дээрх илтгэлүүдэд иргэний болон улс төрийн эрхүүд, тухайлбал, үзэл бодлоо илэрхийлэх, мэдээлэл хайх, хүлээн авах, тайван жагсаал, цуглаан хийх, амьд явах эрх, сонгох, сонгогдох эрх, халдашгүй чөлөөтэй байх эрх, өргөдөл гомдлоо шийдвэрлүүлэх эрх, эрүү шүүлт ба хүний эрх, өөрийгөө өмгөөлөх, хууль зүйн туслалцаа авах эрх, түүнчлэн эдийн засаг, нийгэм соёлын эрхүүд, тухайлбал, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрх, эрүүл мэндээ хамгаалуулах эрх, эмнэлгийн

тусламж, үйлчилгээ авах эрх, сурч боловсрох эрх, хөдөлмөрлөх эрх, хүний эрхийн боловсрол, аж ахуй эрхлэх, зохистой хоол хүнсээр хангагдах эрх, зорилтот бүлгийн эрхүүд, тухайлбал, хүүхдийн эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, үндэсний цөөнхийн эрх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүн худалдаалах гэмт хэрэг ба хүний эрх, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрхийн талаар тусгасаар ирсэн байна.

2023 онд Монгол Улсын хүний эрх, эрх чөлөөний байдлын 22 дахь илтгэлийг хүний халдашгүй чөлөөтэй байх эрх, иргэний оролцооны эрх зүйн зохицуулалт, хөдөлмөрлөх эрх, хүүхдийн эрх, ахмад настны эрх, хүний эрх хамгаалагчийн эрх, улс төрийн хүрээн дэх жөндөрийн эрх тэгш байдал гэсэн 7 сэдвийн хүрээнд боловсруулсан бөгөөд үүнтэй холбогдуулан Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолоор тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт үүрэг болгосон.

2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооноос Улсын Их Хурлын 2022 оны 49, 2023 оны 35 дугаар тогтоолын хэрэгжилтийн талаар Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Засгийн газар, иргэний нийгмийн байгууллага зэргийг оролцуулан хэлэлцүүлэг зохион байгуулсан. Тус хэлэлцүүлэгт Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолоор Засгийн газраас авч хэрэгжүүлэхийг даалгасан нийт 5 зүйлийн 20 заалтаас хэрэгжсэн 6, хэрэгжих шатандаа байгаа 1, үе шаттайгаар хэрэгжүүлж буй 5, хэрэгжилт хангалтгүй 7, хэрэгжээгүй 1 заалт тус тус байна гэсэн дүгнэлтийг танилцуулсан.

Түүнчлэн, Хүний эрхийн Үндэсний Комисст ирүүлсэн нийт гомдол мэдээллийн дийлэнх нь ажлын байрны дарамт, хууль бусаар цагдан хорих, төрийн байгууллага албан тушаалтанд өргөдөл, гомдол гаргах эрх, хүүхдийн эрх, хилс хэрэгт холбогдсон гэх асуудал, эд мөнгөний тусламж авах, нэр төрийн халдашгүй байдал зөрчигдсөн тухай, хууль зүйн туслалцаа авах эрх зэрэг байгааг мөн анхаарч үзэх шаардлагатай байна.

Мөн "Хүний эрх-Дэвшилтэт бодлогын хүрээлэн" төрийн бус байгууллагаас Монгол Улс дахь хүний эрхийн төлөв байдал: тулгамдсан асуудал, шийдэл сэдэвт тойм судалгааг хийж, хүний үндсэн эрхүүдээс нэн тэргүүнд анхаарах шаардлагатайг сонгон эрх тус бүрийн гол агуулга, ахиц дэвшил, тулгамдсан асуудал, шийдвэрлэх арга замд анализ хийж, нийт 228 зөвлөмж боловсруулсан байдаг. Үүнээс 2021 оноос хойш Улсын Их Хурлаас баталсан хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэгдсэн нийт 66 асуудал буюу 29 хувь, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах боломжтой 70 асуудал буюу 31 хувь, Хүний эрхийг хангах энэхүү багц хуулийн төсөл боловсруулах хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж үзсэн 35 асуудал буюу 16 хувь тус тус байна.

Мөн Засгийн газраас болон хууль санаачлах бусад этгээдээс боловсруулж байгаа хууль тогтоомжийн төслийн хүрээнд шийдвэрлэх боломжтой гэж үзсэн 28 асуудал буюу 12 хувь байна. Харин үлдэх 30 асуудал буюу 13.1 хувийг шийдвэрлэхэд тодорхой төлөвлөлт, хугацаа шаардлагатай бөгөөд эдгээрийг "Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр-2" болон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн бусад баримт бичигт тусган үе шаттайгаар хэрэгжүүлж ажиллах боломжтой гэж үзлээ.

Түүнчлэн, Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар хүний эрхэд тавьж буй хориглолт, хязгаарлалтыг хуульд тодорхой заах, хязгаарлалт нь үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, эсхүл нийгмийн дэг журам гэсэн ашиг

сонирхлыг хамгаалах зорилготой байх, хязгаарлалт нь эгтээр зорилгын нэгэнд гэдүрхэхийг байх, үндсэн эрхийг аль болох эдгүүрхээр хангалттай байх гэдэгт зарчмыг баримтлахыг шаарддаг. Иймээс хүний эрх, эрх чөлөөт гэдэгт зарчмыг баримтлахыг шаарддаг. Харвалт бус шүүхээр хяналттай байх захиргааны хэм хэмжээний актээр зохицуулж байгаа байдлыг нь мөн өөрчилж, тухайн зохицуулалтыг тэрхүү зарчмыг баримтлан хуульд тусгах замаар шийдвэрлэх шаардлагатай асуудлыг мөн байсаар байна.

Үүнтэй холбогдуулан, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас Захиргааны хэм хэмжээний актыг үлсн нэгдсэн санд бүртгэлтэй нийт актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайлан 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд тус хуралдаанаас Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хуулиар тусгайгаар эрх олгосон заалтад дүн нийтлэл хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг даалгасны дагуу төрийн захиргааны төв байгууллагад өөрсдийн эрхтэй асуудлыг хэрэвний хууль тогтоомжийн төслийг тус боловсруулж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сабарт хамаарах Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 35 хуулиар 160 гаруй дүрэм, журам батлах эрхийг Засгийн газар, Засгийн газрын гишүүн болон агаар, байгууллагын даргад олгосон байгаагаас 50 орчим хувь нь хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай буюу хүний эрх, эрх чөлөөт хөндсөн, тухайн харилцаанд оролцогчийн эрх, үүргийг тогтоосон буюу процессын шинжилгээтэй зохицуулалт гэж үзэн нийт 29 хуулийн төслийг боловсруулаад байна. Эгтээр нь хүний эрхийг хангах хүрээнд боловсруулах хуулийн төслийг тусгайгаар агуулахыг давчлахгүй, бие даасан үзэл баримтлалтай багц хуулийн төсөл болно.

Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд заасны дагуу Засгийн газар Комиссын илтгэлээр өгсөн санал, зөвлөмжийн биелллийг хариуцаж Үлсн Их Хуралд илтгэх үүрэгтэй.

Ийнхүү "Альсн хараа 2050" Монгол Үлсн үрт хугацааны бодлого, Засгийн газрын "2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-т тусгасан зорилго, Засгийн арга хэмжээг хэрэгжүүлэх, Монгол Үлс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлыг таларх 22 дахь илтгэл, Эрүү шүүлтээс урьдчилсан сөрөг үрэлтэй тухай" гишүүний тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Монгол Үлсн Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөт хамгаалах, зөрчилгээг урьдчилсан сөрөг үрэлтэй аргаар үндэсний хууль тогтоомжийг боловсруулах болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх зорилгоор холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулах шаардлагатай байна.

### Хөбөр, Хуулийн зорилго, өдөнхийн бүтэц, зохицуулах харилцаа

Хүний эрхийг хангахтай холбоотой багц хуулийн төслийн зорилго нь үндэсний хууль тогтоомжийг боловсруулах болгох, хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх болно. Тус зорилгын хүрээнд дараах хуулийн төслийг боловсруулна:

1. Нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст үнэ төлбөрийг үзүүлэх хууль зүйн тусгалааны төрөл, хүрээ, хэмжээг тусгайгаар хангах, өдөн мөрийн тусгалаа бүрэн хангах, олон улсын хуульчтай эрх тогтоолон эгтэр, эх хуульч заасан

хэрэг, маргаанд хууль зүйн тусгалаа үзүүлэх асуудлыг сайддын тушаалаар баталсан журмын дагуу зохицуулж байсныг хуулийн төсөлд тусгах зорилгоор боловсруулах хууль зүйн тусгалааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

2. Баривчлах шийтгэлийг оногдуулахгүй байх этгээний хүрээ хязгаарыг иргэдийн зүй ёсны хэрэгтэй шаардлагад нийцүүлэн өргөжүүлэх, хуулийн тусгай анд заасан зөрчил үйлдсэн этгээд онооногдуулах баривчлах шийтгэлийг нөхөж, үндэсний шилжилт хөдөлгөөний тухай хууль баталсантай нөхөж, Үлсн Их Хурлаас 2021 онд Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн нааруулах, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль баталсантай холбогдуулан зөрчлөлд тооцож үйлдлийг зөрчлөлд тооцож үйлдлийг зөрчлөлд хаах үрчлэлтэн сөрлийг тухай хууль зөрчих үйлдлийг зөрчлөлд тооцож үйлдлийг зөрчлөлд хаах зорилгоор боловсруулах зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

3. Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны оролцоо болон шүүх байдал, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцоо болон шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтнууд бий болгох хүндэр, чирэгдлийг багасгах, цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх зохицуулалт, зарим төрлийн хэргийн хэрьяалагд бий болж байгаа алдааг засах зохицуулалт бүхий Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

4. Хууль зүй, дотоод хэргийн сайд, Үлсн Ерөнхий прокурорын 2017 оны А/22, А/31 дугаар хамтарсан тушаалаар баталсан "Тэр бүлийн хүчирхийллийн зохиорчийн аюулгүй байдлыг хангах журам", Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2017 оны А/37 тоот тушаалаар баталсан "Хохирогчид аюулын зарийн үнэлгээ хийх тухай журам"-аар тус тус зохицуулсан харилцаа тухай тусгах, хохирогчийн түр байрлалын тусламж үйлчилгээ үзүүлэх зорилготой Нэг цагийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээний хүрээг заахыг ялгалаа гаргаж, хариуцах этгээдийг тодорхой болгох зорилгоор "Тэр бүлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

5. Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангахад чиглэсэн холбогдох зохицуулалтуудыг тусгах хохирогчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг хуульчлан, Нэг цагийн хохирогчийн хамгаалах байрны асуудлаарх хуулийн үйлчилгээний таларх нүүдлэх мэдээллийн өөрчлөлт, хуульчлан, гэмт хэргийн туслах, хохирогчид хамгаалах байранд үйлдсэн гэмт хэргийн зарим стандртад нийцсэн түр хамгаалах байранд хамгаалах, хохирогчид хамгаалах зарим арга хэмжээг зохицуулж байсан болон таларх хохирогчид хамгаалах зарим арга хэмжээг тусгай хуульд "хохирогч"-ийг ялгаатай байдлаар тодорхойлсон нь хуульчлан, гэмт хэргийн туслах тухай хууль болон "Тэр", хохирогчийн хамгаалах тухай хуульд тэмцэх тухай хууль болон "Тэр", хохирогчийн хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

6. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон "Тэр", хохирогчийн хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

7. Монгол Улсын иргэнийг Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлзүүлэх журмыг боловсронгуй болгох, хилийн хориг тавих эрх бүхий байгууллагуудын уялдаа холбоог хангах, Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалаар баталсан "Хүүхдийг улсын хилээр нэвтрүүлэх журам"-аар зохицуулж байгаа харилцааг хуулийн төсөлд тусгах, ингэхдээ Улсын Их Хурлаас 2024 онд баталсан Хүүхэд хамгааллын тухай хуулийн шинэчилсэн найруулгад нийцүүлэх зорилготой Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

8. Албаны нууцын тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлох, албаны нууцын хүрээ хязгаарыг багасгах, тухайн байгууллагын даргын шийдвэрээр албаны нууцад хамааруулж байгаа зохицуулалтыг эргэн харах, иргэдийн мэдээлэл авах эрхийг хязгаарлаж байгааг арилгах, хуулийн зохицуулалтыг Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуультай уялдуулан боловсронгуй болгох зорилгоор боловсруулах Төрийн болон албаны нууцын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

9. Цагдаагийн алба хаагчийн тасралтгүй сургалтын тогтолцоо, цагдаагийн алба хаагчид олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журмыг сахиулахдаа хүний эрхийн мэдлэг, хандлага төлөвшүүлэхэд чиглэсэн зохицуулалт бүхий Цагдаагийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

10. Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ (Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ)-ний төрөл, дэглэм, хугацаа тогтоож буй байдал, тус арга хэмжээг хэрэглэхэд хууль ёсны төлөөлөгчийн оролцоог хангах зохицуулалтыг боловсронгуй болгох, эрүү шүүлт тулгах, хүчээр алга болгох гэмт хэргийн шинжийг олон улсын хүний эрхийн байгууллагын зөвлөмжид нийцүүлэн тодорхой болгох зорилгоор боловсруулах Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

11. Харилцаа холбооны зохицуулах хорооны гишүүдийн хараат бус байдлыг хангах, иргэний нийгмийн болон мэргэжлийн байгууллагын бодит оролцоог хангах, тэдгээрийг нээлттэй сонгон шалгаруулалтаар томилох зохицуулалтыг бий болгох зорилгоор боловсруулах Харилцаа холбооны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

12. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх бүхий хуульчдад /шүүгч, прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульч/ олон улсын гэрээ конвенцын ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, уг асуудлыг хуульчийн үргэлжилсэн сургалтын хөтөлбөрт тусгах хөшүүрэг бий болгох, Улсын Их Хурлаас 2019 онд баталсан Өмгөөллийн тухай хууль, Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд Өмгөөллийн тухай хууль баталсантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газар Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсронгуй болгох, өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй байхаар холбогдох хуулийн төслийг боловсруулахыг Засгийн газарт даалгасны дагуу хуульч, өмгөөлөгчийн хураамжийг сайн дурын үндсэн дээр аль нэг байгууллагад төлдөг болох зохицуулалт бүхий Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

13. Өмгөөллийн тухай хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн асуудлаар иргэд гомдол гаргаж, Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 02 дугаар

дүгнэлтээр Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчөөгүй гэсэн дүгнэлт гарсан боловч ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг бүрэн эдлүүлэхтэй холбоотойгоор зарим зохицуулалтыг өөрчлөх шаардлагаар Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

14. Монгол Улсын хөгжлийн бодлогын баримт бичгүүдийг боловсруулахдаа тухайлан хүний эрхийн үнэлгээ, судалгаа хийхтэй холбоотой зохицуулалтыг бий болгох зорилгоор Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл;

15. Иргэний мэдээлэл авах эрхийг хангах зорилгоор агаарын чанарын мэдээлэл, тайланг эрх бүхий байгууллагад хүргүүлэхээс гадна олон нийтэд заавал мэдээлдэг байх зохицуулалт бүхий Агаарын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

16. Хэвлэл мэдээллийн байгууллагад хязгаарлалт тогтоох асуудлыг дайчилгааны үед авах үндсэн арга хэмжээ болгон хэрэглэх зохицуулалтыг Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд нийцүүлэн хасах зохицуулалт бүхий Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

17. Хөдөлмөрлөх эрхийн асуудлыг хөдөлмөрлөх эрхийн олон улсын гэрээ, конвенцид нийцүүлэх, зарим зохицуулалтыг практик шаардлагад нийцүүлэн боловсронгуй болгох зорилгоор Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

18. Хүний эрхийг хамгаалагчийн тогтвортой, үр дүнтэй ажиллах боломжийг бүрдүүлэх, Комиссын хараат бус байдлыг хангах зорилгоор Комиссын даргыг Улсын Их Хурлын даргаас санал болгож Улсын Их Хурлаас томилж байгааг өөрчилж гишүүд дотроосоо олонхын саналаар сонгож, Улсын Их Хуралд санал болгох зохицуулалт бүхий Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

19. Эрүүгийн хуульд албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ (эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ)-ний төрөл, дэглэмийг тусгах болсонтой холбогдуулан Шүүхийн шийдвэр шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

20. Баривчлах, саатуулах, цагдах хорих байранд байгаа Сэжигтэн, яллагдагчийн захирдал харилцааны нууцыг хамгаалуулах эрхийг хангахад тодорхой ахиц гаргах, хуульд хэрэглэгдээгүй нэр томъёог хасах зэрэг зохицуулалт бүхий Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл.

Түүнчлэн, дээрх хуулийн төслийг боловсруулахдаа Засгийн газраас 2020 оноос хойш боловсруулж, Улсын Их Хурлаас батлан 2024 оноос дагаж мөрдөж байгаа Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэмжийн тухай, Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай, Хүүхэд хамгааллын тухай, 2023 оноос дагаж мөрдөж байгаа Боловсролын ерөнхий хууль, Дээд боловсролын тухай, Сургуулийн өмнөх болон

ерөнхий боловсролын тухай, Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай зэрэг хуулиудын шинэчилсэн найруулгын хэрэгжиж эхлэх тодорхой хугацааг харгалзан хөндөхгүй байх нь зүйтэй гэж үзлээ.

Мөн Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хувийн нэмэлт тэтгэврийн тухай анхдагч хуулийн төсөл, Хүмүүнлэг боловсролын тухай хуулийн төсөл болон эрхлэх асуудлын хүрээний төрийн захиргааны төв байгууллагаас ойрын үед Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай, Саадгүй хүртээмжийн тухай, Ахмад настны эрхийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Нийгмийн халамжийн тухай, Төрийн албан хаагчийн цалин хөлс, нийгмийн баталгааны тухай, Шинжлэх ухаан, технологийн тухай, Эрүүл мэндийн тухай зэрэг хуулийн шинэчилсэн найруулга болон Дохионы хэлний тухай анхдагч хуулийн төслийг тус тус боловсруулж байгаа бөгөөд эдийн засаг, нийгэм, соёлын эрхэд хамаарах эдгээр хуульд оруулах өөрчлөлтийн талаар хуулийн төсөл боловсруулаагүй болно.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар**

Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгүүдэд тусгасан хүний эрхийг хангах, хамгаалах, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн зорилт, арга хэмжээг бодитойгоор хэрэгжүүлэх боломж бүрдэнэ.

Түүнчлэн, олон улсын гэрээ, конвенцуудад Монгол Улсын хууль тогтоомжийг нийцүүлэх үйл ажиллагаад ахиц дэвшил гарч, хүний эрхийн олон улсын механизмуудаас зөвлөсөн зөвлөмжүүд, мөн Монгол Улсын хүний эрхийн үндэсний байгууллага болох Хүний эрхийн Үндэсний Комиссын хүний эрх, эрх чөлөөний байдлын жил бүрийн илтгэлүүдээр өгсөн зөвлөмжийг Засгийн газраас хэрэгжүүлж холбогдох арга хэмжээг авдаг байдал хэвшиж тогтоход чухал ач холбогдолтой.

Мөн хүний эрхийг хангах, хамгаалахад иргэний нийгмийн байгууллагуудын дуу хоолой, санал, дүгнэлтийг хүлээн авч, тэдгээрийн оролцоог хангах, иргэний эрхийг ялангуяа тусгай бүрэн эрхийг хэрэгжүүлдэг төр, түүнийг төлөөлсөн этгээдийн зүгээс иргэдийг эрхийг хангах, хамгаалах, үндсэн эрхийг бодитойгоор, бүрэн эдлүүлдэг байх эрх зүйн орчин сайжирна.

Хэдийгээр олон улсын гэрээ конвенцоор хүлээсэн үүрэг, тэдгээрийн байгууллагаас ирүүлсэн зөвлөмж, хүний эрхийн үндэсний байгууллага, төрийн бус байгууллагуудын санал, эрх бүхий байгууллагаас Засгийн газарт даалгасан арга хэмжээ, хүний эрхтэй холбоотой бүх зөрчил, дутагдлыг хуулиар нэг дор арилгаж, засах боломжгүй боловч энэхүү хуулийн төсөл батлагдсанаар хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалахад томоохон дэвшил авчрах боломжтой болж цаашид хүний эрх, эрх чөлөөг хангах, хамгаалах, зөрчигдөхөөс урьдчлан сэргийлэх, хөхиүлэн дэмжихэд чиглэсэн бусад хууль тогтоомжийн төслийг тодорхой төлөвлөлт, үе шаттайгаар боловсруулах болно.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулах хууль тогтоомжийн төсөл байхгүй болно.

-ооОоо-

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

Төсөл

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХ ЧӨЛӨӨНИЙ ТУХАЙ**  
*/Шинэчилсэн найруулга/*

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ.**  
**НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

**1 дүгээр зүйл.Хуулийн зорилт**

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан тайван жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох эрх чөлөөг баталгаажуулах, жагсаал, цуглааны үед олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийтийн хэв журмыг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

**2 дугаар зүйл.Жагсаал, цуглаан хийх журмын хууль тогтоомж**

2.1.Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль болон эдгээр хуультай нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

**3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ**

3.1.Энэ хууль дараах харилцаанд үйлчлэхгүй:

3.1.1.төрийн эрх бүхий байгууллагаас зохион байгуулж байгаа хүндэтгэл болон ёслолын жагсаал, цуглаан;

3.1.2.хүн, хуулийн этгээдээс зориулалтын байгууламж болон олон нийтийн газар зохион байгуулж байгаа спорт, урлаг, соёл, үзэсгэлэн худалдаа, бизнесийн үйл ажиллагаа болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ;

3.1.3.төрийн байгууллага, нийтийн эрх зүйн этгээдээс зохион байгуулж байгаа хурал, уулзалт, хэлэлцүүлэг, мэдээлэл болон үйлчилгээ үзүүлэх өдөрлөг болон тэдгээртэй адилтгах бусад арга хэмжээ;

3.1.4.улс төрийн нам, эвсэл, сонгуульд нэр дэвшигчээс иргэн, сонгогч, гишүүн болон дэмжигчидтэй хийх хурал, уулзалт.

**4 дүгээр зүйл.Жагсаал, цуглааны үйл ажиллагаан дахь зарчим**

1

4.1.Тайван жагсаал, цуглаан хийх эрх болон тайван жагсаал, цуглаан хийх замаар үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, эвлэлдэн нэгдэх эрхээ эдлэх болон хууль сахиулах байгууллагаас олон нийтийн аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах ажиллагаанд Монгол Улсын Үндсэн хуульд зааснаас гадна дараах зарчмыг баримтална:

- 4.1.1.ялгаатай үзэл бодлыг хүлээн зөвшөөрөх;
- 4.1.2.үндэсний нэгдмэл байдлыг хангаж, харилцан итгэлцлийг дэмжих;
- 4.1.3.бусдын эрх, эрх чөлөө, нэр төр, алдар хүндийг хүндэтгэх;
- 4.1.4.хүчирхийллээс ангид байх;
- 4.1.5.эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлэх арга хэмжээ нь тухайн үйлдэл, нөхцөл, тухайн этгээдийн хувийн байдалд тохирсон байх;

4.1.6.мэдээлэл нээлттэй, ил тод байх.

4.2.Тайван жагсаал, цуглаанд тавих аливаа хязгаарлалт нь хүний эрхийн олон улсын хэм хэмжээнд нийцсэн байна.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ**  
**ТАЙВАН ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЭРХИЙН БАТАЛГАА**

**5 дугаар зүйл.Тайван жагсаал, цуглаан түүнийг зохион байгуулах, оролцох эрх**

5.1.Иргэд тодорхой асуудлаар үзэл бодлоо олон нийт, төрийн байгууллагад хүргэх зорилгоор нийтийн эзэмшил болон хувийн өмчлөлийн газарт тайван жагсаал, цуглаан /цаашид "жагсаал, цуглаан" гэх/ хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулах, түүнд оролцох эрхтэй.

5.2.Хоёр, түүнээс дээш хүн ижил зорилгоор үзэл бодлоо илэрхийлж нийтийн эзэмшил болон хувийн өмчлөлийн газар түр хугацаагаар хуран цугларахыг цуглаан гэнэ.

5.3.Хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага цуглааныг жагсаал, суулт хийх, лаа, зул өргөх, индэр ажиллуулах, гарын үсэг цуглуулж хамтарсан өргөдөл гаргах, ганцаар болон хамтран өлсгөлөн зарлах болон хуулиар хориглоогүй бусад хэлбэрээр зохион байгуулж болно.

5.4.Цуглаан нь иргэд тодорхой үйл явдалд хариу үзүүлэх зорилгоор тухайн үйл явдал болсон даруй хуран цуглах байдлаар аяндаа үүсэж болох бөгөөд тус цуглааны үеэр нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага нь олон нийтийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

5.5.Хууль Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаанд оролцох эрхтэй.

2



Тайлбар: -энэ хуульд хэрэглэсэн "өлсгөлөн" гэдгийг тодорхой асуудлаар өөрийн үзэл бодлоо илэрхийлж нийтийн эзэмшлийн газар ганцаар болон хамтран өөрийн биед хоол тэжээлийг зориудаар хорьж, түүнийгээ зарлах үйл ажиллагааг ойлгоно.

**6 дугаар зүйл. Тайван жагсаал, цуглаан, түүнийг зохион байгуулах, оролцох эрхийн баталгаа**

6.1. Хүн, хуулийн этгээд иргэний жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох эрх чөлөөнд хүндэтгэлтэй хандаж, саад болохгүй байх үүрэгтэй.

6.2. Хууль тогтоомжийн дагуу жагсаал, цуглаан зохион байгуулсан, түүнд оролцсоны төлөө хэнийг ч мөрдөн мөшгих, эрх чөлөөг нь хязгаарлах, аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглоно.

6.3. Хуульд зааснаас бусад тохиолдолд жагсаал, цуглаан хийхэд зориуд саад учруулах, хууль тогтоомжийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааныг албадан тараахыг хориглоно.

6.4. Ижил асуудлаар, тухайн цаг хугацаанд өөр газарт, эсхүл өөр асуудлаар ижил газарт жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох эрхийг хязгаарлахгүй.

6.5. Тайван жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцохыг хязгаарласан агуулгатай захиргааны хэм хэмжээний акт баталж, мөрдүүлэхийг хориглоно.

6.6. Бусдыг жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцуулахын тулд эд мөнгөөр татах, эсхүл дарамт шахалт үзүүлэх хэлбэрээр албадахыг хориглоно.

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ЖАГСААЛ, ЦУГЛААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЯЗГААРЛАЛТ, ЗОХИОН  
БАЙГУУЛАГЧ, ОРОЛЦОГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ**

**7 дугаар зүйл. Жагсаал, цуглааныг зохион байгуулахыг хориглох газар, зорилго, агуулга**

7.1. Дараах газарт жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцохыг хориглоно:

- 7.1.1. Монгол Улсын хилийн бүс;
- 7.1.2. нисэх онгоцны буудал, төмөр замын өртөө, буудал
- 7.1.3. Төрийн ордон, түүний нутаг дэвсгэр;
- 7.1.4. хорих анги, түүний хамгаалалтын зурвас;
- 7.1.5. улсын онц чухал объект;
- 7.1.6. төрийн тусгай хамгаалалтад байгаа газар.

7.2. Дараах зорилго, агуулгаар жагсаал, цуглаан хийхийг хориглоно:

7.2.1. дайныг сурталчлах, ялгаварлан гадуурхах, хорлон сүйтгэх ажиллагаа явуулах, төрийн эрх мэдлийг хууль бус аргаар авахыг уриалах;

7.2.2. үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журамд хохирол учруулж эмх замбараагүй байдал бий болгох.

7.3. Хуулиар хориглосноос бусад зорилгоор зохион байгуулсан, эсхүл зохион байгуулагдсан жагсаал, цуглааны явцад энэ хуулийн 7.2-т заасан зорилго, агуулгатай нөхцөл байдал бий болсон бол тухайн жагсаал, цуглааныг үргэлжлүүлэхийг хориглоно.

**8 дугаар зүйл. Жагсаал, цуглааны бүртгэл болон бусад хязгаарлалт**

8.1. Дараах газарт жагсаал, цуглаан зохион байгуулах тохиолдолд урьдчилан бүртгүүлнэ:

8.1.1. авто замын зорчих хэсэг, гүүр;

8.1.2. түүх соёлын дурсгалт зүйл бүхий байгууллага.

8.2. Хүн, хуулийн этгээд, хуулийн этгээдийн эрхгүй байгууллага энэ хуулийн 7.1, 8.1-д зааснаас бусад газарт жагсаал, цуглааныг зохион байгуулах эрхтэй бөгөөд жагсаал, цуглааны үеэр тухайн байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулахад чиглэсэн аливаа үйлдэл хийхийг хориглоно.

8.3. Улс орны буюу тодорхой нутаг дэвсгэрийн хэмжээнд онц болон дайны байдал зарласан, гамшиг, аюулт үзэгдэл, осол тохиолдсон бол тухайн нутаг дэвсгэрт уг шалтгаан арилах хүртэлх хугацаанд жагсаал, цуглааныг зохион байгуулахыг хуулиар хориглоно.

8.4. Олон нийтийн газар өлсгөлөн зарлахыг хөндлөнгөөс албадахыг хориглоно.

8.5. Сэтгэцийн өвчтэй хүн, хуульд заасан бол төрийн тусгай алба хаагч жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцоход хязгаарлаж болно.

8.6. Жагсаал, цуглааныг шөнийн цагаар зохион байгуулахыг хориглоно.

Тайлбар: Энэ зүйлийн 8.6-д заасан "шөнийн цаг" гэдгийг Хөдөлмөрийн тухай хуулийн 88.1-д зааснаар ойлгоно.

**9 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох үйл ажиллагаа**

9.1. Монгол Улсын иргэн жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох эрхтэй бөгөөд энэхүү эрхийг хуульд зааснаас бусад тохиолдолд хязгаарлахыг хориглоно.

9.2. Энэ хуулийн 8.1-д зааснаас бусад газарт жагсаал, цуглааныг зохион байгуулах бол орон нутагт 48 цаг, нийслэлд 24 цагаас доошгүй хугацааны өмнө нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад мэдэгдэл хүргүүлж зохион байгуулна.



9.3.Өлсгөлөн, суулт хийх хэлбэрээр олон нийтийн газар үзэл бодлоо илэрхийлэх болон энэ хуулийн 5.4-т заасан тохиолдолд энэ хуулийн 9.2 дахь хэсэг хамаарахгүй.

9.4.Энэ хуулийн 9.2-т заасан мэдэгдэлд цуглаан зохион байгуулах зорилго, эхлэх, дуусах хугацаа, оролцогчдын баримжаа тоо, хэрэглэх техник хэрэгсэл, цуглах, жагсан явах гудамж, олон нийтийн газар, зохион байгуулагчийн нэр, хаяг, холбоо барих хэрэгслийн дугаар зэрэг мэдээллийг тодорхой тусгана.

9.5.Жагсаал, цуглаан зохион байгуулах мэдэгдлийг энэ хуулийн 9.2-т заасан байгууллагын эрх бүхий ажилтан хүлээн авснаар хүргүүлсэнд тооцно.

9.6.Энэ хуулийн 9.2-т заасан мэдэгдлийг хүлээн авсан цагдаагийн байгууллага тухайн жагсаал, цуглаан зохион байгуулагч, түүнд оролцогчдын олон нийтийн газар үзэл бодол илэрхийлэх эрхийг хангах, тухайн нутаг дэвсгэр дэх замын хөдөлгөөнийг зохицуулах, олон нийтийн аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангахад шаардлагатай бэлтгэл ажлыг хангах үүрэгтэй.

9.7.Цагдаагийн байгууллага жагсаал, цуглаан зохион байгуулах мэдэгдлийг хүлээн авч зохион байгуулагчаас шаардлагатай мэдээллийг тодруулж болох бөгөөд харилцан тохиролцсоны үндсэн дээр зохион байгуулах газар, хугацаа зэрэгт өөрчлөлт оруулж болно.

9.8.Жагсаал, цуглаан зохион байгуулагч нь мэдэгдэл хүргүүлснээс зохион байгуулах хүртэлх хугацаанд хэдийд ч жагсаал цуглаан зохион байгуулахыг цуцалж болох бөгөөд энэ тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

9.9.Энэ хуулийн 8.1-д заасан газарт жагсаал, цуглааныг зохион байгуулах бол энэ хуулийн 9.2-т заасан байгууллагад бичгээр 48 цагаас доошгүй хугацааны өмнө мэдэгдэл хүргүүлж, бүртгүүлсний үндсэн дээр зохион байгуулна.

9.10.Цагдаагийн байгууллага энэ хуулийн 8.1-д заасан мэдэгдлийг хүлээн авч ажлын 1 өдрийн дотор бүртгэсэн эсэх талаар хариу өгнө.

9.11.Цагдаагийн байгууллага жагсаал, цуглаан зохион байгуулагдах талаарх мэдээллийг тухайн нутаг дэвсгэрт байрлах оршин суугч, байгууллагад боломжит хэлбэрээр урьдчилан мэдээлнэ.

Тайлбар: -энэ хуульд заасан "нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага" гэдгийг орон нутагт аймгийн цагдаагийн газар, нийслэлд Нийслэлийн цагдаагийн удирдах газрыг ойлгоно.

**10 дугаар зүйл. Жагсаал, цуглааныг зохион байгуулагч,  
оролцогчийн үүрэг**

10.1.Жагсаал, цуглаан зохион байгуулахад уг арга хэмжээний үед энэ хуулийн 10.1.3-т заасныг хэрэгжүүлэх үүрэг бүхий зохион байгуулагч хүнийг албан ёсоор томилно.

10.2.Жагсаал, цуглааныг санаачилсан, мэдэгдлийг баталгаажуулсан этгээдийг зохион байгуулагч гэж үзнэ. Санаачилсан этгээд нь зохион байгуулагч байж болно.

10.3.Зохион байгуулагч жагсаал, цуглаан зохион байгуулагдахаас өмнө дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

10.3.1.жагсаал, цуглаан зохион байгуулах үеийн хууль зүй, аюулгүй байдлын зөвлөмжтэй танилцах;

10.3.2.оролцогчдод энэ хуулийн 10.4-т заасан шаардлагыг урьдчилан анхааруулах;

10.3.3.энэ хуулийн 10.3.2-т заасан нөхцөл байдал хангагдаагүй тохиолдолд цагдаагийн байгууллагад даруй мэдэгдэж шаардлагатай арга хэмжээ авах саналыг хүргүүлэх.

10.4.Жагсаал, цуглаанд оролцогч дараах үүрэг хүлээнэ:

10.4.1.жагсаал, цуглаан хийх газарт нийгмийн хэв журам, иргэдийн аюулгүй байдлыг хангах;

10.4.2.нийтийн эзэмшлийн газар, бусдын эд хөрөнгөд хохирол учруулахгүй байх;

10.4.3.зэвсэг хэрэгсэл, химийн хорт болон аюултай бодис, тэсэрч дэлбэрэх бодис, орчиндоо аюул учруулж болох амьтныг авч явахгүй байх;

10.4.4.жагсаал, цуглааны явцад аливаа хэлбэрээр хүч хэрэглэхгүй байх, бусдын нэр төр, алдар хүндийг хүндэтгэх, төр, байгууллага, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байх;

10.4.5.согтууруулах, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхгүй байх;

10.4.6.тухайн жагсаал, цуглаан зохион байгуулах зорилгод шууд хамааралтайгаас бусад тохиолдолд бага насны хүүхдийг оролцуулахгүй байх;

10.4.7.жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татах, айлган сүрдүүлэх, шахалт дарамт үзүүлэх болон бусад хэлбэрээр албадахгүй байх;

10.4.8.замын хөдөлгөөнд саад учруулахгүй байх;  
10.4.9.жагсаал, цуглааны үед нисэгчгүй төхөөрөмж буюу дрон, бусад эд хэрэгсэл ашиглах бол цагдаагийн байгууллагаас зөвшөөрөл авах;

10.4.10.нүүрээ халхалсан баг өмсөхгүй байх.

Тайлбар: - Энэ зүйлд заасан "эд хэрэгсэл" гэдгийг гэр, майхан, тээврийн хэрэгсэл, цахилгаан үүсгүүр зэргийг ойлгоно.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ОРОЛЦОГЧИЙН АЮУЛГҮЙ  
БАЙДЛЫГ ХАНГАХ, ДЭГ ЖУРМЫГ ХАНГУУЛАХ**

**11 дүгээр зүйл. Жагсаал, цуглаан, түүнд оролцогчдыг хамгаалах**

11.1. Цагдаагийн байгууллага нь энэ хуульд заасан журмын дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглааны үед зохион байгуулагч, оролцогч иргэдийн аюулгүй байдлыг хангах үүрэгтэй.

11.2. Аяндаа үүссэн жагсаал, цуглааныг эрх бүхий байгууллагад мэдэгдсэн эсэх, зохион байгуулагчтай эсэхээс үл хамааран оролцогчдын аюулгүй байдлыг хангана.

11.3. Цагдаагийн байгууллагаас иргэдийн үзэл бодлоо илэрхийлж байгаа газар нь тухайн асуудлыг хүргэхээр зорьсон этгээдэд харагдахуйц, эсхүл сонсогдохуйц байдлыг алдагдуулахад чиглэсэн үйлдэл гаргахгүй байна.

11.4. Цагдаагийн албан хаагч нь жагсаал, цуглаанд оролцогчдын талаар мэдээлэлтэй байх, оролцогчдын ялгаатай байдлыг мэдэрч түүнд тохирсон арга хэмжээ авах, жагсаал цуглаан зохион байгуулагч, оролцогчидтой идэвхтэй харилцаатай байна.

11.5. Цагдаагийн байгууллага олон хүн цугларах үеийн төлөвлөгөөг батлах бөгөөд уг төлөвлөгөөнд жагсаал, цуглаанд хүүхэд, хөдөлгөөний бэрхшээлтэй иргэд, ахмад настан зэрэг эмзэг бүлгийн иргэдийн аюулгүй байдлыг хангах тухайлсан арга хэмжээг тусгасан байна.

11.6. Тухайн нутаг дэвсгэрийн эрүүл мэндийн байгууллага нь зохих журмын өлсгөлөн зарласан этгээдийн эрүүл мэндийн байдалд үзлэг шинжилгээ хийж, дүгнэлт гарган нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.

11.7. Өлсгөлөн зарласан үед тухайн нутаг дэвсгэрийн Эрүүл мэндийн газрын даргын шийдвэрээр баталсан хуваарийн дагуу төрөлжсөн мэргэжлийн эмч, сувилагчдыг баг бүрдүүлэн өлсгөлөн зарласан этгээдийг эрүүл мэндэд үзлэг хийж, хяналт тавьж ажиллана.

11.8. Өлсгөлөн зарласан этгээдийн амь нас, эрүүл мэндэд ноцтой аюул учрахаар байдалд орсон тохиолдолд өлсгөлөнг зогсоож албадан эмчилгээнд оруулах арга хэмжээ авна.

11.9. Өлсгөлөн зарлахад харшлах өвчний жагсаалтыг эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

**13 дугаар зүйл. Жагсаал, цуглааныг албадан тараах**

13.1. Цагдаагийн байгууллага нь жагсаал, цуглаан зохион байгуулагдах үеэр энэ хуульд заасан аюул занал гарцаагүй бий болсон тохиолдолд албадан тараах шийдвэрийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын дарга гаргана.

13.2. Жагсаал, цуглааны явцад энэ хуулийн 7.2-т заасан нөхцөл байдал үүссэн, эсхүл түүнд хүргэх эрсдэлтэй хүчин зүйл, нөхцөл бүрдэж, ийнхүү нөхцөл бүрдсэнийг үндэсний аюулгүй байдлыг хангах болон хууль сахиулах байгууллага мэдээлэл, баримтаар баталсан тохиолдолд жагсаал, цуглааныг албадан тараах нөхцөл үүссэнийг гарцаагүй байдал бий болсонд тооцно.

13.3. Хуулиар хориглосон газар, зорилгоор зохион байгуулагдсан, эсхүл хориглоогүй жагсаал, цуглааны явцад хориглосон нөхцөл байдал бий болсон бол албадан тараах үндэслэл болно.

13.4. Албадан тараах шийдвэрийг жагсаал, цуглаан, түүнд оролцогчдоод боломжит хэлбэрээр урьдчилж сануулна.

13.5. Чанга яригчаар сонсогдохуйц тодорхой хугацаа өгч хоёроос дээш удаа сануулсны дараа албадан тараана.

13.6. Эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй хүн, хүүхэд, ахмад настан зэрэг хүмүүстэй тухайн этгээдийн онцлогт тохирсон харилцаа үүсгэнэ.

13.7. Жагсаал, цуглааныг албадан тараахад цагдаагийн байгууллагын хүч, хэрэгсэл хүрэлцэхгүй бол Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэгтэй бусад байгууллагыг татан оролцуулж болно.

13.8. Албадан тараах ажиллагааны явцыг дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэг ашиглан баримтжуулна.

13.9. Цагдаагийн байгууллагаас жагсаал, цуглааныг албадан тараасан тохиолдолд тухайн арга хэмжээг хэрэгжүүлснээс хойш ажлын хоёр өдрийн дотор олон нийтэд мэдээлнэ.

**14 дүгээр зүйл. Жагсаал, цуглааны үйл явц нээлттэй ил тод байх,  
гомдол гаргах**

14.1. Жагсаал, цуглаан зохион байгуулагдах үйл явцыг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, хэвлэл мэдээллийн байгууллагаас олон нийтэд мэдээлэх, сурвалжлах эрхийг хязгаарлахгүй.

14.2. Иргэн жагсаал, цуглаан хийх журамтай холбоотой гомдол, мэдээллээ төрийн эрх бүхий байгууллага, албан тушаалтан, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комисс, шүүхэд гаргах эрхтэй.

**15 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

15.1. Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

15.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ДАЙНЫ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Дайны байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2.1 дэх заалтын "зохих байгууллагын зөвшөөрөлгүйгээр хурал, цуглаан, жагсаал," гэснийг "эрх бүхий этгээдэд мэдэгдээгүй жагсаал, цуглаан," гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 1994 оны 07 дугаар сарын 07-ны өдөр баталсан Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ДОТООДЫН ЦЭРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Дотоод цэргийн тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2.6 дахь заалтын "хүч хэрэглэсэн жагсаал, цуглааныг" гэснийг "хууль бус жагсаал, цуглааныг" гэж өөрчилсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зөрчлийн тухай хуулийн 5.8 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"5.8 дугаар зүйл. Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай  
хууль зөрчих

1. Хуулиар хориглосон жагсаал, цуглаан зохион байгуулсан, эсхүл жагсаал, цуглааны явцад түүний зорилгыг өөрчилж хориглосон жагсаал, цуглаан зохион байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Хуульд заасан журмын дагуу тайван жагсаал, цуглаан зохион байгуулахад санаатайгаар саад учруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Гудамж, талбайд өлсгөлөн зарлахыг хөндлөнгөөс зориуд зохион байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Согтууруулах ундаа хэрэглэсэн, эсхүл сэтгэцийн эмгэгтэй хүнийг жагсаал, цуглаанд оролцуулсан, эсхүл жагсаал, цуглаанд оролцуулахын тулд бусдыг эд мөнгөөр татсан, эсхүл дарамт шахалт үзүүлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Жагсаал цуглааныг зохион байгуулагч, оролцогч зэвсэг, хорт бодис, тэсэрч дэлбэрэх бодис, орчин тойрон, хүний амь нас, эрүүл мэндэд аюул учруулж болохуйц аливаа зүйл, амьтан авч явсан бол зөрчил үйлдэхэд ашигласан зэвсэг, хэрэгслийг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй

тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно."

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ХИЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын хилийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.12 дахь хэсгийн "Хилийн боомтод" гэснийг "Хилийн бүсэд" гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1.14 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2024 оны...дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 2.2 дугаар зүйлд доор дурдсан агуулга бүхий 8, 9 дэх хэсэг нэмсүгэй:

"8.Зөрчил шалган шийдвэрлэх, хяналт тавих байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах, харилцан мэдээлэл солилцох зорилго бүхий зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн сантай байна.

9.Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд мэдээлэл нийлүүлэх, солилцох, ашиглах, мэдээлэлтэй танилцах журмыг энэ хуульд нийцүүлэн Улсын ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална."

**2 дугаар зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.8 дахь заалтын "15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг," гэсний дараа "15.4 дүгээр зүйл," гэж, 6.8 дахь заалтын "5.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг," гэсний дараа "15.4," гэж, 6.11 дэх заалтын "7.14 дүгээр зүйлийн 2.1, 3.2 дахь хэсэг," гэсний дараа "7.18 дугаар зүйлийн 2.2 дахь заалт," гэж, 6.12 дахь заалтын "...," гэсний дараа "7.18 дугаар зүйлийн 4.1,4.2 дахь заалт," гэж, 6.13 дахь заалтын "15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг," гэсний дараа "15.4," гэж, мөн заалтын "15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг," гэсний дараа "15.29 дүгээр зүйл" гэж, 6.13 дахь заалтын "Зөрчлийн тухай хуулийн" гэсний дараа "11.2 дугаар зүйл," гэж, 6.17 дахь заалтын "7.9 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг," гэсний дараа "11.2 дугаар зүйл," гэж, 6.18 дахь заалтын "10.11," гэсний дараа "11.2," гэж, 6.19 дэх заалтын "11.35 дугаар зүйл," гэсний дараа "15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг" гэж, 6.21 дэх заалтын "9.10 дугаар зүйлийн 3 дахь," хэсэг гэсний дараа "11.2 дугаар зүйл," гэж, 6.22 дахь заалтын "9.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг," гэсний дараа "1.30" гэж, 6.25 дэх заалтын "Зөрчлийн тухай хуулийн" гэсний дараа "11.2" гэж, 6.48 дахь заалтын "7.8 дугаар зүйл," гэсний дараа "7.18 дугаар зүйлийн 2. 3 дахь хэсэг, 4.3 дахь заалт" гэж, 6.55 дахь заалтын "Зөрчлийн тухай хуулийн" гэсний дараа "11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг" 9.1 дүгээр зүйлийн "6.26 дугаар зүйл," гэсний дараа "7.18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг," гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

**1/6.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

"3.Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан шийдвэр гаргасан даруй зөрчлийн бүртгэл, мэдээллийн системд бүртгэнэ."

**2/6.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

"1.Зөрчлийн талаарх гомдол, мэдээлэл тухайн байгууллагын харьяаллын бус болох нь тогтоогдвол энэ хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасан хугацаанд багтаан харьяаллын дагуу шилжүүлж, зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд даруй бүртгүүлнэ."

**3/6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

1.Энэ хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан нөхцөл байдал тогтоогдвол хүн, хуулийн этгээд, албан тушаалтнаас ирүүлсэн гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзаж, зөрчлийн бүртгэл, мэдээллийн системд даруй бүртгэж, шийдвэрийг гомдол, мэдээлэл гаргагчид мэдэгдэнэ."

**4/6.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

"5.Эрх бүхий албан тушаалтан хялбаршуулсан журмаар зөрчил шалган шийдвэрлэсэн даруй зөрчлийн бүртгэл, мэдээллийн системд бүртгэнэ."

**5/6.6 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:**

"7.Прокурор эрх бүхий албан тушаалтны зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэлтэй гэж үзвэл энэ хуулийн 7.7 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу дүгнэлт бичиж шүүхэд хүргүүлнэ."

**6/6.10 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

"2.Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэр гаргасан даруй зөрчлийн бүртгэл, мэдээллийн системд бүртгэнэ."

**7/7.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

"1.Зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах шийдвэр нь шийтгэлийн хуудас хэлбэртэй байна. Шийтгэлийн хуудас нь цахим хэлбэртэй байж болно."

**8/9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

"1.Эрх бүхий алба хаагч Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.26 дугаар зүйл, 7.18, 8.6, 8.7 дугаар зүйл, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 15.33 дугаар зүйл, 17.1 дүгээр зүйлийн 7, 16 дахь хэсэг, 18.1, 18.2, 18.4 дэх заалт, 23 дахь хэсэгт заасан зөрчлийг

шалгахад энэ хуульд заасан ердийн журмаас гадна энэ зүйлд заасан тусгай журмыг баримтлан хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулна."

**4 дүгээр зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.14 дэх заалтын "10.18 дугаар зүйл," гэснийг "10.18, 11.2 дугаар зүйл," гэж, 6.16 дахь заалтын "10.27 дугаар зүйл," гэснийг "10.27, 11.2 дугаар зүйл," гэж, 6.20 дахь заалтын "10.20 дугаар зүйл, 11.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг," гэснийг "10. 20, 11.2 дугаар зүйл," гэж, 6.22 дахь заалтын "11.1 дүгээр зүйл," гэснийг "11.1,11.2 дугаар зүйл," гэж, 6.26 дахь заалтын "10.23 дугаар зүйл," гэснийг "10.23, 11.2 дугаар зүйл," гэж, 6.37 дахь заалтын "7.16 дугаар зүйлийн 1,2 дахь хэсэг," гэснийг "7.16 дугаар зүйлийн 1 дэх хэсэг," гэж, мөн заалтын "7.17," гэснийг "7.17 дугаар зүйл, 7.18 дахь хэсгийн 2. 3 дахь хэсэг, 4.3 дахь заалт," гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн "7.18 дугаар зүйл," гэснийг "7.18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг," гэж, 6.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, 6.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "прокурорын нэгдсэн бүртгэлд" гэснийг "зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн санд" гэж, мөн зүйлийн "6.7 дахь хэсгийн 5.18 дугаар зүйл, гэснийг "5.18, 11.2 дугаар зүйл," гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 10 дахь хэсэг, 1.8 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн 6.11 дэх заалтын "6.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг," гэснийг,16.13, 6.27 дахь заалтын "7.16 дугаар зүйлийн 2 дахь хэсэг," гэснийг, 6.43 дахь заалтын "13.4 дүгээр зүйлийн 3,5 дахь хэсэг," гэснийг, 6.55, 6.58, 6.60 дахь заалтын "10.14, 10.29," гэснийг, 2.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "6.13," гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг 2017 оны 5 дугаар сарын 18-ны өдөр баталж, 2017 оны 7 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн хүчин төгөлдөр үйлчилж байна.

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны 2019 оны "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" 07 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах, төрийн үйл ажиллагаан дахь цахим шилжилтийг дэмжих, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг цахим хэлбэрээр явуулж болох нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор "Зөрчлийн бүртгэл, хяналтын нэгдсэн систем"-ийг үйл ажиллагааны эрх зүйн орчинг бий болгохоор тусгалаа.

2022 онд "Зөрчлийн бүртгэл, мэдээллийн нэгдсэн систем"-ийн туршилтын ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 02-ны өдрөөс эхлүүлж, 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс албан ёсоор ашиглалтад оруулж, хэрэглээнд нэвтрүүлэхийг талаар Засгийн газрын хуралдааны тэмдэглэл гарч хэрэгжиж эхлээд байна.

Үүнтэй холбогдуулан зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны шуурхай байдлыг хангах, цахимын багц хуулийг хэрэгжилтийг дэмжих хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч болон шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтнуудад бий болдог хүндрэл, чирэгдлийг багасгах, цахим үйл ажиллагааг нэвтрүүлэх, цахим хэлбэрээр зөрчлийн хэргийг бүртгэх, дугаар олгох, шалгах, хянан шийдвэрлэх талаар зохицуулалт тусгалаа. Энэ нь тухайн зөрчлийг орон зайнаас үл хамааран, шуурхай, зөрчил шалгах бүхий л зардлыг хэмнэсэн, цар тахлын нөхцөл байдлаас үл хамааран хууль хэрэгжих нөхцөл боломжийг бүрдүүлсэн.

Түүнчлэн шийтгэл оногдуулсан шийдвэр, шийтгэлээс чөлөөлөх шийдвэрийн хуудсыг цахим хэлбэрээр хүргүүлж, оногдуулж байх зэрэг хууль зүйн үндэслэлүүд, хуулийг хэрэглэдэг болон хэрэгжүүлж ажилладаг эрх бүхий байгууллагуудаас ирүүлсэн санал, практик шаардлагын дагуу зарим төрлийн хэргийн харьяалалд бий болсон алдааг засахаар боловсрууллаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2024 оны ... дугаар  
сарын ... өдөр

Улаанбаатар  
хот

**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ  
КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн тухай 13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"13.4.Комиссын даргыг гишүүд дотроосоо олонхын саналаар сонгож санал болгосноор зургаан жилийн хугацаагаар Улсын Их Хурал нэг удаа томилно."

**2 дугаар зүйл.**Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.6 дахь хэсгийн "нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа" гэснийг "олонхын саналаар нууц санал хураалтаар" гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийн 13.4-т заасныг хүчин төгөлдөр хуулийн дагуу томилогдсон даргын бүрэн эрхийн хугацаа дуусгавар болж, комиссын дараагийн даргыг томилох үйл ажиллагаанаас эхлэн дагаж мөрдөнө.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийн 2024 оны ... сарын ... өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын  
тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

Комиссын гишүүд даргаа өөрсдөө дотроосоо сонгох нь Комиссын хараат бус, бие даасан байдал бэхжих ач холбогдолтой. Иймд одоо үйлчилж байгаа Улсын Их Хурлын даргын санал болгосны дагуу Улсын Их Хурлаас томилж байгаа одоогийн зохицуулалтыг халж, Комиссын даргыг гишүүд дотроосоо олонхын саналаар сонгож Улсын Их Хуралд санал болгох зохицуулалтыг бий болгох, харин энэ нь одоогийн томилогдсон даргын бүрэн эрхийн хугацаанд хамааралгүй бөгөөд Комиссын дараагийн даргыг томилох үйл ажиллагаанаас эхлэн дагаж мөрдөхөөр тусгалаа.

Түүнчлэн Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсэгт "Комиссын Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүн "Хүний эрх хамгаалагчийн хороо"-ны дарга байх бөгөөд Хорооны үйл ажиллагааг нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж ажиллана" гэж, 13.6 дахь хэсэгт "Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнийг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүд дотроосоо нэг жилийн хугацаагаар олонхын саналаар нууц санал хураалтаар зөвхөн нэг удаа сонгоно" гэж тус тус заажээ. Гэтэл Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт Комиссын гишүүнд нэр дэвшигч нь хууль зүйн өндөр мэргэшилтэй, хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилласан туршлагатай, 35 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх ерөнхий шаардлагыг хангасан байхаар тусгасан.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэгт "Ашгийн төлөө бус хуулийн этгээдийн төлөөллөөс Хорооны гишүүнд хүний эрхийг хамгаалах чиглэлээр үндэсний, эсхүл олон улсын хэмжээнд долоогоос доошгүй жил ажилласан туршлагатай, хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоо, эрх зүйн хэм хэмжээний талаар мэдлэг, туршлагатай, сүүлийн таван жил улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй байх шаардлагыг хангах, мөн хорооны гишүүнийг гурван жилийн хугацаагаар зөвхөн нэг удаа сонгохоор заасан. Ийнхүү Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэд хүний эрх хамгаалагчийн эрх зөрчигдсөн эсэх талаар дүгнэлт гаргах чиг үүрэг бүхий орон тооны бус Хүний эрх хамгаалагчийн хорооны дарга, гишүүнд тавигдах шаардлагыг эрхэлсэн ажил, албан тушаал, мэдлэг туршлага, цаг хугацаагаар нь ялгамжтайгаар заасан байна.

Хүний эрх хамгаалагчийн асуудал эрхэлсэн гишүүнийг тогтвортой ажиллуулах шаардлагаар хуульд заасан нэг жилээр ажиллах, нэг удаа сонгогдох зохицуулалтыг хасахаар тусгалаа.

**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ**

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД. НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### “14 дүгээр зүйл. Албаны нууцад хамаарах мэдээлэл

14.1. Албаны нууцад дараах шаардлагыг хангасан мэдээллийг хамааруулна:

14.1.1. тухайн мэдээлэл нь үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүний эрх, эрх чөлөө, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн байх;

14.1.2. тухайн мэдээллийг ил тод, нээлттэй болгох, бусдад дамжуулах, өгөх нь хуулиар хамгаалсан ашиг сонирхолд хохирол учрахыг тогтоосон байх;

14.1.3. энэ хуулийн 14.1.2-т заасан учрах хохирол нь олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлоос давахааргүй байх.

14.2. Энэ хуулийн 14.1-д заасан үндэслэлээр албаны нууцад хамааруулсан хэдий ч тухайн мэдээлэл нь төрийн байгууллага, бусад хуулийн этгээд, албан тушаалтны хууль бус үйлдлийг нуух зорилготой мэдээллийг албаны нууцад хамааруулахыг хориглоно.

14.3. Тухайн байгууллага албаны нууцад хамаарах мэдээллийг энэ хуульд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулж, Тагнуулын байгууллагын дарга батална.

14.4. Тухайн байгууллага нь албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ил болгох мэдээлэл байгаа эсэхэд багтаан дүн шинжилгээг жил бүрийн эхний улиралд хийнэ.

14.4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хязгаарлалттай мэдээллийг өгөхөөс татгалзсан бол татгалзсан үндэслэлээ тухайн байгууллага тайлбарлах үүрэгтэй.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

1

Е

## ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.8-д “Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана.” гэж, мөн 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.3 дахь заалтын 1 дүгээр үе шат(2021-2030)-ны гэж тус тус заасан байна.

Түүнчлэн Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.4.1-д “Хуулиар хориглоогүй мэдээллийг чөлөөтэй хайх, олж авах, үүсгэх, дамжуулах, түгээх эрх, эрх чөлөөг хангах, мэдээллийн дэд бүтэц, түүний бүрдэл хэсэг, үйлчилгээнд чөлөөтэй хандах боломжийг бүрдүүлснээр мэдээллийн хүртээмжтэй байдал хангагдана.” гэж заасан.

2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр батлагдсан, 2022 оны 5 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөх Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд зааснаар хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй байхаар заасан.

Гэвч төрийн байгууллага, албан тушаалтнууд хуульд ил тод, нээлттэй байхаар заагаагүй бөгөөд нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг “албаны нууц”-д хамааруулан тогтоох боломжтой байгаа албаны нууцын талаарх эрх зүйн зохицуулалт буюу Төрийн болон албаны нууцын тухай хууль дахь зохицуулалт нь иргэний Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон мэдээлэл авах эрхийг хөндөхөд хүрч байна гэсэн шүүмж гарсаар байна.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасан, иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх зорилгоор хуульд ил тод, нээлттэй байхаар заагаагүй бөгөөд нууцад хамааруулах шаардлагагүй мэдээллийг албаны нууцад хамааруулахгүй байх, үүний тулд албаны нууцад хамааруулах мэдээллийн шалгуур үзүүлэлтийг нарийвчлан тусгалаа.

Албаны мэдээллийг тухайн байгууллагын дарга баталж байгааг өөрчилж, тагнуулын байгууллагын дарга баталдаг байхаар тусгав.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

2

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГЭР БҮЛИЙН ХҮЧИРХИЙЛЭЛТЭЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

#### 1/23 дугаар зүйлийн 23.8 дахь хэсэг:

"23.8. Гэр бүлийн хүчирхийллийн талаархи статистик мэдээлэл, тоо бүртгэл хөтөлж, мэдээллийн сан бүрдүүлэх, хууль сахиулах чиг үүргийг хэрэгжүүлэх болон холбогдох бусад байгууллага хоорондын мэдээлэл солилцох ажиллагааг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилсан сэргийлэх тухай хуулиар зохицуулна."

#### 2/44<sup>1</sup> дүгээр зүйл:

#### "44<sup>1</sup>. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах

44<sup>1</sup>.1. Цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч, прокурор нь гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй гомдол, мэдээлэл шалгах, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт болон зөрчлийн хэрэг бүртгэлийн явцад хохирогчийн аюулгүй байдлыг хангаж ажиллана.

44<sup>1</sup>.2. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг цагдаагийн байгууллагын хохирогчийг хамгаалах чиг үүрэг бүхий нэгж хариуцан хэрэгжүүлнэ.

44<sup>1</sup>.3. Цагдаагийн байгууллага нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг энэ хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан журмын дагуу хэрэгжүүлнэ.

44<sup>1</sup>.4. Прокурор нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах ажиллагааг хуульд заасан журмын дагуу хийгдсэн эсэхэд хяналт тавьж, илэрсэн зөрчлийг арилгуулахаар шаардлага хүргүүлэх, хуульд заасан тодорхой ажиллагаа гүйцэтгүүлэхээр даалгавар өгч, хохирогч түүний хууль ёсны төлөөлөгчөөс гаргасан гомдол, хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ."

**2 дугаар зүйл.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль," гэсний дараа "Гэрч, хохирогчийг хамгаалах тухай," гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

#### 1/19 дүгээр зүйлийн 19.1.8 дахь заалт:

"19.1.8. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд иргэд, олон нийтийг татан оролцуулах, энэ чиглэлээр идэвх санаачилгатай ажиллаж байгаа этгээд, хамт олон, аж ахуйн нэгж, байгууллагыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 34.3 дахь хэсэгт заасан журмын дагуу урамшуулах."

#### 2/30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэг:

"30.2. Хүчирхийлэлд өртсөн хүүхдийг түр байрлуулан хамгаалах үйлчилгээг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар зохицуулна."

#### 3/31 дүгээр зүйл:

#### "31 дүгээр зүйл. Аюулын зэргийн үнэлгээ

31.1. Цагдаагийн алба хаагч гэр бүлийн хүчирхийллийн дуудлага, гомдол, мэдээллийн тохиолдол бүрт хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдалд учирсан, эсхүл учирч болох эрсдэлд аюулын зэргийн үнэлгээ хийнэ.

31.2. Цагдаагийн алба хаагч аюулын зэргийн үнэлгээг гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдсэн, үйлдэгдсэн байж болзошгүй, эсхүл хохирогчийн байгаа газарт очиж хийнэ.

31.3. Аюулын зэргийн үнэлгээ хийх аргачлал, тэмдэглэлийн загварыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

31.4. Аюулын зэргийн тогтоохдоо хохирогчийн амь нас, эрүүл мэндэд учирсан хохирол, учирч болзошгүй эрсдэл, хүчирхийлэл үйлдэгчийн хувийн байдал болон орчны эрсдэлийг үнэлнэ.

31.5. Аюулын зэргийн үнэлгээ нь хохирогч түүний гэр бүлийн гишүүдэд энэ хуулийн 34.1-т заасан хамгаалалтын үйлчилгээг үзүүлэхэд харгалзах нөхцөл болно.

31.6. Аюулын зэргийн үнэлгээг хохирогчтой харилцан ярилцах хэлбэрээр хийж, аюулын эрсдэлийг бага, дунд, өндөр гэж дүгнэнэ.

31.7. Аюулын зэргийн үнэлгээ хийхэд хохирогчийг буруутгах, нэг талыг баримтлах, тулгах, хөтлөх байдлаар асуух, айдас түгшүүр түрүүлэх, загнахыг хориглоно.

31.8. Монгол хэл, бичиг мэдэхгүй, эсхүл хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хохирогчид орчуулагч, хэлмэрчийн тусламжтайгаар аюулын зэргийн үнэлгээг хийнэ.

31.9. Хүүхдэд учирсан аюулын зэргийн үнэлгээг хийхдээ эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл багш, нийгмийн ажилтан, хүүхдийн эрхийн ажилтан, сэтгэл зүйчийг байлцуулна.

31.10.Хүүхэд гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн гэж үзэх нөхцөл байдал тогтоогдвол энэ хуульд заасан тусламж, үйлчилгээг Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан тусламж үйлчилгээтэй уялдуулж зохион байгуулна.

31.11.Аюулын зэргийн үнэлгээг нотлох баримтаар тооцох, үнэлэх эсэхийг эрх бүхий албан тушаалтан холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэнэ."

**4/35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг:**

"35.1.Хохирогчийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах зорилгоор түүнд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7.1.6-д заасан үйлчилгээг үзүүлнэ."

**5/35 дугаар зүйлийн 35.10 дахь хэсэг:**

"35.10.Түр байрлуулан хамгаалах үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар зохицуулна."

**6/36 дугаар зүйл:**

**"36 дугаар зүйл.Нэг цэгийн үйлчилгээ**

36.1.Энэ хуулийн 33.1-д заасан үйлчилгээг нутаг дэвсгэрийн харьяалал харгалзахгүй 24 цагийн турш нэг цэгээс үзүүлэх чиг үүрэг бүхий нэг цэгийн үйлчилгээний төвийг эмнэлэгийн байгууллагын дэргэд ажиллуулна.

36.2.Нэг цэгийн үйлчилгээний төв энэ хуулийн 33.1 дэх хэсэгт заасан үйлчилгээг холбогдох байгууллагатай хамтран үзүүлнэ.

36.3.Нэг цэгийн үйлчилгээний төвийн болон үйлчилгээний стандартыг стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

36.4.Нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх зардлыг энэ хуулийн 35.4-т заасны дагуу тооцож, улсын төсвөөс санхүүжүүлнэ.

36.5.Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдлыг цагдаагийн байгууллага дараах байдлаар хангана:

36.5.1.нэг цэгийн үйлчилгээний төвийг нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллага эргүүлийн хяналт хэрэгжүүл;

36.5.2.нэг цэгийн үйлчилгээний төвийн дотор болон гадна орчныг хамруулсан теле камерыг 24 цагийн хяналтад байлгах;

36.5.3.нэгийн үйлчилгээтэй холбоотой дуудлага, мэдээллийг шуурхай шалган шийдвэрлэх."

**7/39 дүгээр зүйлийн 39.3 дахь хэсэг:**

"39.3.Хохирогчид эрх зүйн туслалцаа үзүүлэхтэй холбогдсон харилцааг Хууль зүйн туслалцааны тухай хуулиар зохицуулна."

**8/44 дүгээр зүйлийн 44.3 дахь хэсэг:**

"44.3.Зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийг хууль зүйн, нийгмийн хамгааллын, боловсролын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална."

**9/44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсэг:**

"44.5.Зан үйлд нөлөөлөх албадан сургалтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 189.10-т заасан журмаар зохион байгуулна."

**4 дүгээр зүйл.**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай 5 дугаар зүйлийн 5.1.3 дахь заалтын "эмнэлэг, төрийн, төрийн бус" гэснийг "эмнэлгийн" гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийн "Эрүүгийн байцаан шийтгэх" гэснийг "Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай" гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.4 дэх заалт, 17 дугаар зүйлийн 17.2 дахь хэсэг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т "Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн." гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 114 дүгээр тогтоолоор хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй аливаа шалтгаан нөхцлийг судлан холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хийдэл, зөрчлийг арилгахыг Засгийн газарт үүрэг болгосон.

Түүнчлэн 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаас хуулиар тусгайлан эрх олгосон заалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг сайд нарт даалгасан. Иймд хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, хязгаарласан, харилцаанд оролцогчийн эрх, үүргийг тогтоосон буюу процессын шинжтэй зохицуулалт агуулсан, журмаар зохицуулсан харилцааг тухайн хуульд тусган боловсруулах шаардлага бий болсон.

2022 онд цагдаагийн байгууллагад 1729 энэ төрлийн гэмт хэрэг бүртгэгдснээс 1664 хүн хохирогчоор тогтоогдсон байна. Үүнээс 1468 нь эмэгтэй, 177 буюу 10.6 хувь нь хүүхэд өртсөн байна<sup>1</sup>. Гэр бүлийн хүчирхийллийн суурь шалтгаан нь эрх мэдлийн тэнцвэргүй, тэгш бус байдал, эрэгтэй эмэгтэй хүмүүсийн үүрэг хариуцлагын талаарх нийгэмд тогтсон хэвшмэл ойлголтоос үүдсэн байдаг тул хохирогч хамгааллын үйлчилгээний хүртээмж, чанарыг дээшлүүлэх шаардлагатай байдаг.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар хохирогчид тусламж үзүүлэх зориулалттай Нэг цэгийн үйлчилгээний төв болон түр хамгаалах байранд үзүүлэх үйлчилгээг ялгамжтай байлгах үүднээс Нэг цэгийн үйлчилгээний төвийг зөвхөн эмнэлгийн байгууллагын дэргэд ажиллуулахаар өөрчиллөө.

Хохирогчийг түр байрлуулан хамгаалах журмыг Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар зохицуулж байгаа нь эрх зүйн давхардсан зохицуулалтыг үүсгэж байгаа зөрчлийг арилгахаар гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийг түр байрлуулан хамгаалах журмыг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд тусгаж, хохирогчийг хамгаалах байр болон үйлчилгээ нь нэгдсэн нэг стандарттай, хохирогчийн ялгаатай хэрэгцээнд нийцсэн байхаар өөрчилж давхардлыг арилгалаа.

Мөн Улсын Их Хурлын болон Засгийн газрын дээрх шийдвэрийн хүрээнд хохирогчид эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх ажилд идэвх санаачлагатай ажилласан этгээдийг урамшуулах, гэр бүлийн хүчирхийллийн тоон мэдээллийг бүртгэх, хөтлөх, солилцох харилцааг холбогдох хууль болох Хууль зүйн туслалцааны тухай хууль, Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулахаар тусгаж давхардлыг арилгалаа.

2016 онд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль батлагдсанаас хойш хүч хэрэглэхгүйгээр зөрчилдөөнтэй асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрт сайн дураараа хамрагдсан тохиолдол огт бүртгэгдээгүй байна. Харин албадан сургалтын хүрээнд 2022 онд 5796 хүн, 2023 онд 5375 хүн хамрагдсан байна.

Иймээс зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөрийг сайн дурын болон албадан гэж ялгахгүйгээр ижил хөтөлбөрөөр олгодог байхаар, хөтөлбөрийг боловсруулж батлах этгээдэд боловсролын асуудал эрхэлсэн сайдыг нэмэхээр, зан үйлд нөлөөлөх сайн дурын сургалтыг хасахаар тус тус өөрчиллөө. Түүнчлэн Зан үйлд нөлөөлөх албадан сургалтын журмыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд заасан журмаар зохицуулахаар өөрчилж, холбогдох заалтыг хүчингүй болгохоор тусгалаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан Хохирогчид аюулын зэргийн үнэлгээ хийх журам, Нэг цэгийн үйлчилгээний төвийн аюулгүй байдалд цагдаагийн байгууллага хяналт тавих журмын зохицуулалтыг тус тус хуулийн төсөлд тусгаж захиргааны хэм хэмжээний актын тоог буурууллаа.

Мөн Улсын ерөнхий прокурор, Хууль зүй, дотоод хэргийн сайдын хамтран баталсан тушаалаар хэрэгжиж буй Гэр бүлийн хүчирхийллийн хохирогчийн аюулгүй байдлыг хангах журам нь Цагдаагийн албаны тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон Прокурорын байгууллагын тухай хуульд туссан зохицуулалтыг агуулж байх тул хүчингүй болгох нь зүйтэй гэж үзлээ.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХҮН ХУДАЛДААЛАХТАЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**1/3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалт:**

"3.1.3."хувийн мэдээлэл" гэж Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.11-д заасан мэдээллийг."

**2/10<sup>1</sup> дүгээр зүйл.**

**"10<sup>1</sup> дүгээр зүйл. Хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах**

10<sup>1</sup>.1. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон байж болзошгүй талаарх мэдээллийг тагнуул, цагдаагийн байгууллага хүлээн авсан даруйд хохирогчийг тогтоох арга хэмжээг авна.

10<sup>1</sup>.2. Хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн байж болзошгүй нөхцөл байдал, шинж тэмдэг илэрвэл эрсдэлийн үнэлгээ хийж, аюулгүй байдлыг хангах арга хэмжээг авна.

10<sup>1</sup>.3. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь хүүхэд бол хүүхэд гэр бүл хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад мэдэгдэж Хүүхэд хамгааллын тухай хуульд заасны дагуу яаралтай тусламж үйлчилгээнд хамруулж болно.

10<sup>1</sup>.4. Хохирогчийн аюулгүй байдлыг хангахдаа амь нас, эрүүл мэнд болон сэтгэл зүйн аюулгүй байдлыг нэн тэргүүнд хангана.

10<sup>1</sup>.5. Хохирогчийг эрүүл мэндийн байдал, нас, хүйс, бэлгийн чиг хандлага, нийгмийн гарал, боловсролоор ялгаварлан гадуурхахыг хориглоно.

10<sup>1</sup>.6. Зайлшгүй шаардлагатайгаас бусад тохиолдолд тухайн хэргийг шалгаж байгаа мөрдөгч, хяналт тавьж буй прокурорыг солихгүй.

10<sup>1</sup>.7. Цагдаа, тагнуулын байгууллагын албан хаагч нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах талаар Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

10<sup>1</sup>.7.1. хохирогчид хуульд заасан эрх үүрэг, төрийн болон төрийн бус байгууллагаас түүнд үзүүлж болох тусламж, үйлчилгээний талаар болон шаардлагатай бусад мэдээллийг өгөх;

10<sup>1</sup>.7.2. хохирогчийн эрсдэлийн үнэлгээний түвшингээс хамаарч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын арга хэмжээнд прокурорын тогтоол, шүүгчийн захирамжийг үндэслэн хамруулах;

10<sup>1</sup>.7.3. хохирогчийн амь бие, эрүүл мэндэд халдах талаар үндэслэлтэй мэдээлэл авагдсан тохиолдолд хамгаалалтад авах арга хэмжээг хохирогчийн зөвшөөрөл шаардахгүйгээр зохион байгуулах;

10<sup>1</sup>.7.4. хохирогч хамгаалалтын арга хэмжээнд хамрагдахаас сайн дураар татгалзсан бол энэ талаар баримтжуулах;

10<sup>1</sup>.7.5. оршин байгаа газраа соливол мэдэгдэхийг хохирогчид даалгах;

10<sup>1</sup>.7.6. гэмт хэрэгт холбогдсон этгээдийг сэжигтнээр баривчлан сулласан болон яллагдагчаар цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авч, сулласан тухай мэдээллийг цаг алдалгүй өгөх.

10<sup>1</sup>.8. Шүүгч, прокурор нь хохирогчийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд зааснаас гадна дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

10<sup>1</sup>.8.1. хохирогчийн мэдээллийг нууцлах;

10<sup>1</sup>.8.2. хамгаалах байранд байгаа хохирогчтой аль болох уулзахгүй байх, уулзах бол нууц байдалд уулзах;

10<sup>1</sup>.8.3. шүүх хуралдаан болох байрны аюулгүй байдлын зураглалыг гаргах, шаардлагатай тохиолдолд шүүх хуралдааныг өөр байранд хийх санал гаргах.

**3/11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг:**

"11.3. Гадаадын иргэн, харьяалалгүй хүн хохирогч болсон тохиолдолд өөрийн эх хэл, эсхүл мэдэх хэлээрээ орчуулагч оролцуулан мэдээлэл авах эрхтэй."

**4/12 дугаар зүйлийн 12.4, 12.5 дахь хэсэг:**

"12.4. Энэ хуулийн 12.1.4-т заасан үйлчилгээг Хууль зүйн тусламжааны хуульд заасан журмаар үзүүлнэ.

12.5. Хохирогч хараа, сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй бол дохио зангаа, тусгай тэмдэгт ашиглан хэлмэрчийн тусламжтайгаар энэ зүйлийн 12.1-д заасан мэдээллийг авах эрхтэй."

**5/13 дугаар зүйлийн 13.5, 13.6 дахь хэсэг:**

"13.5.Хохирогч хүүхдийн гэр бүлийн гишүүн, асран хамгаалагч, харгалзан дэмжигч түүний эсрэг ашиг сонирхолтой бол хүүхдийг нэн даруй тэдгээрээс тусгаарлана.

13.6.Хохирогчийг насанд хүрснийг тодорхойлох боломжгүй үед насыг тогтоох хүртэл насанд хүрээгүйд тооцож хамгаалалтын арга хэмжээнд хамруулна."

**2 дугаар зүйл.**Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн дараах хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

**1/9 дүгээр зүйлийн 9.4 дэх хэсэг:**

"9.4.Хамгаалах байрны үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон харилцааг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар зохицуулна."

**2/16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг:**

"16.5.Энэ хуулийн 16.3.4-т заасан урамшуулал олгохтой холбогдсон харилцааг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар зохицуулна."

**3 дугаар зүйл.**Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсгийн "Хохирогчийн өөрийн болон эцэг, эхийн нэр, оршин суугаа газрын хаяг, хувийн байдалтай нь холбоотой бусад" гэснийг "Хохирогчийн хувийн" гэж өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсгийн "энэ хуулийн 12.1.4-т заасан үйлчилгээ үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага," гэснийг хассугай.

**5 дугаар зүйл.**Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт" Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна." гэж, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.4-т "Монгол хүний эрүүл, аюулгүй амьдрах таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх, хүнсний аюулгүй байдлыг хангах, амьдрах орчин, орон байрны аюулгүй нөхцөлийг баталгаажуулах, гэмт хэрэг, халдлагын золиос болохоос хамгаалах нь хүний аюулгүй байдлыг хангах үндэс мөн." гэж тус тус заасан.

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейгаас 2000 онд "Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцыг баталж, 2003 онд 147 улс гарын үсэг зурснаар конвенц хүчин төгөлдөр болсон. Монгол Улс уг конвенц болон түүний нэмэлт болох "Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протоколд 2008 оны 05 дугаар сарын 16-ны өдөр нэгдэн орсон.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 114 дүгээр тогтоолоор хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй аливаа шалтгаан нөхцлийг судлан холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хийдэл, зөрчлийг арилгахыг Засгийн газарт үүрэг болгосон.

2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаас хуулиар тусгайлан эрх олгосон заалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг сайд нарт даалгасан. Иймд хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, хязгаарласан, харилцаанд оролцогчийн эрх, үүргийг тогтоосон буюу процессын шинжтэй зохицуулалт агуулсан, журмаар зохицуулсан харилцааг тухайн хуульд тусган боловсруулах шаардлага бий болсон.

Монгол Улсын хэмжээнд сүүлийн 10 жилийн хугацаанд Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан хүн худалдаалах 91 гэмт хэрэг бүртгэгдсэн бөгөөд үүнд 68 хүн холбогджээ. 2022 онд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоон мэдээлэлд улсын хэмжээнд хүн худалдаалах 27 гэмт хэрэг бүртгэгдсэнээс 6 хүн хохирогч болсон байна.

Хуулийн төслөөр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль болон Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд "хохирогч"-ийг ялгаатай байдлаар тодорхойлсон нь хууль хэрэглээний хувьд төөрөгдөл үүсгэж байгааг арилгаж хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хүрээнд хамгаалагдах асуудлыг зөрчилгүй болгосон.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг ажиллагааны холбогдох журам батлагдан хэрэгжээгүй байснаас хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах ажиллагаа зохицуулалтгүй байсныг засч хуулийн төсөлд

холбогдох зохицуулалтыг тусгалаа. Ингэхдээ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуульд тодорхойлж заасан бүх хувийн мэдээллийг хохирогчийн хувьд нууцлахаар тусгаж өмнөх зохицуулалтын хүрээг өргөжүүллээ.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон хүний аюулгүй байдлыг хамгаалахтай холбогдсон үйл ажиллагаа тодорхой зохицуулалттай болж аюулгүй байдлыг хангах ажиллагаанд нэн тэргүүн хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалах эрэмбийг тогтоолоо. Түүнчлэн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь гадаадын иргэн, хэл яриа, хараа, сонсголын бэрхшээлтэй бол өөрт нь ойлгомжтой хэл, хэлбэрээр мэдээлэл авах эрхтэй байхаар тусгалаа.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг хамгаалах байрны асуудал Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуультай давхардсан зохицуулалтыг бий болгож хэм хэмжээний өрсөлдөөн үүсгэсэн байгааг засч, хамгаалах байрны үйлчилгээг Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар зохицуулахаар тусгалаа. Ингэснээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч нь өөрийн ялгаатай хэрэгцээ, шаардлагадаа нийцсэн стандарт бүхий тав тухтай, аюулгүй байдал хангагдсан түр хамгаалах байранд хамгаалагдах юм.

Хохирогчийн эрх зүйн туслалцаа авах харилцааг захиргааны хэм хэмжээний актаар буюу журмаар зохицуулж байсныг өөрчилж Хууль зүйн туслалцааны тухай хуулиар зохицуулахаар өөрчиллөө.

#### ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Хүний эрхийн түгээмэл тунхаглал		
Иргэний болон улс төрийн эрхийн олон улсын пакт		
Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн олон улсын пакт		
Монгол Улсын Үндсэн хууль		
Хүний эрхийн зөвлөлийн UPR зөвлөмж		
НҮБ ын хүний эрхийн механизмын зөвлөмжийн нэгтгэл ХЭХҮХ		
Алсын хараа 2050 Монгол Улсын урт хугацааны бодлого		
Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр		
Монгол Улсын Их Хурлын 2023 оны 35 дугаар тогтоол		
Хүний эрх, эрх чөлөөний байдлын 22 дугаар илтгэл		
Монгол Улс дахь Хүний эрхийн төлөв байдал тулгамдсан асуудал, шийдэл 2021	- Хохирогч хамгааллын байрны нөхцөл, аюулгүй байдлын баталгааг нэмэгдүүлэх, бүх хүйсийн болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үйлчлэх нөхцөлийг бүрдүүлэх	
Нийгмийн харилцааг зохицуулж буй хуулиудад хийсэн хүний эрхийн үнэлгээний тайлан 2021		

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд дор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

#### 1/3 дугаар зүйлийн 3.4 дэх хэсэг:

"3.4. Шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчид учирч болох эрсдэлийн түвшин, гэмт хэргийн нөхцөл байдлыг харгалзан түүнийг өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор энэ хуулийн 3.2-т зааснаас бусад эрх, үйлдэлд хязгаарлалт тогтоож болно."

#### 2/7 дугаар зүйлийн 7.4, 7.5 дахь хэсэг:

"7.4. Эрх бүхий байгууллагын хамгаалалтын тусгай алба энэ хуулийн 7.1.3-7.1.9-д заасан хамгаалалтад оролцсон, мэдсэн төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн холбогдох албан тушаалтан, алба хаагч, гэрч хохирогч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчөөс нууцын баталгаа гаргуулна. Насанд хүрээгүй гэрч, хохирогчид түүний хууль ёсны төлөөлөгчийг байлцуулан, нууц хадгалах талаар тайлбарлаж, тэмдэглэл үйлдэнэ."

7.5. Гэрч, хохирогчийг хамгаалалтын үйл ажиллагаанд харш аливаа сөрөг үйлдэл хийхийг хориглоно."

#### 3/10 дугаар зүйлийн 10.3-10.9 дэх хэсэг:

"10.3. Биечилсэн хамгаалалтыг энэ хуулийн 23.1-д заасан эрх бүхий байгууллагаас томилогдсон алба хаагч байрлаж болон хөдөлгөөнтэйгээр, ил болон далд хэлбэрээр зохион байгуулна."

10.4. Хамгаалалтын арга хэмжээнд хэрэглэгдэх холбоо, тээвэр, орон байр, галт зэвсэг, тусгай хэрэгслийг эрх бүхий байгууллага хариуцах бөгөөд шаардлагатай тохиолдолд галт зэвсэг, нэг бүрийн тусгай хэрэгсэл биеийн хүчийг холбогдох хуульд заасан үндэслэл журмын дагуу хэрэглэнэ."

10.5. Энэ хуулийн 10.1-д заасан хамгаалалтын арга хэмжээг биечлэн, ил болон далд хэлбэрээр гүйцэтгэнэ."

10.6. Биечилсэн хамгаалалт нь хамрах хүрээ, хүч хэрэгсэл, нөхцөл байдал, аюулын эрсдэлээс шалтгаалан дараах түвшинтэй байна:

10.6.1. Нэгдүгээр түвшний хамгаалалтыг энэ хуулийн 22.3.1-д заасан аюулын эрсдэлийн түвшин өндөр тогтоогдсон үед 24 цагаар, тодорхой хугацаанд тасралтгүйгээр зохион байгуулна."

10.6.2. Хоёрдугаар түвшний хамгаалалтыг энэ хуулийн 22.3.2-т заасан дунд түвшний аюулын эрсдэл тогтоогдсон үед зохион байгуулна."

10.6.3. Гуравдугаар түвшний хамгаалалтыг 22.3.3-т заасан аюулын эрсдэлийн түвшин бага тогтоогдсон үед зохион байгуулна."

10.7. Эрх бүхий байгууллага энэ хуулийн 21.10-т заасан гэрээг гэрч, хохирогчтой харилцан тохиролцож байгуулсны үндсэн дээр хамгаалалтыг хэрэгжүүлнэ."

10.8. Насанд хүрээгүй гэрч, хохирогчийг хамгаалах гэрээг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчтэй байгуулна."

10.9. Шаардлагатай гэж үзвэл эрх бүхий албан тушаалтны шийдвэрийг хүлээлгүй гэрч, хохирогчийг хамгаалалтанд авч прокурор, шүүгчид нэн даруй мэдэгдэнэ."

10.10. Хамгаалалт гүйцэтгэж буй алба хаагч нь гэрч, хохирогчтой хувийн харилцаа тогтоох, дур мэдэн гадны хүн нэвтрүүлэх, хууль бус хүсэлт тавих, гэрч хохирогчийн талаар мэдээлэл дамжуулахыг хориглоно."

#### 4/11 зүйлийн 11.4 дэх хэсэг:

"11.4. Гэрч, хохирогчид өгсөн зохиомол нэрийг зөвхөн мөрдөн шалгах, шүүн таслах ажиллагаанд оролцох үед хэрэглэнэ."

#### 5/16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэг:

"16.5. Гадаад төрхийг өөрчлөх аюулгүй байдлын хамгаалалтын арга хэмжээг хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад зорилгоор хэрэгжүүлэхийг хориглоно."

#### 6/21 дүгээр зүйл:

**"21 дүгээр зүйл. Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журам**

21<sup>1</sup>.1. Цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийн хамгаалалтын арга хэмжээг энэ хуулийн 23.2-т заасан алба, нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагын эрүүгийн цагдаагийн нэгж, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа хорих байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ."

21<sup>1</sup>.2. Энэ хуулийн 21<sup>1</sup>.1-д заасан байгууллагууд хамгаалалтын төрлөөс хамаарч хамгаалалтын арга хэмжээнд хамтран ажиллах гэрээ, насанд хүрээгүй гэрч, хохирогчийн хамгаалалтын арга хэмжээнд хамтран ажиллах гэрээний аль тохирохыг байгуулна."

21<sup>1</sup>.3. Хамгаалалтын арга хэмжээний үед Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд зааснаас гадна дараах арга хэмжээг авна:

211.3.1.гэрч, хохирогчийн аюулын эрсдэлийн түвшинг тогтоох;

21.3.2.гэрч, хохирогчийг бусад хоригдол, хоригдогч, алба хаагч, иргэдээс тусгаарлах;

211.3.3.шаардлагатай тохиолдолд гэрч, хохирогчийг хорих ангид эдэлж байсан ажил хөдөлмөр, олон нийтийн арга хэмжээнд оролцуулахгүй байх;

211.3.4.хамгаалалтын арга хэмжээний шаардлагыг хангаагүй, биелүүлэх боломжгүй үед, эсхүл энэ хуулийн 23.1-д заасан байгууллагын саналын дагуу гэрч, хохирогчийн байршлыг өөрчлөх;

211.3.5.шаардлагатай бусад.

211.4.Хамгаалалтын арга хэмжээнд хамрагдаж байгаа гэрч, хохирогч нь энэ хуулийн 18 дугаар зүйлд заасан туслалцааг авах, хамгаалалтын арга хэмжээний талаар санал, хүсэлт гаргах, хамгаалалтын арга хэмжээний болон өөрийн аюулгүй байдлын талаар мэдээллээр хангагдах эрхтэй.

211.5.Хамгаалалтын арга хэмжээнд хамрагдаж байгаа гэрч, хохирогч нь хорих анги, хорих байрны дотоод журмыг дагаж мөрдөх, хамгаалалтын арга хэмжээний заавар, зөвлөмж, алба хаагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлэх, өөрт нь ямар нэгэн аюул заналхийлэл учирсан, учирч болзошгүй нөхцөл байдлын талаар мэдсэн даруйд хамгаалалтын арга хэмжээ хэрэгжүүлэгч байгууллагад мэдэгдэх үүрэгтэй.

211.6.Гэрч, хохирогч нь хорих ангийн дотоод журам, хорих ангийн даргын баталсан цагийн хуваарийг дагаж мөрдөөгүй, хамгаалалтын арга хэмжээний зааврыг удаа дараа зөрчсөн тохиолдолд хамгаалалтын арга хэмжээг цуцалж болно.

#### **7/22 дугаар зүйлийн 22.3 дугаар хэсэг:**

"22.3.Энэ хуулийн 22.1.4-т заасан аюулын эрсдэлийн түвшинг дараах байдлаар ангилна:

22.3.1.гэрч, хохирогчийн амь насанд бодитой заналхийлсэн, бие махбодид гэмтэл учруулсан, тарчлаасан, байнгын дарамтад байлгасан, гэмт хэрэг үйлдэхийг тулган шаардсан, айлган сүрдүүлсэн, дарамт шахалт үзүүлсэн, дагаж мөрдсөн бол эрсдэлийн өндөр түвшин;

22.3.2.гэрч, хохирогчийн эд хөрөнгөд халдсан, заналхийлсэн, цахим сүлжээ, холбооны хэрэгсэл ашиглан ятгасан, нөлөөлсөн, мөнгө, эд зүйл, албан тушаал амласан бол эрсдэлийн дунд түвшин;

22.3.3.гэрч, хохирогчтой уулзах, харилцаа тогтоохыг оролдсон бол эрсдэлийн бага түвшин."

**2 дугаар зүйл.**Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дүгээр заалтын "хохирогчийг," гэсний дараа "Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан хохирогчийг," гэж, 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсгийн "болно." гэсний дараа "Шийдвэрийг хүлээн авсан байгууллага гэрч, хохирогчтой холбоотой

цахим мэдээллийн санд нэвтрэх боломжийг тогтоосон хугацаагаар хязгаарлах техник, технологийн арга хэмжээг авч холбогдох баримт бичгийг нууцын архивт шилжүүлнэ." гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

#### **1/12 дугаар зүйл:**

**"12 дугаар зүйл.Хувийн хамгаалалтын хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах**

12.1.Гэрч, хохирогчийг хувийн хамгаалалтын нэг бүрийн тусгай хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангаж, шаардлагатай тохиолдолд түүний биед болон орон байранд тусгай техник хэрэгсэл суурилуулж болно.

12.2.Энэ хуулийн 12.1-д заасан биед болон оронд байранд суурилуулах тусгай техник хэрэгсэлд дор дурдсан техник хэрэгслийг тооцно:

12.2.1.дохиолол илрүүлэх;

12.2.2.галын аюулыг илрүүлэх;

12.2.3.дүрсийг хянах;

12.2.4.байршил тогтоох

12.2.5.цахим болон биометрик мэдээлэл таних төхөөрөмж;

12.2.6.бусад.

12.3. Энэ хуулийн 12.1-д заасан хувийн хамгаалалтын нэг бүрийн тусгай хэрэгсэлд дараах хэрэгслийг хамруулна:

12.3.1.Хувийн хамгаалалтын тухай хуулийн 12.1-д заасан хэрэгсэл;

12.3.2.хутга, сумнаас хамгаалах хантааз

12.3.3.бусад.

12.4.Энэ хуулийн 12.1-д заасан техник, хэрэгслийг олгохоос өмнө гэрч, хохирогчийг сургалтад хамруулан зааварчилгаа өгнө.

12.5.Гэрч, хохирогч нь нэг бүрийн тусгай техник, хэрэгслийг биедээ авч явах эрхтэй.

12.6.Гэрч, хохирогч нь тусгай хэрэгсэл, техникийг өөрийн буруугаас эвдсэн, гэмтээсэн, үрэгдүүлсэн тохиолдолд нөхөн төлнө.

12.7.Гэрч, хохирогчийн ашиглаж байгаа тусгай хэрэгсэл, техникийн төрөлд өөрчлөлт оруулах асуудлыг хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллагын албан тушаалтны гаргасан саналыг үндэслэн тухайн байгууллагын удирдлага шийдвэрлэнэ.

12.8.Эрх бүхий байгууллага өөрийн хүн хүч, техникээр хамгаалалтыг зохион байгуулах боломжгүй тохиолдолд гэрээт харуул хамгаалалтын байгууллагаар дохиолол хамгаалалтын төхөөрөмж, галын аюулын дохиолол, дүрсний хяналтын болон байршил тогтоох хэрэгсэл, хаалганы цахим болон биометрик мэдээлэл мэдрэгч цоож ашиглахтай холбоотой ажил, үүргийг гэрээгээр гүйцэтгүүлж болно.

12.9.Гэрээгээр харуул хамгаалалт хэрэгжүүлэх байгууллага нь Гэрээт харуул хамгаалалтын тухай хуулийн 6.1-д зааснаас гадна 5-аас доошгүй жил тасралтгүй үйл ажиллагаа явуулсан, татварын өргүй, санхүүгийн чадавхи, гэрч, хохирогч болон аюул занал учруулж болзошгүй этгээдтэй ашиг сонирхлын зөрчилгүй байна.”

**2/13 дугаар зүйл:**

**“13 дугаар зүйл. Аюулгүй газарт түр байрлуулах**

13.1.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан насанд хүрсэн гэрч, хохирогчийг өөрийнх нь зөвшөөрснөөр, насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түүний эцэг, эх, хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хүүхдийн эрхийг хамгаалах байгууллагын зөвшөөрснөөр аюулгүй байдал хангагдсан газарт бодит аюул, заналхийлэл арилах хүртэл хугацаанд түр байрлуулна.

13.2.Түр байрлуулан хамгаалах байр нь дараах төрөлтэй байна:

13.2.1.энэ хуулийн 23.1-д заасан байгууллагын дэргэдэх тусгай хамгаалах байр болон хамгаалах байр;

13.2.2.бусад төрийн байгууллага болон төрийн бус байгууллага гэрээний үндсэн дээр ажиллуулах хамгаалах байр.

13.3.Гэрч, хохирогчийн зөвшөөрөл, эрсдэлийн түвшинг харгалзан эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр төрийн болон төрийн бус байгууллагын хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний төв болон бусад байрыг хамгаалах байрны зориулалтаар гэрээ байгуулан ашиглаж болно. Аюулгүй байдал, гарах зардлыг сайн дурын үндсэн дээр хүлээн зөвшөөрсөн тохиолдолд эрсдэлийн бага түвшинтэй гэрч, хохирогчийн орон байрыг хамгаалах байрны зориулалтаар гэрээ байгуулан ашиглаж болно.

13.4.Насанд хүрээгүй гэрч, хохирогчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, хууль ёсны төлөөлөгч түр хамгаалах байранд хамт байх боломжгүй тохиолдолд тэдний зөвшөөрлийг бичгээр авсны үндсэн дээр гэрч, хохирогчийг дангаар байрлуулж болно.

13.5.Энэ хуулийн 13.4-т заасан гэрч, хохирогчийн эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч болон өмгөөлөгчтэйгээ уулзах уулзалтыг хамгаалах байрнаас гадуур зохион байгуулна.

13.6.Насанд хүрээгүй гэрч, хохирогчийн суралцах нөхцөл, боломжийг хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэгч байгууллага хангана.

13.7.Энэ хуулийн 22.3-т заасан эрсдэлийн өндөр түвшин тогтоогдсон гэрч хохирогчийг зөвхөн тусгай хамгаалах байранд, эрсдэлийн дунд болон бага түвшин бүхий гэрч, хохирогчийг хамгаалах байранд тус тус байрлуулна.

13.8.Нэг гэмт хэргийн гэрч, хохирогч нарыг түр хамгаалах байранд хамтад нь байрлуулахыг хориглоно.

13.9.Түр байрлуулан хамгаалах байр болон үйлчилгээ нь хүний ялгаатай хэрэгцээ, шаардлагад нийцсэн байх бөгөөд нарийвчлан зохицуулсан стандартыг холбогдох байгууллагаар батлуулан мөрдөж ажиллана.

13.10.Түр байрлуулан хамгаалах байрны үйлчилгээ нь үнэ төлбөргүй байх бөгөөд зардлыг улсын төсөв болон хуульд заасан бусад эх үүсвэрээс санхүүжүүлнэ.”

**4 дүгээр зүйл.**Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.5 дахь хэсгийн “7.1.3-7.1.9-д” гэснийг “7.1.4, 7.1.7, 7.1.8, 7.1.9 -д” гэж өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.9 дэх хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Манай улс Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийг эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад гэрч, хохирогчийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, тэднийг мэдээллээр хангах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх эрх зүйн үндсийг тогтоох зорилгоор 2013 онд батлан мөрдөж байна.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулиар цагдаагийн алба, Тагнуулын ерөнхий газар, Авилгатай тэмцэх газар өөр өөрийн эрх хэмжээний хүрээнд дараах этгээдийг хамгаалах үүрэг хүлээж байна.

- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогч;

- Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрч;

- Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 4.1.1-д заасан ганцаараа эсхүл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх хамгаалах үйл ажиллагаа явуулж байгаа, түүнд оролцож байгаа хүний эрх хамгаалагч;

- Гэрч, хохирогч, хүний эрх хамгаалагчийн хамаарал бүхий этгээд;

- Гэмт хэрэг илрүүлэхэд ач холбогдол бүхий мэдээлэл, баримт сэлт өгөх болон бусад байдлаар туслалцаа үзүүлсэн, эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гэрчээр оролцоогүй хүн.

Тус хуульд заасан хамгаалалтын арга хэмжээнд 2016-2024 хооронд 66 гэрч, 918 хохирогч, тэдгээрийн хамаарал бүхий болон бусад нийт 1075 хүнийг хамруулснаас өндөр эрсдэлтэй 32, дунд эрсдэлтэй 393, бага эрсдэлтэй 593 хүнийг хамруулж ажилласан тоон мэдээлэл байна.

Монгол Улсын Их Хурлын 2023 оны 114 дүгээр тогтоолоор хүний эрх, эрх чөлөөг зөрчиж болзошгүй аливаа шалтгаан нөхцлийг судлан холбогдох эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох, хийдэл, зөрчлийг арилгахыг Засгийн газарт үүрэг болгосон.

Түүнчлэн 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаас хуулиар тусгайлан эрх олгосон заалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг сайд нарт даалгасан. Иймд хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, хязгаарласан, харилцаанд оролцогчийн эрх, үүргийг тогтоосон буюу процессын шинжтэй зохицуулалт агуулсан, журмаар зохицуулсан харилцааг тухайн хуульд тусган боловсруулах шаардлага бий болсон.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад "гэрч, хохирогч" гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг гэж тодорхойлсон бөгөөд энэ нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан хохирогчийн тодорхойлолттой нийцдэггүйгээс энэ төрлийн гэмт

хэргийн хохирогч Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн хамгаалалтын гадна үлдэх хийдэл үүссэн байсныг заслаа.

Мөн гэрч, хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг Хууль зүйн туслалцааны тухай хууль, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар зохицуулж байсан нь эрх зүйн давхардал үүсгэсэн байгааг тухайн харилцааг зохицуулж буй Хууль зүйн туслалцааны тухай хуульд заасан журмаар зохицуулахаар өөрчилж давхардлыг арилгалаа.

Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт зөвхөн насанд хүрээгүй гэрч, хохирогчийг түр хамгаалах асуудлыг стандарттай байхаар зохицуулсан байдаг. Энэ нь насанд хүрсэн гэрч, хохирогчийг ялгаварласан байдал үүсгэснийг өөрчилж бүх гэрч, хохирогч ялгаатай хэрэгцээ, шаардлагадаа нийцсэн стандарт бүхий тав тухтай, аюулгүй байдал хангагдсан түр хамгаалах байранд хамгаалагдах эрхтэй байхаар тусгаж хүний эрхийн талаас нь дэвшил гаргах байдлаар зохицуулалтыг өөрчиллөө.

Хүний эрхийг зөвхөн хуулиар хязгаарлах зарчим болон Засгийн газрын дээрх шийдвэрийн хүрээнд Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан хамгаалалтын арга хэмжээг журмаар буюу хууль зүйн асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн батлан мөрдүүлж байснаас биечилсэн хамгаалалт хэрэгжүүлэх журам, нэг бүрийн тусгай хэрэгсэл болон тусгай техник хэрэгсэл, харилцаа холбооны хэрэгслээр хангах журам, аюулгүй газар түр байруулах журам болон цагдан хоригдож байгаа болон хорих ял эдэлж байгаа гэрч, хохирогчийг хамгаалах журмын холбогдох зохицуулалтыг хуульд тусган боловсрууллаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

Төсөл

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 3.7 дугаар зүйлд дор дурдсан агуулгатай тайлбар нэмсүгэй:

"Тайлбар: Энэ зүйлд заасан "өрх толгойлсон эх, эцэг" гэдэгт Нийгмийн халамжийн тухай хуулийн<sup>1</sup> 3 дугаар зүйлийн 3.1.8-д заасныг, "баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчин" гэж Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн<sup>2</sup> 157 дугаар зүйлийн 157.2-т заасныг ойлгоно.

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн дараах зүйл, хэсгийг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

**1/ 3.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

"4.Шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан, эсхүл торгох шийтгэлийг баривчлах шийтгэлээр сольсон тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, 0-3 насны хүүхэдтэй эх, арван зургаа хүртэлх насны хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх, хүнд өвчтэй хүнийг асран хамгаалж байгаа хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй."

**2/5.5 дугаар зүйл:**

**"5.5 дугаар зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх  
тухай хууль зөрчих**

1.Гэр бүлийн хүчирхийллийн талаар хуулиар хүлээсэн мэдээлэх, хүүхдийн бэртэл гэмтэл, өвчлөл, сэтгэл санааны байдал, хичээл таслалт, сургууль завсардалт зэрэг хүүхдийн бие махбод, сэтгэл санаа, зан үйлд гарч байгаа сөрөг нөлөөллийн шалтгааныг тогтоох, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүргээ биелүүлээгүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвийн журам зөрчиж нэвтэрсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

<sup>1</sup>Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2012 лны 08 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup>Төрийн мэдээлэл эмхтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн.

3.Түр хамгаалах байрыг хуульд зааснаас өөр зориулалтаар ашигласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, эсхүл бусадтай харилцахыг хязгаарласан, эсхүл хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүний биед халдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна."

**3/10.13 дугаар зүйл:**

**"10.13 дугаар зүйл.Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний  
тухай хууль зөрчих**

1.Гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр хууль бус хөдөлмөр эрхлүүлсэн бол гадаадын иргэн, харьяалалгүй хүний хөдөлмөр эрхэлсэн хугацааны ажлын байрны төлбөрийг нөхөн төлүүлж, хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Гадаад ажилтны ажлын байрны төлбөрийг төлөөгүй бол гадаадын иргэн, харьяалалгүй хүний тухайн ажил олгогчид хөдөлмөр эрхэлсэн хугацааны төлбөрийг нөхөн төлүүлж, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Гадаад ажилтныг хөдөлмөрийн чиг баримжаа олгох сургалтад хамруулаагүй, эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамруулах үүргээ биелүүлээгүй хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацаа дууссан гадаадын ажилтныг нутаг буцаах үүргээ биелүүлээгүй бол гадаадын ажилтны ажлын байрны төлбөрийг нөхөн төлүүлж, хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Тусгай зөвшөөрөл эзэмшигч гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучилсан иргэний бүртгэл хөтлөөгүй, мэдээ, тайланг тогтоосон хугацаанд өгөөгүй, худал тайлан өгсөн бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч зуучлуулагчтай зуучлалын гэрээ байгуулаагүй, зуучлуулагчаас хууль бусаар төлбөр хураамж, барьцаа, бэлэн мөнгө авсан бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Зөвшөөрөлгүйгээр иргэнийг гадаад улсад хөдөлмөр эрхлэхэд зуучилсан, хөдөлмөр эрхлүүлнэ гэж ухуулан сурталчилсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирлыг нөхөн төлүүлж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: "хууль бус хөдөлмөр эрхлүүлсэн" гэж Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлд тодорхойлсон хөдөлмөрийн харилцаанд оролцож, ашиг, орлого олох зорилготой эсэхээс үл хамааран, зөвшөөрөлгүйгээр гадаадын иргэн, харьяалалгүй хүнээр ажил гүйцэтгүүлсэн, хөлсөөр ажиллуулсан, туслан гүйцэтгүүлсэн бүх төрлийн хөдөлмөр эрхлэлт, тэдгээрийг хөдөлмөр эрхлүүлнэ гэж ухуулан сурталчилсан, элсүүлсэн, зуучилсан, тээвэрлэсэн үйлдлийг ойлгоно."

#### 4/10.16 дугаар зүйл:

#### "10.16 дугаар зүйл.Хөдөлмөрийн тухай хууль зөрчих

1.Ажил олгогч, ажил олгогчийн төлөөлөгч хуульд заасныг зөрчиж:

1.1.ажилтны эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхээ хэрэгжүүлэхэд саад учруулсан, эсхүл ажилтны төлөөллийн байгууллагын үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцсон, эсхүл уг зорилгоор санхүүгийн болон бусад дэмжлэг амалсан, үзүүлсэн;

1.2.ажил олгогчийн хяналт дор үйлдвэрчний эвлэл байгуулах, эвлэлдэн нэгдэхийг ажилтанд тулгасан;

1.3.ажилтныг үйлдвэрчний эвлэл байгуулсан, үйл ажиллагаанд нь оролцсон, гишүүнээр элссэнтэй нь холбогдуулан хөдөлмөр эрхлэлтийн нөхцөлийг нь дордуулсан;

1.4.ажилтны төлөөлөгчид хамтын хэлэлцээ хийхэд нь хөндлөнгөөс оролцсон, хязгаарласан, албадлага хэрэглэсэн;

1.5.хамтын хэлэлцээ хийх, хамтын гэрээ, хамтын хэлэлцээр байгуулахад шаардагдах мэдээлэл өгөхөөс татгалзсан;

1.6.ажилтны төлөөлөгчид санхүүгийн болон бусад дэмжлэг амлах, үзүүлэх замаар ажил олгогчийн хяналтад байлгахыг оролдсон бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Ажилтан, ажилтны төлөөлөгч хуульд заасныг зөрчиж:

2.1.бусад ажилтныг ялгаварлан гадуурхахад хүргэж болзошгүй шаардлагыг ажил олгогчид тулгасан, ятгасан;

2.2.хамтын хэлэлцээ хийх болон хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх нөхцөлтэйгээр ажил олгогчоос санхүүгийн болон бусад дэмжлэг шаардсан, авсан;

2.3.ажилтан, үйлдвэрчний эвлэлийн гишүүний эвлэлдэн нэгдэх, төлөөлөгчөө сонгох, хамтын үйл ажиллагаанд оролцох эрхээ эдлэх, үл эдлэхэд нь ажил олгогчоос санхүүгийн болон бусад дэмжлэг авах болзол тавьж хөндлөнгөөс оролцсон бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Ажил олгогч хамтын хэлэлцээнд оролцож байгаа, эсхүл оролцсон үйлдвэрчний эвлэлийн ажилтан, сонгуультай ажилтны төлөөлөгчид уг ажилтай нь холбогдуулж:

3.1.сахилгын шийтгэл ногдуулсан;

3.2.өөр ажилд шилжүүлсэн;

3.3.цалин хөлсийг бууруулсан;

3.4.хэлэлцээний явцад болон хэлэлцээ дууссанаас хойш нэг жилийн дотор аж ахуйн нэгж, байгууллага, түүний салбар татан буугдсан болон Хөдөлмөрийн тухай хуульд зааснаас бусад үндэслэлээр ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Ажил олгогч ажилтантай хөдөлмөрийн гэрээг байгуулаагүй, эсхүл ажилтныг ажил үүргээ гүйцэтгэж эхэлснээс хойш ажлын 10 өдрийн дотор хөдөлмөрийн гэрээг бичгээр нөхөн байгуулаагүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Ажил олгогч хууль тогтоомж, хөдөлмөрийн гэрээний дагуу олговол зохих цалин хөлс, олговрыг олгоогүй, эсхүл хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр тогтоосон хугацаанд нь олгоогүй, эсхүл цалин хөлснөөс үндэслэлгүйгээр суутгал хийсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Ажил олгогч насанд хүрээгүй хүнийг:

6.1.ажилд авахдаа болон ажиллуулах хугацаандаа 18 нас хүртэл нь зургаан сар тутам эрүүл мэндийн үзлэгт хамруулаагүй;

6.2.шөнийн цагаар ажиллуулсан;

6.3.илүү цагаар ажиллуулсан;

6.4.хуулиар зөвшөөрөгдсөнөөс бусад тохиолдолд албан томилолтоор ажиллуулсан;

6.5.уртын ээлжээр ажиллуулсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Хуулиар зөвшөөрснөөс бусад тохиолдолд 15 нас хүрээгүй хүнээр хөдөлмөр эрхлүүлсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Жирэмсэн эмэгтэй, гурван нас хүрээгүй хүүхэдтэй, эсхүл 16 хүртэлх насны байнгын асаргаа шаардлагатай хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрснөөс бусад тохиолдолд нийтээр амрах баярын болон долоо хоног бүрийн амралтын өдөр ажиллуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Жирэмсэн эмэгтэй, гурван нас хүрээгүй хүүхэдтэй ажилтан өөрөө зөвшөөрөөгүй, насанд хүрээгүй ажилтан, Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэрээр шөнийн цагаар ажиллуулахыг хориглосон ажилтныг шөнийн цагаар ажиллуулсан бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Хуульд заасны дагуу нийт ажлын байрны дөрвөн хувиас доошгүй орон тоонд хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулах үүргээ биелүүлээгүй, эсхүл хуульд заасныг зөрчиж хөгжлийн бэрхшээлтэй хүний хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Ажил хаялтад оролцсонтой нь холбогдуулан ажилтан, ажилтны төлөөлөгчид сахилгын шийтгэл ногдуулсан, өөр ажилд шилжүүлсэн, ажил олгогчийн санаачилгаар хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцалсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно."

3 дугаар зүйл. Зөрчлийн тухай хуулийн 5.13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "...торгох, эсхүл долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулах..." гэснийг хассугай.

4 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 5.9 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө

## ТАНИЛЦУУЛГА

Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт тухай хуулийн төслийн талаар

Монгол Улсын Их Хурлаас 2017 баталсан Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга нь 17 бүлэг, 255 зүйл, 1058 хэсэг, 908 заалттай бөгөөд тус хуулийн тусгай ангид нийт 2300 орчим үйлдлийг зөрчилд тооцож, зөрчил үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах зохицуулалттай байна. Тус хуулийн төсөлд хүний эрх, эрх чөлөөг хангах дэвшилтэт зохицуулалтыг бий болгох, зүй ёсны хэрэгцээ шаардлагыг харгалзах, хүний эрх эрх чөлөөнд зөвхөн хуулиар хязгаарлалт тогтоох олон улсын хүний эрхийн гэрээ конвенц, Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг баримтлан дараах өөрчлөлтийг тусган боловсрууллаа.

Түүнчлэн НҮБ-ын Дур зоргоор саатуулах асуудал хариуцсан ажлын хэсгийн 2022 онд Монгол Улсад хийсэн айлчлалын дүгнэлтдээ 2017 онд батлагдсан Зөрчлийн тухай хуулийн дагуу хариуцлага хүлээлгэж байгаа үйл ажиллагаанд санаа зовниж байгаа болон хүний эрх чөлөөг хасах нь хамгийн эцсийн шатанд авах арга хэмжээ байх ёстой гэдгийг сануулсан байдаг. Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 9 дүгээр зүйлд заасны дагуу хүний эрх чөлөөг хангах үүднээс баривчлах шийтгэл оногдуулж буй үйлдлүүдийн цар хүрээг Засгийн газар дахин нэг нягталж үзэх нь зүйтэй талаар зөвлөснийг мөн харгалзан үзлээ.

### Ерөнхий ангийн хувьд

Баривчлах шийтгэлийг оногдуулахгүй байх этгээдийн хүрээ хязгаарыг иргэдийн зүй ёсны хэрэгцээ шаардлагад нийцүүлэн харьцангуй өргөжүүлэн тусгалаа. Ийнхүү шүүх баривчлах шийтгэлийг энэ хуулийн тусгай ангид заасан тохиолдолд оногдуулах ба жирэмсэн эмэгтэй, 0-3 насны хүүхэдтэй эх, арван зургаа хүртэлх насны хүүхэдтэй эрх толгойлсон эцэг, эх, хүнд өвчтэй хүнийг асран хамгаалж байгаа хүн, баривчлах шийтгэл эдлүүлэхэд саад болохуйц өвчтэй хүнд оногдуулахгүй байхаар тусгалаа.

### Тусгай ангийн хувьд

Тус хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд буюу 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд прокурорын байгууллагад хамгийн олон бүртгэгдсэн зөрчлүүдийг зүйлээр авч үзвэл:<sup>3</sup>

Д/д	Зүйлийн гарчиг	Нийт бүртгэгдсэн	
1	14.7 дугаар зүйл.Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль зөрчих	6,640,580	

<sup>3</sup> Улсын ерөнхий прокурорын газраас ХЗДХЯ-д ирүүлсэн тоон баримт дээр үндэслэн боловсруулсан тоо болно.

2	5.1 дүгээр зүйл.Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	259,626	
3	14.6 дугаар зүйл.Автотээврийн тухай хууль зөрчих	65,576	
4	5.3 дугаар зүйл.Хүний биед халдах	41,495	
5	11.15 дугаар зүйл.Жолоочийн даатгалын тухай хууль зөрчих	36,813	
6	15.24 дүгээр зүйл.Иргэний улсын бүртгэлийн тухай хууль зөрчих	36,167	
7	5.4 дүгээр зүйл.Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих	30,603	
8	15.9 дүгээр зүйл.Хуурамч дуудлага, мэдээлэл өгөх	24,283	
9	5.5 дугаар зүйл.Нийтийн зориулалттай орон сууцны оршин суугчдын амгалан тайван байдлыг алдагдуулах	18,694	
10	5.2 дугаар зүйл.Танхайрах	18,506	

Харин 2022 оны тоон мэдээллийн Монгол Улс дахь гэмт хэргийн цагаан ном 2022 оос харахад Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчсөн зөрчил 10095 бүртгэгдсэн нь 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2021 оны 05 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд прокурорын байгууллагад бүртгэгдсэн зөрчлийн дундаж үзүүлэлтэй харьцуулахад 2022 онд нийт зөрчилд эзлэх хувь өссөн үзүүлэлттэй байна. Ийнхүү 2022 онд бүртгэгдсэн 10095 зөрчилд нийт 395 хүнийг 8195 баривчилсан байна. Өөрөөр хэлбэл тус зөрчлийн 80 хувьд нь баривчлах шийтгэл оногдуулсан байна.

Гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон, хүсэл зоригийнх нь эсрэг тодорхой үйлдэл хийх, хийхгүй байхыг албадсан, бусадтай харилцахыг хязгаарласан, хуваарьт болон дундын эд хөрөнгөө эзэмших, ашиглах, захиран зарцуулах эрхэд халдсан үйлдлүүдэд баривчлах шийтгэл оногдуулах зохицуулалт үйлчилж байна. Гэтэл хууль хүчин төгөлдөр үйлчлэх хугацаанд тус гэр бүлийн хүчирхийллийн зөрчил нийт бүртгэгдсэн зөрчлийн эхний 5 зөрчилд байнга бүртгэгдэж ирсэн бөгөөд ийнхүү гэр бүлийн хувьд нэгийг баривчлах шийтгэл ирсэн нь энэ төрлийн шийтгэл оновчтой, үр дүнтэй биш гэдэг нь нотлогдож байна.

Харин гэр бүлийн зөрчлийг анх удаа үйлдэж байгаа, эсхүл гэр бүлийн маргаанаас үүдэн гарсан зөрчилд юуны түрүүнд баривчлах шийтгэл оногдуулахгүйгээр уяан хатан зохицуулалтыг бий болгох, албан сургалтад хамруулах, нөлөөллийн арга хэмжээ авах, ажил хөдөлмөр эрхлэх боломж олгох нь үр дүнтэй байж болох тул харин гэр бүлийн хамаарал бүхий харилцаатай хүнийг зодсон буюу биед нь халдсан үйлдэлд баривчлах шийтгэл оногдуулахаар өөрчлөн тусгалаа. Энэ талаар эрх бүхий байгууллагын судалгаа, дүгнэлт, гэр бүлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас санал ирүүлснийг үндэслэсэн болно.

Мөн гамшиг, аюулт үзэгдэл, осол, аюулын үед эрх бүхий байгууллагаас тогтоосон хорио цээр, хөдөлгөөний хязгаарлалт, тэдгээрийн дэглэм зөрчсөн, эсхүл саад учруулсан зөрчил оногдуулах баривчлах шийтгэлийг хасаж боловсруулав.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2021 онд Хөдөлмөрийн тухай хууль, Гадаадаас ажиллах хүч авах, ажиллах хүч гадаадад гаргах тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Ажиллах хүчний шилжил хөдөлгөөний тухай хуулийг баталсан боловч тус хуультай холбогдуулан зөрчилд тооцох үйлдэл, түүнд оногдуулах шийтгэлийг Зөрчлийн тухай хуульд шинэчлэн тусгаж батлаагүй хуулийн хийдэл үүсгэж байна. Иймд Хөдөлмөрийн тухай хууль зөрчих, Ажиллах хүчний шилжилт хөдөлгөөний тухай хууль зөрчих гэсэн зүйлүүдийг өөрчлөн найруулсан болно.

Хүчин төгөлдөр Зөрчлийн тухай хуульд Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол гэж ерөнхий байдлаар тусгасан зохицуулалт үйлчилдэг.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд иргэнд үүрэг хүлээгсэн 14 заалт, хуулийн этгээдэд үүрэг хүлээлгэсэн 9 заалт, хэвлэл, мэдээллийн байгууллагад үүрэг хүлээлгэсэн 11 заалт тус тус үйлчилж байна. Өөрөөр хэлбэл Зөрчлийн тухай хуульд нэг заалтаар зөрчил оногдуулахаар заасан боловч бодит байдал дээр нийт 25 заалтыг үндэслэн иргэн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулахаар зохицуулалт үйлчилж байна.

Ялангуяа тус хуулийн 31.1.1 дэх заалтад заасан бусдын нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хохироохгүй байх, өөрийн үзэл бодлыг илэрхийлэхдээ бусдын нэр төр, алдар хүндэд хүндэтгэлтэй хандах, гэмт хэрэг, зөрчилд бусдыг өдөөн хатгахгүй, олон нийтийн аюулгүй байдал, нийтийн хэв журмыг гажуудуулах үйлдэл гаргахгүй байх заалтыг үндэслэн шийтгэл оногдуулах байдал түгээмэл байна. Иймд тус заалтыг хүчингүй болгохоор тусгалаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ...дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИРГЭН ГАДААДАД ХУВИЙН ХЭРГЭЭР ЗОРЧИХ, ЦАГААЧЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуулийн 5 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/5 дугаар зүйл:

"5 дугаар зүйл. Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх

5.1. Монгол Улсын иргэний гадаадад зорчих эрхийг дараах үндэслэлээр доор дурдсан хугацаагаар түдгэлзүүлнэ:

5.1.1. Эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоол үйлдсэн өдрөөс эхлэн уг тогтоолыг хүчингүй болгох, эсхүл хэргийг хэрэгсэхгүй болгох хүртэл;

5.1.2. Эрүүгийн ял шийтгүүлсэн бол уг ялыг эдэлж дуустал, эсхүл ялаас чөлөөлөх тухай шийдвэр гарах хүртэл;

5.1.3. Ял оногдуулахгүйгээр үүрэг хүлээлгэх, эрх хязгаарлах албадлагын арга хэмжээ авсан бол уг хугацаа дуусах, эсхүл шүүхээс уг албадлагын арга хэмжээг хүчингүй болгох хүртэл;

5.1.4. Төрийн болон албаны нууцтай танилцах эрх олгогдсон иргэн, тусгай нөхцөлөөр танилцсан болон нууц хамгаалах чиг үүрэг бүхий болон түүнийг шууд хариуцаж байгаа албан тушаалтан цагаачлах хүсэлт гаргасан бол уг ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн өдрөөс хойш гурван жилийн дотор;

5.1.5. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай<sup>1</sup>, Зөрчил шалган шийдвэрлэх тухай<sup>2</sup>, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай<sup>3</sup> хуульд заасны дагуу гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын шийдвэрт заасан хугацаагаар.

<sup>1</sup> Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 23 дугаарт нийтлэгдсэн

<sup>2</sup> Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн

<sup>3</sup> Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 24 дугаарт нийтлэгдсэн

5.2. Энэ хуулийн 5.1-д зааснаас бусад үндэслэлээр Монгол Улсын иргэний гадаадад зорчих, цагаачлах эрхийг хязгаарлахыг хориглоно.

5.3. Энэ хуулийн 5.1-д зааснаар Монгол Улсын иргэний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэхэд шүүх, прокурор, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, улсын хилээр нэвтрэх үед хилийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хяналт тавина.

5.4. Хилийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн иргэдийн мэдээллийн нэгдсэн санг эрхлэн хөтөлнө.

5.5. Монгол Улсын иргэний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх эрх бүхий байгууллага нь тухайн иргэний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлсэн, сунгасан, хүчингүй болгосон талаарх мэдээллийг Монгол Улсын хил хамгаалах байгууллагад даруй мэдээлнэ.

5.6. Энэ хуулийн 5.5-д заасан мэдээллийг улсын хил хамгаалах байгууллагад мэдээлээгүйгээс үүсэх үр дагаварыг тухайн байгууллага, албан тушаалтан хариуцна."

2/7 дугаар зүйл:

"7 дугаар зүйл. Насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүйд тооцогдсон иргэн гадаадад зорчих

7.1. Насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүйд тооцогдсон иргэн гадаадад зорчихдоо эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хамт явна.

7.2. Насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүйд тооцогдсон иргэн эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчээс өөр хүний хамт гадаадад зорчих тохиолдолд энэ хуулийн 7.1-д заасан этгээдээс насанд хүрээгүй, эсхүл эрх зүйн чадамжгүйд тооцогдсон иргэний хамт гадаад улсад зорчих этгээдэд олгосон итгэмжлэлийг үндэслэн улсын хилээр нэвтрүүлнэ.

7.3. Энэ хуулийн 7.1-д заасан этгээд улсын хилээр хамт нэвтэрсэн насанд хүрээгүй иргэнийг гадаад улсад үлдээсэн тохиолдолд түүнийг асран хамгаалалтад авч үлдсэн хүний талаарх мэдээлэл, тайлбар, нотлох баримтыг улсын хил хамгаалах байгууллагад гаргаж өгнө.

7.4. Энэ хуулийн 7.3-т заасан байгууллага насанд хүрээгүй иргэнийг гадаад улсад үлдээсэн шалтгааныг тодруулж, шаардлагатай гэж үзвэл тухайн асуудлыг цагдаагийн байгууллагад шалгуулахаар шилжүүлнэ.

7.5. Насанд хүрээгүй хүн Монгол Улсын хилээр гарах тохиолдолд хил нэвтрэх эрхийн баримт бичгээс гадна дараахь баримт бичгийг аль тохирохыг үндэслэн улсын хилээр нэвтрүүлнэ.

7.5.1. эцэг, эхийн аль нэгээр овоглоогүй бол гэр бүлийн гишүүний хамт зорчих үед хүүхдийн төрсний гэрчилгээ, түүнийг орлох баримт бичиг;

7.5.2. хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоосон тухай сум, дүүргийн Засаг даргын захирамж, шүүхийн шийдвэр;

7.5.3. олон улсын уралдаан, тэмцээн, урлаг соёлын арга хэмжээ, сурагч, оюутан солилцоогоор сургалтад хүүхэд оролцуулж байгаа сургууль, спорт клуб, урлаг соёлын байгууллагын тухайн нутаг дэвсгэрийн харьяалах цагдаагийн байгууллагын зөвшөөрөл.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагах мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арванзургадугаар зүйлийн 18 дахь хэсэгт "Монгол Улсын иргэн нь улсынхаа нутаг дэвсгэрт чөлөөтэй зорчих, түр буюу байнга оршин суух газраа сонгох, гадаадад явах, оршин суух, эх орондоо буцаж ирэх эрхтэй. Гадаадад явах, оршин суух эрхийг үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд зөвхөн хуулиар хязгаарлаж болно." гэж заасан.

1994 онд баталсан Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх буюу хилийн хоригтой холбоотой асуудлыг хүчин төгөлдөр үйлчилж байгаа тус хуульд үндэслэл, хугацааг тусгасан боловч хилийн хоригийн талаарх мэдээллийг бүрдүүлэхэд эрх бүхий байгууллагуудын олон тусдаа шийдвэрээр баталсан журмууд хэрэгждэг, нэгдсэн бүртгэл байхгүй тул уг үйл ажиллагааг боловсронгуй болгох, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, харилцан мэдээлэл солилцох зохицуулалтыг бий болгох шаардлага байсаар байна.

Иймээс хуульд тусгасан Монгол Улсын иргэний Монгол Улсын хилээр гарах эрхийг түдгэлдүүлэх үндэслэлийг хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөн найрууллаа. Ингэхдээ хуурамч, бусдын паспорт, баримт бичиг ашигласан, эсхүл 2 буюу түүнээс дээш удаа өөрийн буруугаас гадаад паспортаа гэмтээсэн; хаяж үрэгдүүлсэн этгээдийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр 2 жил хүртэл хугацаагаар Монгол Улсын хилээр гарахыг түдгэлзүүлэх зохицуулалт үйлчилж ирснийг хасах боловсрууллаа. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх үндэслэл байгаа эсэхэд нийслэлд улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, орон нутагт цагдаагийн байгууллага хяналт тавих зохицуулалт мөн шаардлагагүй гэж үзсэн болно.

Монгол Улсын иргэн гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлэх, цуцлах үйл ажиллагааг нарийвчлан тусгах, гадаадад зорчих, цагаачлах эрхийг түдгэлзүүлсэн, сунгасан, цуцалсан талаарх мэдээллийн нэгдсэн сан байгуулах, эрх бүхий байгууллагууд харилцан мэдээлэл солилцох журмыг батлах эрхийг Засгийн газарт олгох зохицуулалтыг тусгалаа.

Хууль зүй, дотоод хэргийн яамнаас захиргааны хэм хэмжээний актад хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн тайланг 2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанд танилцуулсан бөгөөд тус хуралдаанаас Засгийн газар, төрийн захиргааны төв болон төрийн захиргааны байгууллагад хуулиар тусгайлан эрх олгосон заалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг даалгасны дагуу Хууль зүй, дотоод



хэргийн салбарт хамаарах Монгол Улсын хүчин төгөлдөр үйлчилж буй 35 хуулиар 160 гаруй дүрэм, журам батлах эрхийг Засгийн газар, Засгийн газрын гишүүн болон агентлаг, байгууллагын даргад олгосон байгааг судалж үзээд тэдгээрийн 50 орчим хувь нь зайлшгүй хуулиар зохицуулах ёстой буюу хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, харилцаанд оролцогчийн эрх, үүргийг тогтоосон буюу процессын шинжтэй зохицуулалт агуулсан байгааг хуулийн төсөл болгон боловсруулж, холбогдох хуулиудад тусгах нь зүйтэй гэж үзсэн болно.

Энэ хүрээнд Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль болон хүүхдийн эрхийг хамгаалах зорилгод нийцүүлэх, хүний эрхэд зөвхөн хуулиар хязгаарлалт тавих Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалыг баримтлан насанд хүрээгүй хүүхдийг улсын хилээр нэвтрүүлэх тухай зохицуулалтыг Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан журмаар зохицуулж байсныг хуулийн төсөлд тусгаж, эрх шилжүүлсэн заалтыг хүчингүй болгохор тусгасан болно.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Төсөл

Улаанбаатар  
хот

ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өмгөөллийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 14.2 дахь хэсэг нэмсүгэй:

"14.2.Энэ хуулийн 14.1.15-д заасан гишүүнчлэлийн хураамжийг сайн дурын үндсэн дээр Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн Холбооны аль нэгд төлнө."

2 дугаар зүйл.Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалтыг хүчингүй болсонд тооцугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

ТАНИЛЦУУЛГА

Өмгөөллийн тухай хуульд  
өөрчлөлт оруулах тухай хуулийн  
төслийн талаар

Улсын Их Хурлаас 2018 оны 10 дугаар сарын 18-ны өдөр иргэдийн хууль зүйн тусалцаа авах, өөрөө өөрийгөө өмгөөлөх эрхийг хангах, өмгөөлөгч, өмгөөлөгчдийн мэргэжлийн өөрөө удирдах ёсны байгууллагын эрх зүйн байдлыг тогтоож, өмгөөллийн үйл ажиллагаа, өмгөөлөгчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах зорилт бүхий Өмгөөллийн тухай хуулийг баталсан.

Тус хуулийн 8 дугаар зүйлд өмгөөлөгчийн шалгалтын талаарх зохицуулалтыг хуульчилж, мөн зүйлийн 8.6 дахь хэсэгт хуульчийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахаас татгалзах үндэслэлийг тусгасан байна. Уг хэсгийн 8.6.3 дахь заалтад "энэ хуулийн 15.1.12, 15.1.13-т заасан өмгөөллийн үйл ажиллагаатай хавсран эрхэлж болохгүй ажил, албан тушаал эрхэлж байгаа;" буюу хууль зүйн чиглэлээр багшлах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил хийх, өмгөөллийн хуулийн этгээд, мэргэжлийн холбоо, түүний хороодын чиг үүрэгт хамаарахаас бусад ажил, албан тушаал хавсран эрхэлж байгаа, эсхүл улс төрийн нам, түүний харьяа, салбар, бүтцийн нэгжид орон тооны ажил, албан тушаал хавсран эрхэлж байгаа хуульчийг өмгөөлөгчийн шалгалтад оруулахгүй байхаар хуульчилжээ.

Дээрх асуудлын иргэний Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргаж Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2022 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 02 дугаар тогтоолоор "Өмгөөллийн тухай хуулийн дээрх заалт нь тухайн мэргэжлийн үйл ажиллагаатай нь холбогдуулан тавьсан нийтлэг хязгаарлалт байх бөгөөд эрх зүйн байдлын хувьд адил тэгш этгээдүүдэд зүй бус ялгаварлал, алагчилсан байдал үүсгэсэн гэж үзэх үндэслэлгүй байна." гэж дүгнэсэн байдаг.

Тус тогтоолд Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч маргааныг шалгах явцад ирүүлсэн тайлбар болон Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Өмгөөллийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.6.3 дахь заалт нь Үндсэн хуульд заасан ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох эрхийг хязгаарласан байх магадлалтай гэж хүлээн зөвшөөрсөн болно. гэжээ.

Иймд иргэний гаргасан мэдээлэл, Үндсэн хуулийн цэцийн тогтоол, Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн тайлбарыг үндэслэн Өмгөөллийн тухай хуулийн дээрх заалтыг хүчингүй болгох нь зүйтэй гэж үзсэн болно.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН  
ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2. дахь хэсгийн "заавал хянана." гэснийг "хянаж болно. гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2.3 дахь заалтын "онц аюултай гэмт хэрэгтэн, түүнчлэн" гэснийг, 35 дугаар зүйлийн 35.4 дэх хэсгийг тус тус хассугай.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХАРИЛЦАА ХОЛБООНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Харилцаа холбооны тухай хуулийн дараах хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсэг:**

"8.3.Зохицуулах хорооны дарга, гишүүнийг Ерөнхий сайд томилох бөгөөд гишүүнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, харилцаа холбооны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тус 2, Худалдаа, аж үйлдвэрийн танхим, иргэний нийгмийн төлөөллөөс тус бүр 1 нэр дэвшигчийг санал болгоно."

**2/8 дугаар зүйлийн 8.6, 8.6<sup>1</sup> дахь хэсэг:**

8.6.Зохицуулах хорооны гишүүнээр дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг нээлттэй сонгон шалгаруулалтын үндсэн дээр томилно:

8.6.1.харилцаа холбоо, мэдээллийн технологи, эдийн засаг, эрх зүйн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;

8.6.2.харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт мэргэжлээрээ 8-аас доошгүй жил ажилласан байх;

8.6<sup>1</sup>.1.Зохицуулах хорооны даргаар дараах шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнийг томилно:

8.6<sup>1</sup>.1.1.харилцаа холбоо, мэдээллийн технологийн чиглэлээр магистр болон түүнээс дээш зэрэгтэй;

8.6<sup>1</sup>.1.1.харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбарт 12-оос доошгүй жил, үүнээс 5-аас доошгүй жил удирдах албан тушаалд ажилласан байх.

8.6.2.Зохицуулах хорооны дарга, гишүүн нь үйлчлэгчийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаар эзэмшигч, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд байж болохгүй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

202... оны дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

ХӨДӨЛМӨРИЙН ТУХАЙ ХУУЛЬД  
НЭМЭЛТ,ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хөдөлмөрийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

**1/50 дугаар зүйлийн 50.1.7 дахь заалт:**

"50.1.7."онцгой нөхцөл бүхий ажил үүрэг гүйцэтгүүлэх."

**2/65 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

"65.6."Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний хугацаа таван жилээс илүүгүй байна."

**3/109 дүгээр зүйлийн 10 дахь хэсэг:**

"109.10. "Илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс, шагнал урамшууллыг оруулахгүй".

**4/157 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

157.2.Хөдөлмөрийн эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлэх байгууллагад хандан энэ хуулийн 154 дүгээр зүйлийн 154.2.1, 154.2.2-т заасан хугацаанд багтаж гомдол гаргасан тохиолдолд шүүхэд гомдол гаргах хугацаа зогсоно.

**2 дугаар зүйл.**Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-д дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/50 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

"50.4."Энэ хуулийн 50.1.6, 58.1.3, 139.1-д зааснаас бусад тохиолдолд хугацаатай байгуулсан гэрээний анх байгуулсан болон сунгасан хугацааны нийлбэр хоёр жилээс дээш бол уг гэрээг хугацаагүй байгуулагдсанд тооцно."

**2/83 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

"83.4."Ажил олгогч ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон тухай шийдвэрийг ажил хүлээлцэхээс өмнө бичгээр гаргаж, ажилтанд

танилцуулж, уг шийдвэрийн нэг хувийг хүлээлгэн өгнө. Хэрэв ажилтан тухайн шийдвэрийг хүлээн авахаас татгалзсан бол шийдвэрийг ажилтанд (утасны дугаар, цахим шуудангийн хаяг, оршин суугаа хаягт шуудангаар хүргүүлсэнээр) мэдэгдсэнээр ажилтан тухайн шийдвэртэй танилцсанд тооцно."

**3/144 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:**

"144.4."Хөгжлийн бэрхшээлтэй хүний байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагын нийт ажилтны дийлэнх нь хөгжлийн бэрхшээлтэй аж ахуйн нэгж, байгууллагын эсхүл хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүнээ гэртээ асарч байгаа хүний үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр байнга худалдан авах зэргээр тэдний үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлсэн ажил олгогчийг энэ хуулийн 144.3-т заасан төлбөрөөс чөлөөлж, эсхүл хөнгөлж болно."

**4/154 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

"154.3.Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комисс, сум, дүүргийн хөдөлмөрийн эрхийн маргаан зохицуулах гурван талт хороо гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор эвлэрч маргааныг шийдвэрлэхэд нь туслах, дэмжлэг үзүүлэх зорилгоор тэднийг оролцуулан урьдчилан шийдвэрлэх ажиллагааг хэрэгжүүлнэ."

**5/154 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:**

"154.6.Энэ хуулийн 154.5-д заасан хөдөлмөрийн эрхийн маргаан таслах комиссын тэмдэглэлийг хүлээн авснаас хойш ажлын 10 өдрийн дотор маргалдагч аль нэг тал шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй."

**6/154 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг:**

"154.8 Энэ хуулийн 154.7-д заасан сум, дүүргийн ХЭМЗГТХ-ны шийдвэрийг эс зөвшөөрвөл түүнийг хүлээж авснаас хойш ажлын 10 өдрийн дотор маргалдагч аль нэг тал шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй."

**3 дугаар зүйл.**Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 156 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн "156.3-т заасан" гэсний дараа "ажилтны" гэж нэмсүгэй.

**4 дүгээр зүйл.**Хөдөлмөрийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсгийн "Эдгээр байгууллагаас хүн амд үзүүлэх наад захын үйлчилгээний хэмжээг Үндэсний хорооны саналыг харгалзан Засгийн газар батална." гэснийг "Эдгээр байгууллагын ажилтан, албан хаагч ажил хаях болон ажлын байр түр хаах /локаут/ үед хүн амд үзүүлэх наад захын хэмжээг хангах үүрэгтэй." гэж өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 28.1 дэх хэсгийн "Нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг Үндэсний хорооны саналыг харгалзаж Засгийн газар батална.", 50.4 дэх хэсэг, 123.2.4 дах заалт, 64.4 дэх хэсгийн "... ,эсхүл түр ажлын байранд" гэснийг тус тус хассүгэй.

6 дугаар зүйл. Энэ хуулийг 2024 оны ... дүгээр сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хөдөлмөрийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ 2021 онд батлагдаж, 2022 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдөгдөж байна. Уг хууль шинэчлэгдэн батлагдсанаар хуулийн хамрах хүрээ өргөжиж, хүний эрхийг хамгаалсан, хөдөлмөрийн маргаан шийдвэрлэх тогтолцоо боловсронгуй болсон зэрэг олон онцлог зохицуулалттай болсон.

Монгол Улс олон улсын хөдөлмөрийн байгууллагын 21 конвенцийг соёрхон батлаад байгаа бөгөөд холбогдох конвенциудад нийцүүлэх зорилготойгоор Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай. Тухайлбал, Монгол Улсын нэгдэн орсон "Тэгш шан хөлс олгох тухай" 100 дугаар конвенцид нийцүүлэн хүйсийн ялгааг үл харгалзан ажлын бодит үнэлгээний дагуу цалин хөлс олгох зохицуулалт төсөлд тусгана.

Ажилтан, аж ахуйн нэгж, байгууллагаас хуулийг хэрэгжүүлэх явцад хуулийг нэг мөр хэрэглэх, ойлголтыг нэгтгэх хэрэгцээ шаардлага үүсэж байна. Үүнтэй холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

1. Аж ахуйн нэгж, байгууллагын удирдах ажилтантай гүйцэтгэх удирдлагын түвшний ажил үүрэг гүйцэтгүүлэхээр тохирч байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг хөдөлмөрийн хугацаатай гэрээний төрөлд хамруулж, хугацааг 5 жил хүртэл байхаар тусгалаа.

2. Аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийг 1-10 жил хүртэл хугацаагаар харилцан адилгүй хэрэгжүүлдэг. Үүнтэй холбоотойгоор санхүүжилт, хийгдэх ажлын цар хүрээтэй холбоотой цаг хугацаагаар хязгаарлагдсан ажил үүрэг гүйцэтгэж байгаа ажилтны хөдөлмөрийн гэрээний хугацааны үргэлжлэл 2 жилээр хязгаарлахгүй байхаар хуулийн 50.4-т өөрчлөлт оруулахаар боловсрууллаа.

3. Ажил олгогчоос хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгосон тухай гаргасан шийдвэрийг ажилтан хүлээн авахаас татгалзсан бол шийдвэрийг ажилтанд (утасны дугаар; цахим шуудангийн хаяг, оршин суугаа хаягт шуудангаар хүргүүлснээр) мэдэгдсэнээр ажилтан тухайн шийдвэртэй танилцсанд тооцно.

4. Цалин хөлсийг тооцох аргачлалыг боловсронгуй болгож, илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны нэмэгдэл хөлсийг тооцох дундаж цалин хөлсний бүрэлдэхүүнд нэмэгдэл хөлс, шагнал урамшууллыг оруулахгүй. Ингэснээр илүү цаг, шөнийн цаг, долоо хоногийн амралтын өдөр, нийтээр амрах баярын өдөр ажилласан ажилтны цалин хөлсийг бодох аргачлал тодорхой болно.

5. Аж ахуйн нэгж, байгууллагын хүний нөөцөөс "албан тушаал бууруулах" гэсэн хөдөлмөрийн сахилгын шийтгэл нь аж ахуйн нэгж, байгууллагад хэрэглэхэд хүний нөөцийн хувьд ажилтнуудыг шилжүүлэх, ажлын байрны хувьд шинэ ажлын байр нэмэх зэрэг хүндрэл учруулж байгаа талаар санал ирүүлсэн. Үүнтэй холбоотойгоор Хөдөлмөрийн тухай хуулийн 123 дугаар зүйлийн 123.2.4-т заасан "албан тушаал бууруулах" гэсэн хөдөлмөрийн сахилгын шийтгэлийг хасахаар тусгалаа.

6. Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах төрийн бус байгууллагаас удаа дараа гаргаж байгаа санал, хүсэлтийн дагуу Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн 144.4 дэх хэсэгт өөрчлөлт оруулах санал боловсрууллаа. Өөрөөр хэлбэл, хөгжлийн бэрхшээлтэй хүн гэснийг өөрчилж, хөгжлийн бэрхшээлтэй хүний байгуулсан аж ахуйн нэгж, байгууллагын, нийт ажилтны дийлэнх нь хөгжлийн бэрхшээлтэй аж ахуйн нэгж, байгууллагын үйлдвэрлэсэн бараа, бүтээгдэхүүн, ажил үйлчилгээг гэрээгээр худалдан авч байгаа ажил олгогчийг хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ажиллуулаагүй төлбөрөөс зохих журмын дагуу хөнгөлж, эсхүл чөлөөлнө.

7. Ажилтан хөдөлмөрийн маргаан таслах комиссоор шийдвэрлэсэн хөдөлмөрийн эрхийн маргааныг хүлээн зөвшөөрөөгүй тохиолдолд шууд шүүхэд хандаж шийдвэрлүүлэх боломжтой байхаар заасан.

8. Ажилтны шүүхэд хандах эрхийн хангах зорилгоор хуулийн 157.2-т Хөдөлмөрийн эрхийн маргааныг урьдчилан шийдвэрлэх байгууллагад хандан хуульд заасан хугацаанд багтаж гомдол гаргасан тохиолдолд шүүхэд гомдол гаргах хугацаа зогсоно.

9. Төрийн албаны тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль зэрэг хуулиудаар ажил хаялт санаачлах, зохион байгуулах, түүнд оролцохыг хориглосон байгууллагын ажилтныг тодорхойлсон учир Хөдөлмөрийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсгийн "Нэн шаардлагатай үйлчилгээ үзүүлдэг аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалтыг Үндэсний хорооны саналыг харгалзаж Засгийн газар батална." гэснийг хүчингүй болсонд тооцохоор хуулийн төсөлд тусгасан.

Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөлд 4 хэсэг шинээр нэмж, 8 хэсгийг өөрчлөн найруулж, 1 хэсэгт нэмэлт оруулж, 3 хэсэг, заалтыг хасахаар төсөл боловсрууллаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ЗҮЙН ТУСЛАЛЦААНЫ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хууль зүйн туслалцааны тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/6 дугаар зүйлийн 6.1.7 дахь хэсэг:**

"6.1.7.хамгаалалтад байгаа гэрч, хохирогч;

6.1.8.төрөлжсөн асрамжийн газарт асруулагч ахмад настан, хүүхдийн тэтгэвэр, тэтгэмжтэй холбоотой хэрэг маргаан."

#### **2/6 дугаар зүйлийн 6.4, 6.5, 6.6 дахь хэсэг:**

"6.4.Энэ хуульд заасан "Ахмад настан" гэж Ахмад настны эрхийн тухай хуулийн 3.1-д заасан хүнийг, "хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн" гэж Эмнэлэг, хөдөлмөрийн магадлах комиссын дүрэмд заасан хүнийг, "өрх толгойлсон эцэг, эх" гэж Нийгмийн халамжийн тухай хуулийн 3.2.8-д заасан хүнийг, "олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх" гэж, Олон хүүхэдтэй эцэг, эхэд тэтгэмж олгох тухай хуулийн 6.4-т заасныг, "гадаадын иргэн" Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 5.1.1, "харьяалалгүй" хүн гэж 5.1.7-д заасныг тус тус ойлгоно.

6.5.Тухайн улстай байгуулсан олон улсын гэрээнд заасан бол төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүнд энэ хуулийн 6.1.5-д зааснаас бусад хууль зүйн туслалцааг түүний бичгээр гаргасан хүсэлтийг үндэслэн энэ хуульд заасан журмын дагуу үзүүлж болно.

6.6.Хууль зүйн туслалцааны байгууллага нь энэ хуульд зааснаас бусад мэдээ, мэдээлэл баримт шаардахыг хориглоно."

#### **3/7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалт:**

"7.1.3.Гадаадын иргэний бол тухайн улсын харьяалах дипломат төлөөлөгчийн газрын тодорхойлолт, харьяалалгүй хүний өөрийн хүсэлт."

**2 дугаар зүйл.**Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалтын "төлбөрийн чадваргүй" гэсний өмнө "Эрүүгийн хэргийн" гэж, мөн зүйлийн 6.6 дахь хэсгийн туслалцаа үзүүлнэ." гэсний дараа "Монгол Улс тухайн гадаадын

иргэний харьяалах улстай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан бол уг гэрээнд заасан хүрээнд туслалцаа үзүүлнэ." гэж, 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсгийн "улсын бүртгэлийн мэдээллийн сан" гэсний дараа "Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 4.1.7-д заасан нийгмийн даатгалын мэдээллийн сан" гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.8 дахь хэсгийн "төлбөрийн чадвартай болох нь" гэснийг "энэ хуульд заасан шаардлага хангаагүй нь" гэж тус тус өөрчилсүгэй.

**4 дүгээр зүйл.**Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтын "төлбөрийн чадваргүй" гэснийг, 14 дүгээр зүйлийн 14.1.6 дахь заалтын "журам болон хууль зүйн туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд дагаж мөрдөх бусад дүрэм, " гэснийг тус тус хассугай.

**5 дугаар зүйл.**Хууль зүйн туслалцааны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.7 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.12 дахь хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1.5 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**6 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



## ТАНИЛЦУУЛГА

### Хууль зүйн туслалцааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Улсын Их Хурлаас 2022 оны 7 дугаар сарын 21-ний өдөр Төлбөрийн чадваргүй яллагагчид хууль зүйн туслалцаа үзүүлэх тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулга буюу Хууль зүйн туслалцааны тухай хуулийг Улсын Их Хурлаас баталж 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөж байна.

Хууль зүйн туслалцааны тухай хуульд зааснаар улсын өмгөөллийн үйлчилгээг зөвхөн төлбөрийн чадваргүй яллагагчаар хязгаарлахгүйгээр, доор дурдсан хүнд өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлж байна:

- Эрүүгийн хуулийн Арван хоёрдугаар бүлэг /Хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг/, Арван дөрөвдүгээр бүлгийн 14.1 дүгээр зүйл /Ялгаварлан гадуурхах/, Арван зургадугаар бүлэг /Хүүхдийн эсрэг гэмт хэрэг/-т заасан гэмт хэргийн 18 насанд хүрээгүй хохирогч, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан;
- Эрүүгийн хуулийн 11.7 дугаар зүйл /Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх/, 13.1 дүгээр зүйл /Хүн худалдаалах/-д заасан гэмт хэргийн хохирогч төлбөрийн чадваргүй, эсхүл хохирогч нь 18 насанд хүрээгүй бол түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч хүсэлт гаргасан, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгч хүсэлт гаргасан;
- төлбөрийн чадваргүй сэжигтэн, яллагагч, шүүгдэгч, ялтан;
- хүүхдийн тэтгэлэг гаргуулах нэхэмжлэгч төлбөрийн чадваргүй бол;
- үл хөдлөх эд хөрөнгө, газар өмчлөх эрх нь зөрчигдсөн захиргааны хэргийн оролцогч төлбөрийн чадваргүй бол;
- Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4.1.1-д заасан эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд.

Харин Гэмт хэргийн гэрч хүүхэд, Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйл /Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль зөрчих/, 6.20 дугаар зүйл /Хүүхдийн эрхийг зөрчих/-д заасан зөрчлийн улмаас эрх нь зөрчигдсөн хүүхэд, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн хүсэлт, эсхүл шаардлагатай тохиолдолд хүүхэд хамгаалах байгууллага, нийгмийн ажилтан, мөрдөгч, прокурор, шүүгчийн хүсэлтээр өмгөөллийн үйлчилгээ үнэ төлбөргүй үзүүлж болохоор заасан.

Мөн Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад байгаа гэрч, хохирогч болон хүүхдийн тэтгэлэг гаргуулах маргаанд нэхэмжлэгчээр, үл хөдлөх эд хөрөнгө, газар өмчлөх эрх нь зөрчигдсөн захиргааны маргаанд ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх хууль зүйн туслалцаа авч болох зохицуулалт тус тус үйлчилж байна.

Хууль зүйн туслалцааны тухай хууль нь Монгол Улсын хууль, олон улсын гэрээнд заасан эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн, хөндөгдсөн хүний хууль зүйн туслалцаа авах эрхийг хангах, төрөөс хууль зүйн туслалцааг үнэ төлбөргүй үзүүлэх хүрээ, тогтолцоо, зохион байгуулалт, эрх зүйн үндсийг тогтоох зорилготой боловч мөн хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэгт зааснаар "...хууль зүйн туслалцааг хуульд харшлахгүй арга, хэлбэрээр явуулах бөгөөд хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална." гэж хууль зүйн туслалцаа үзүүлэх үндсэн процедурын асуудлыг хуульчлалгүй журмаар, төлбөрийн чадваргүй гадаадын иргэн, харьяалалгүй хүн, ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг сайд нарын баталсан журмаар зохицуулж байна.

2023 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн Засгийн газрын хуралдаанаас хуулиар тусгайлан эрх олгосон заалтад дүн шинжилгээ хийж, холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулахыг сайд нарт даалгасан. Иймд хүний эрх, эрх чөлөөг хөндсөн, харилцаанд оролцогчийн эрх, үүргийг тогтоосон буюу процессын шинжтэй зохицуулалт агуулсан, журмаар зохицуулсан харилцааг тухайн хуульд тусгай боловсруулах шаардлага бий болсон.

Ийнхүү хууль зүйн туслалцаа үзүүлэх журам, мөн нийгмийн эмзэг бүлгийн хүмүүст үнэ төлбөргүй үзүүлэх хууль зүйн туслалцааны төрөл, хүртээмжийг нэмэгдүүлэх, ахмад настан, хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан хүн, олон хүүхэдтэй өрх толгойлсон эцэг, эх хуульд заасан хэрэг, маргаанд хууль зүйн туслалцаа үзүүлэхтэй холбоотой журмаар зохицуулж байсан харилцааг хуулийн төсөлд тусгаж, холбогдох эрх олгосон заалтыг хүчингүй болгохоор хуулийн төсөл боловсрууллаа.

Түүнчлэн олон улсын хүний эрхийн гэрээ конвенцоор гэрч, хохирогчийг хамгаалах, ялангуяа гэрч, хохирогч хүүхдийг хамгаалах, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлэх асуудлыг төрөөс баталгаажуулахыг байнга зөвлөсөөр ирсэн болно.

Иймд хамгаалалтад байгаа гэрч, хохирогчид хууль зүйн туслалцаа үзүүлж болох агуулгаар тусгасныг заавал үзүүлэхээр өөрчилж, мөн хүн худалдаалах гэмт хэргийн насанд хүрсэн хохирогч нь төлбөрийн чадваргүй тохиолдолд л туслалцаа үзүүлэхээр заасаныг энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийг заавал төлбөрийн чадваргүй байхыг шаардахгүй байхаар өөрчлөн хуулийн үйлчлэлд хамаарах этгээдийн хүрээ хязгаарыг өргөжүүлж хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэхэд анхаарч боловсрууллаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

Төсөл

ТАНИЛЦУУЛГА

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны... дугаар  
сарын ... ны өдөр

Улаанбаатар  
хот

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

ХУУЛЬЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн дараах зүйл,  
заалтыг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт:

"11.1.1.шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүгч, прокурор,  
нотариатч, өмгөөлөгчийн туслах;"

2/55 дугаар зүйл:

"55 дугаар зүйл.Хуульчийн сургалт зохион байгуулах

55.1.Хуульчийн үргэлжилсэн болон ёс зүйн сургалтыг жилд нэгээс доошгүй удаа  
зохион байгуулна.

55.2.Хуульчийн үргэлжилсэн сургалтын агуулга нь Монгол Улсын олон улсын  
гэрээ, конвенц, шинээр батлагдсан хууль тогтоомжийг таниулах, хуульчийн  
мэргэжлийн ур чадвар, мэдлэг, ёс зүйг нэмэгдүүлэх, хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх  
дадал төлөвшүүлэхэд чиглэгдэнэ."

3/62 дугаар зүйлийн 62.6 дахь хэсэг:

"62.6.Монголын Хуульчдын холбооны гишүүдийн татвар, Монголын  
Өмгөөлөгчдийн Холбооны гишүүнчлэлийн хураамжийг давхардуулан авахгүй."

2 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж  
мөрдөнө

Гарын үсэг

Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох эрх бүхий хуульчдад /шүүгч,  
прокурор, өмгөөлөгч, нотариатч, бусад хуульч/ олон улсын гэрээ конвенцын ойлголт  
мэдлэгийг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ, уг асуудлыг хуульчийн үргэлжилсэн  
сургалтын хөтөлбөрт тусгах хөшүүрэг бий болгохоор хуулийн 55 дугаар зүйл буюу  
хуулийн үргэлжилсэн сургалт зохион байгуулах гэсэн хэсэгт хуульчийн үргэлжилсэн  
сургалтын агуулга нь Монгол Улсын олон улсын гэрээ, конвенц, шинээр батлагдсан  
хууль тогтоомжийг таниулах, хуульчийн мэргэжлийн ур чадвар, мэдлэг, ёс зүйг  
нэмэгдүүлэх, хуулийг нэг мөр ойлгож хэрэглэх дадал төлөвшүүлэхэд чиглэгдэх агуулга  
бүхий зохицуулалт нэмэхээр боловсрууллаа.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2019 онд баталсан Өмгөөллийн тухай  
хууль, Өмгөөллийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд Өмгөөллийн  
тухай хууль баталсантай холбогдуулан Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийг  
боловсронгуй болгох, өмгөөлөгч давхар гишүүнчлэлийн татвар, хураамж төлдөггүй  
байхаар холбогдох хуулийн төслийг боловсруулахын Засгийн газарт даалгасны дагуу  
хуульч, өмгөөлөгчийн хураамжийг сайн дурын үндсэн дээр аль нэг байгууллагад  
төлдөг болох зохицуулалтыг бий болгохоор тусгалаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

ТАНИЛЦУУЛГА

Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын  
тухай хуульд нэмэлт оруулах тухай

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН  
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.27 дахь заалтын "хэрэгжүүлснээр" гэсний дараа "хүний эрх," гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Монгол Улс 1961 онд Нэгдсэн Үндэстний Байгууллагад элсэн орсноос хойш Нэгдсэн Үндэстний Байгууллага болон түүний гшүүн байгууллагуудаас батлан гаргасан хүний эрх, эрх чөлөөтэй холбоотой 70 гаруй гэрээнд нэгдэн ороод байна. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблейн тогтоолоор батлагдсан Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын Пактаар хүний хувийн халдашгүй байдлын эрхийг баталгаажуулсан байдаг бөгөөд энэхүү эрхийн хүрээнд хүний орон байр, өмч нь халдашгүй байхаар хамгаалагдсан.

Хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх явцад иргэний өмчид халдах, албадан нүүлгэх үйл ажиллагаа явагддаг бөгөөд энэхүү ажиллагаанд хүний хувийн халдашгүй байдал буюу хүний өмч халдашгүй байх, орон байр халдашгүй байх эрх хөндөгддөг.

Иймд хөгжлийн төлөө төсөл хөтөлбөр хэрэгжүүлэхдээ үүсч болох эрсдэл, хохиролыг бууруулах үүднээс тухайлан хүний эрхийн судалгаа хийхээр Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслийг боловсрууллаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

2024 оны... дугаар  
сарын ... ны өдөр

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

Төсөл

Улаанбаатар  
хот

### АГААРЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Агаарын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалт, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийг "тайлагнах;" гэснийг "тайлагнаж, олон нийтэд мэдээлэх;" гэж, 9.1.5 дахь заалтын "өгөх;" гэснийг "өгч, олон нийтэд мэдээлэх гэж," тус тус өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

Агаарын тухай хуульд өөрчлөлт  
оруулах тухай хуулийн төсөл

НҮБ-ын Хүний эрхийн хорооны 19 дүгээр хуралдааны 10 дугаар ерөнхий тайлбарт төрийн байгууллагад байгаа мэдээллийг олж авах эрхийг хөхиүлэн дэмжинэ. Хадгалж буй арга хэлбэр, эх сурвалж, мэдээлэл үүссэн цаг хугацаанаас үл хамааран төрийн байгууллагад авагдсан бүх төрлийн баримтыг энэ төрийн мэдээлэл гэж үзнэ. Төрийн байгууллага гэдэгт төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг нийтийн эрх зүйн хуулийн этгээдийг мөн оруулж ойлгоно. Мэдээлэл авах эрхийг хангахын тулд улс нийтийн ашиг сонирхолд хамаарах өөрт байгаа мэдээллийг өөрийн санаачлагаар ил болгож, олон нийт хялбар, шуурхай, үр дүнтэй, бодитой танилцах боломжийг бүрдүүлнэ. Мэдээлэл өгөхгүй бол мэдээлэл өгөхөөс татгалзсан шийдвэрийнхээ үндэслэлийг тайлбарлах үүрэгтэй байхаар тайлбарласан байдаг.<sup>1</sup>

Монгол Улсын Үндсэн хуулийн Арвандолдугаар зүйлийн 7 дахь хэсэгт төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй байхаар заасан.

Түүнчлэн Улсын Их Хурлаас 2021 онд хуульд заасан үндэслэл, журмын дагуу иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, нийтийн мэдээллийн дэд бүтцийн эрх зүйн үндсийг тогтоох, төрийн үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилго бүхий Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийг батлан хэрэгжиж байна.

Иймд иргэдийн мэлээлэл авах эрхийг хангах, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд мэдээлэл ил тод, нээлттэй байх зарчмыг баримтлах шаардлагаар Агаарын ухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэрэгжилтийг жил бүр Улсын Их Хуралд тайлагнах, 15 дугаар зүйлийн 15.7 дахь хэсгийн Аймаг, нийслэлийн Засаг дарга агаарын бохирдлыг бууруулах арга хэмжээг нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд зохион байгуулах, хэрэгжилтийг тайлагнах, 9 дүгээр зүйлийн 9.1.5 дахь заалтын аж ахуйн нэгж, байгууллага нь агаарын бохирдлын эх үүсвэрийн дотоод хяналтын болон холбогдох бусад тайлан, мэдээг энэ хуулийн 12.5-д заасан журмын дагуу мэргэжлийн албаны орон нутаг дахь салбарт гаргаж өгөх үүргийг хүлээхээс гадна дээрх тайлан мэдээг олон нийтэд заавал мэдээлэх агуулгыг нэмэхээр тусгалаа.

## ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

<sup>1</sup> Үндсэн хууль манай сургуульд НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар, сургалтын хөтөлбөр 143 дугаар хуудас

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

ДАЙЧИЛГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5.8 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

Төсөл

Улаанбаатар  
хот

ТАНИЛЦУУЛГА

Дайчилгааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

НҮБ-ын Хүний эрхийн хорооноос үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөнд зайлшгүй бус, тохиромжгүй хязгаарлалт тогтоохгүй байхыг зөвлөдөг.<sup>1</sup>

Манай улсын хувьд Онц байдлын тухай хуульд заасны дагуу олон нийтийн онц байдал тогтоосон хугацаанд мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох, эсхүл онц байдлыг цуцлах хүртэл үйл ажиллагааг нь зогсоох нэмэлт онцгой арга хэмжээ тогтоож болох зохицуулалт үйлчилдэг. Өөрөөр хэлбэл мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоох нэмэлт арга хэмжээг авч болно эсхүл авахгүй ч байж болно гэсэн агуулгаар тусгасан байдаг.

Гэтэл Дайчилгааны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.5 дахь заалтад улсын дайчилгаа явуулахад хэвлэл мэдээллийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулах үйл ажиллагааг үндсэн арга хэмжээ болгон хэрэгжүүлэхээр заасан.

Хэвлэл, мэдээллийн эрх чөлөөний тухай хуульд "Хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглоно.", "Төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тогтоохгүй" байхаар тус тус заасан. Иймд Дайчилгааны тухай хуулийн дээрх заалтыг хүчингүй болгохоор тусгалаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ

<sup>1</sup> Үндсэн хууль манай сургуульд. НҮБ-ын Хүний эрхийн хороодын ерөнхий тайлбар. 2022 он 155 дугаар хуудас

**БАТЛАВ  
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД  
ХЭРГИЙН САЙД**



**Б.ЭНХБАЯР**

**ЖАГСААЛ, ЦУГЛААН ХИЙХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН  
ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

Хууль зүйн үндэслэл:

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “эх орныхоо тусгаар тогтнолыг батлан хамгаалж, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журмыг хангах нь төрийн үүрэг мөн.” гэж, Арван зургадугаар зүйлийн 16 дахь заалтад “Монгол Улсын иргэн итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно” гэж, Арван долдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтад “Монгол Улсын иргэн шударга, хүнлэг ёсыг эрхэмлэн хүний нэр төр, алдар хүнд, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх үндсэн үүрэгтэй.” гэж, “Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” гэж тус тус заасан.

Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.4.3 дахь заалтад заасны дагуу иргэдийн эрх, эрх чөлөөний аюулгүй байдал нь үндэсний аюулгүй байдлын бүрэлдэхүүн хэсэг байхаар, Эрүүгийн хуулийн 1.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 5.5.7-д “Засаглалын үйл ажиллагаанд иргэд эрх тэгш оролцон үзэл бодлоо илэрхийлэх, эвлэлдэн нэгдэх боломж, чадавхыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлэх орчныг бүрдүүлнэ.” гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.4.11-д “Монгол Улсын Үндсэн хуульд заасан иргэний шашин шүтэх, эс шүтэх эрх чөлөө, эвлэлдэн нэгдэх болон мэдээлэл авах эрхээ хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг сайжруулна.” гэж заасан.

Практик шаардлага:

Монгол Улсын Их Хурлаас Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийг 1994 онд анх баталсан бөгөөд түүнээс хойш нийт таван удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Тухайлбал, 2006 онд Сүхбаатарын талбайд хоноглох, гэр, майхан, унаа хөсөг оруулахгүй байх зохицуулалт нэмсэн, 2015 онд жагсаал, цуглаан зохион байгуулахад зөвшөөрөл олгодог байсныг мэдэгдэл хүргүүлэх, гэхдээ хариу заавал авах зохицуулалттай болгосон, 2015 онд Зөрчлийн тухай хууль батлагдсантай холбогдуулан өөрчлөлт оруулсан, 2017 онд Гамшгаас хамгаалах тухай хууль батлагдсантай холбогдуулан гамшиг, аюулт үзэгдэл, ослын үед хориглох хүрээг өргөжүүлсэн агуулгаар өөрчилсөн, 2014 онд жагсаал, цуглааныг албадан тараах үйл ажиллагаанд зөвхөн дотоодын цэргийн нэмэлт хүч хэрэглэхээр заасныг үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудаас дэмжлэг авч болох тухай, 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр жагсаал, цуглааныг зохион байгуулах мэдэгдлийг бичгээр хүргүүлэх зохицуулалтыг бичгээр болон цахимаар хүргүүлэх зэрэг өөрчлөлтийг тус тус оруулсан байдаг.

Дээрх нэмэлт, өөрчлөлтүүдээс харахад бүхэлдээ үзэл бодлоо илэрхийлэх, жагсах, цуглах эрхийг хязгаарлах чиглэлээр, албадан тараах үйл ажиллагаанд хүч нэмэгдүүлсэн агуулгаар шинэчлэгдэж ирсэн гэж үзэж болохоор байна.

Монгол Улсад жагсаал, цуглаан зохион байгуулагдаж ирсэн тоо баримтыг сүүлийн 8 жилийн байдлаар авч үзвэл 2014 онд 115, 2015 онд 140, 2016 онд 121, 2017 онд 128, 2018 онд 180, 2019 онд 206, 2020 онд 255, 2021 онд 214, 2022 онд 241 удаагийн жагсаал, цуглааныг иргэд, олон нийтийн зүгээс зохион байгуулж, мөн цагдаагийн байгууллага хуулиар хүлээсэн үүргийн дагуу уг үйл ажиллагааг болон оролцогчдын аюулгүй байдал, дэг журмыг хангуулан ажиллажээ.

2014-2022 онд иргэд нийт 38 удаа өлсгөлөн зарлаж Эрүүл мэндийн сайдын 2010 оны 233 дугаар тушаалаар баталсан "Өлсгөлөнгийн үед эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх заавар"-ын дагуу эмнэлгийн тусламж үйлчилгээг үзүүлсэн тоон үзүүлэлттэй байна. Түүнчлэн, сум, дүүргийн Засаг даргаас сүүлийн 2 жилд 214 жагсаал, цуглаан зохион байгуулахыг хүссэн бичигт цар тахлын үеийн дүрэм, журмын зохицуулалттай холбоотойгоор татгалзсан хариуг өгсөн байдаг.

Жагсаал, цуглааны тоо өсөхийн хэрээр зохион байгуулагдах хэлбэр, хүрээ хязгаар нь ч харилцан адилгүй болж байгаа бөгөөд ийнхүү шинээр үүсэж байгаа нөхцөлд нийцсэн зохицуулалт дутагдаж байна. Иргэний тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг баталгаажуулах ёстой хуулийн зарим зохицуулалтууд нь өөрөө хүний эрхийг хязгаарлах, зөрчих үндэслэл нь болж байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээгээр тулгамдаж байгаа дараах асуудлуудад дэвшилтэт зохицуулалтыг бий болгох шаардлагатай гэж дүгнэсэн:

1. Иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх эрхийн хэрэгжилт нь тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй салшгүй холбоотой. Нийгмийн харилцааны өөрчлөлтөд үндэслэн гудамж, талбайд жагсаал цуглаан зохион байгуулахад зөвшөөрөл олгодог хуулийн зохицуулалтыг өөрчилж, бүртгэлийн зохицуулалттай

болгох зорилгоор Улсын Их Хурлаас 2005 онд нэмэлт, өөрчлөлтийг баталсан боловч жагсаал, цуглаан зохион байгуулахдаа Засаг даргаас мэдэгдэл авдаг тогтолцоо нь "зөвшөөрлийн тогтолцоо"-той адил байдлаар хэрэглэгдэж, иргэдийн тайван жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлаж байна.

Түүнчлэн, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад "Тайван хуран цуглах эрхийг хүлээн зөвшөөрнө. Энэхүү эрхийг эдлэхэд ардчилсан нийгэмд үндэсний буюу нийгмийн аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах, эрх ашгийн үүднээс хуулийн дагуу тогтоосноос өөр хязгаарлалт хийж болохгүй." гэж заасан.

Ийнхүү жагсаал, цуглаан хийх эрх нь зөвхөн нийтийн дэг журмыг хөндөхүйц бодитой үндэслэл байвал хязгаарлагдаж болох хэдий ч захиргааны байгууллагаас "зөвшөөрөхгүй байх үндэслэл"-ийг хэт өргөн утгаар тайлбарлаж, жагсаал цуглаан хийх эрхийг хязгаарлаж байна. Түүнчлэн, цар тахлын эсрэг холбогдох хуулиудаар нийслэлийн Засаг даргад тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөг хязгаарлах эрх олгоогүй байхад захирамж баталж, иргэдийн жагсаал, цуглаан хийх эрхийг хязгаарлаж, жагсаалыг бүртгэхгүй байх, түүнийг зөрчсөн этгээдэд Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулсан зэрэг хүний эрхийг зөрчсөн цөөнгүй тохиолдол гарсныг судлаачид тэмдэглэж байна.

Иргэд цахим орчинд идэвхтэй болж, аливаа мэдээллийг түргэн шуурхай хүлээн авснаар нийгмийг бухимдуулсан үйл явдал, мэдээлэлд богино хугацаанд хариу үйлдэл, эсэргүүцэл үзүүлдэг болсон өнөө цагт жагсаал, цуглаан зохион байгуулахын тулд жагсаал зохион байгуулахаас 3 өдрийн өмнө Засаг даргад мэдэгдэл өгөх, түүний дагуу мэдэгдлийг бүртгэсэн эсэх хариуг Засаг дарга ажлын 3 өдрийн дотор өгөх, хэрэв бүртгэхээс татгалзсан бол шүүхэд хандаж болох боловч шүүх ажлын 6 өдрийн дотор Засаг даргын татгалзал үндэслэлтэй эсэхийг шийдвэрлэх ёстой. Үүнээс харахад жагсаал, цуглаан хийх мэдэгдлээ бүртгүүлж цуглаан хийхэд нийт ажлын 9 өдөр буюу хуанлийн 14 хоног зарцуулахаар байна. Энэ талаар гадаадын зарим орны сайн туршлага байна. Жишээ нь ХБНГУ-ын хувьд мэдэгдэл өгсний дараа зохион байгуулагч нь зөвшөөрөл авах шаардлагагүй тул эрх бүхий байгууллагаас ямар нэгэн хариу хүлээх ёсгүй байдаг байна.

Иймд жагсаал, цуглаан хийх үндсэн эрхээ эдлэхэд тухайн засаг захиргааны нэгжээс зөвшөөрөл авдаг тогтолцоог өөрчлөх шаардлагатай байна.

2.Цаг үеийн асуудлаас үүдэн иргэд зохион байгуулалтгүйгээр нэгдэн жагссан ба тухайн нөхцөл байдалд манай улсад хуулийн зохицуулалт байхгүй байна.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд жагсаал, цуглааныг зохион байгуулах, бүртгүүлэх, жагсаал, цуглааны хэлбэрүүд болох сөрөг жагсаал, аяндаа үүссэн жагсаал, цуглааны талаарх хуулийн зохицуулалт байхгүйгээс жагсаал, цуглааныг зохион байгуулагчид үүрэг ногдуулсан байдал нь иргэний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хязгаарлах, эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж байна.



Тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний хамрах хүрээнд төлөвлөсөн болон зохион байгуулсан, төлөвлөөгүй буюу аяндаа үүссэн олон төрлийн үйл явдал ордог. Хэн нэг хүний хэлсэн үг, бусдын хийсэн цуглаан, эсхүл тодорхой үйл явдалд хариу болгон зохион байгуулсан цуглааныг аяндаа үүссэн цуглаанд тооцож хүлээн зөвшөөрөх нь олон улсын гэрээ конвенцид нийцнэ. Ийм цуглааны үед зохион байгуулагч байхгүй, эсхүл зохион байгуулагч байсан ч урьдчилсан мэдэгдэл өгөх хуулийн хугацааг баримтлах боломжгүй байдаг. Аяндаа үүссэн цуглаан нь тодорхой үйл явдлын өрнөлийн үед аяндаа бий болдог. Ийм цуглааныг хийх боломжтой байх нь чухал бөгөөд түүнийг хойшлуулснаар илэрхийлэх гэж буй үзэл бодлыг сулруулдаг. Иймд Монгол Улсад аяндаа үүссэн жагсаал, цуглааны зохицуулалтыг бий болгох шаардлагатай.

3. Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн 9 дүгээр зүйлд жагсаал, цуглаан хийх тухай мэдэгдэл хүлээн авах, хянаж хариу өгөх, жагсаал цуглааныг албадан тараах шийдвэрийг гаргах эрх бүхий этгээд нь аймаг, нийслэлийн Засаг дарга буюу улс төрийн албан тушаалтан байдаг. Ийнхүү манай улсад жагсаал, цуглаан зохион байгуулахад бодит байдал дээр зөвшөөрлийн тогтолцоо үйлчилж байгаа бөгөөд жагсаалын зорилго, агуулгад Засаг дарга субъектив байдлаар хандаж жагсаалыг үл зөвшөөрөх, цаашлаад албадан тараах шийдвэр гаргахад хүртэл нөлөөлөх тохиолдлууд гардаг талаар олон нийт шүүмжлэлтэй хандаж байна.

Жагсаал, цуглааны үеэр жагсагчидтай хамгийн ойр ажилладаг, тэдгээрийг зохион байгуулах, аюулгүй байдлыг хангах, хэв журмыг хангуулах, хуульд заасан бол тараах үүргийг цагдаагийн байгууллага хэрэгжүүлдэг. Иймээс гадаадын бусад орны жишиг АНУ, Франц, Япон гэх зэрэг улсын жагсаал цуглаан зохион байгуулах зохицуулалтын туршлагаас үзэхэд тухайн орон нутгийн төрийн тусгай алба буюу цагдаагийн байгууллагад хандах, мэдэгдэх тогтолцоотой байна. Харин төрийн тусгай алба болон Засаг даргын тамгын газар хоорондоо олон нийтийн газар болох үйл явдлын талаар мэдээллийг солилцож харилцан уялдуулдаг байх боломжтой юм.

4. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар жагсаал, цуглааныг хориглох үйл ажиллагааг субъектээр, газар байршлаар, зорилго чиглэлээр, хугацаагаар зэргээр нь төрөл бүрийн хэлбэрээр хязгаарлаж зохицуулсан байна.

Хүний эрхийн олон улсын гэрээ, конвенцийн дагуу тайван жагсаал, цуглаан зохион байгуулахад дээр дурдсан хүрээ хязгаар тогтоож, түүнийг хууль тогтоомжоор өргөжүүлэхгүй байхыг зөвлөдөг. Ийнхүү тогтоосон хориглолт, хязгаарлалт нь хүний тайван хуран цуглах үндсэн эрх чөлөөг хангаагүй гэж үздэг байна.

Манай улсын хувьд Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд байршлаар нь нисэх онгоцны буудал, төмөр замын бүх өртөө, буудал, нийслэлийн зорчигч тээврийн төв буудал, цэрэг, цагдаагийн болон төрийн хамгаалалтад байгаа газар, радио телевизийн нэвтрүүлэг явуулдаг байгууллага, аймаг, нийслэл дэх төв холбооны газар, олон улсын буюу үндэсний яармаг, үзэсгэлэн зохион байгуулж байгаа байгууллага, хот суурин газрын хүнсний болон барааны зах, Нийслэл Улаанбаатар хотын Сүхбаатарын талбайн Төрийн ордны нутаг дэвсгэрт хамаарах хэсэгт гэж хориглосноос гадна бусад

хуулиар хориглох хүрээг өргөжүүлэн тусгасан байдаг. Тухайлбал, Монгол Улсын хилийн тухай хуулиар хилийн боомт, бүсэд, Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хуулиар яаманд, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулиар агентлагт, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулиар хорих ангид, Төрийн ордны тухай хуулиар төрийн ордон, түүний нутаг дэвсгэрт хориглохоор тус тус заасан. Харин Монгол Улсын Их Хурлын 2022 оны 37 дугаар тогтоолоор Төрийн ордны нутаг дэвсгэрийн хэмжээ, заагийг Төрийн ордны баруун, зүүн талын хашаа болон Төрийн ордны хойд талын цэцэрлэгт хүрээлэнгийн урд талын хашаа, Төрийн ёслол хүндэтгэлийн өргөө цогцолборын барилгын бүтээцийн урд хязгаараар тооцож багасган тогтоосон байдаг.

Хүний эрхийн олон улсын байгууллагуудын зөвлөмжид жагсаал, цуглаан хийхийг хориглох байршлыг хавтгайруулж тогтоох нь зохисгүй гэж үздэг байна. Гэхдээ дээрх хуулиар хориглосон байршилд дурдагдаагүй зарим байршлын тухай шинээр авч үзэх боломжтой. Тухайлбал, түүх, соёлын дурсгалт зүйл бүхий байршил, замын хөдөлгөөний зорчих хэсэг зэргийг судлан тусгаж, ийнхүү хуулийн шаардлагыг улс орныхоо нөхцөл байдалд тохируулан хэрэглэх нь зүйтэй байна. Өөрөөр хэлбэл, эдгээр байршилд жагсаал, цуглаан зохион байгуулах тохиолдолд эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн байх зохицуулалтыг бий болгох шаардлагатай. Харин эдгээрээс бусад байршилд зөвхөн мэдэгдэл хүргүүлснээр буюу хариу хүлээх шаардлагагүйгээр тайван хуран цуглах эрхээ хэрэгжүүлэх боломжтой гэж үзэж байна.

Түүнчлэн хориглох субъектээр нь авч үзвэл хуулиар Монгол Улсын иргэн, улсын бүртгэлд бүртгэгдсэн улс төрийн нам, төрийн бус байгууллага жагсаал, цуглаан зохион байгуулах эрхтэй гэж тусгайлан тоочиж хүрээ хязгаарыг зааж өгсөн нь эдгээрээс бусад этгээдийг хориглох агуулгыг илэрхийлж байна. Мөн хуульд сэтгэцийн өвчтэй хүнийг хориглосон бөгөөд мөн бусад хуулиар хориглох этгээдийг тусгайлан заасан нь Төрийн албаны тухай хуулиар төрийн албан хаагчийг, Төрийн тусгай албаны тухай хуулиар төрийн тусгай албаны ажилтанг, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулиар цэргийн албан хаагчийн жагсаал, цуглаан хийх эрхийг хориглон, хязгаарласан байна. Ялангуяа Улсын Их Хурлаас 2017 онд баталж 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн Төрийн албаны тухай хуулийн шинэчилсэн найруулгын 39 дүгээр зүйлийн 39.1.14 дэх заалтад төрийн албан хаагчийг төрийн бодлого, үйл ажиллагааг эсэргүүцсэн аливаа жагсаал, цуглаанд оролцох, мэдээ, мэдээлэл тараахыг хориглосон байна. Энэ нь өмнө үйлчилж байсан 1994, 2002 оны Төрийн албаны тухай хуульд байгаагүй зохицуулалт бөгөөд Монгол Улсын Үндсэн хуулиар олгогдсон эрх чөлөөг хязгаарласан зохицуулалт гэж үзэхээр болжээ.

Иймд дээрх субъектүүдэд тогтоосон хориглолт хязгаарлалтыг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээнд нийцүүлэн дахин авч үзэх шаардлагатай.

5. Монгол Улс хүний эрх эрх чөлөөний асуудлаар нийт 48 гэрээ конвенцид нэгдэн орсон байдаг ч олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлж байгаа гэж Хүний эрхийн Үндэсний Комисс үзсэн байдаг. Цагдаа, хууль сахиулах байгууллагын алба хаагчид хүчин төгөлдөр хуулиар хүлээсэн үүргээ биелүүлсний төлөө олон улсын гэрээ конвенцын өмнө буруутан болох учиргүй. Иймд цагдаагийн байгууллагаас

жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний мөн чанар, үүссэн зөрчлийг хэлэлцээний аргаар шийдвэрлэх ур чадварыг цагдаагийн алба хаагчдад төлөвшүүлэх нь зүйтэй. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисс, Цагдаагийн ерөнхий газар болон Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллага хамтран жагсаал, цуглааны үед хууль сахиулахад хүний эрхийг хангах асуудлаар цагдаагийн сургагч багш нар бэлдэж, энэ чиглэлээр боловсруулсан гарын авлагыг практикт үр дүнтэй ашиглаж байгаа нь сайшаалтай.

Ийнхүү тайван жагсаал, цуглаан хийх эрхийн баталгааг хүний эрхийн аливаа зөрчилгүйгээр хангах шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, хууль ёсоор тайван жагсаал, цуглаанд жагсагч болон цагдаа нарыг сөргөлдүүлэн тавих бус хамтран ажиллах, хоорондоо идэвхтэй харилцаатай байх, мэдээлэл солилцох, зөвлөх туслах харилцаатай байхыг дэмжих чиглэлээр эрх зүйн орчинг өөрчлөх шаардлагатай байна.

Ингэхдээ мэдэгдлийн тогтолцоог хэрэгжүүлэх, жагсаал, цуглааныг албадан тараахдаа эрх хэмжээг хэтрүүлэхгүй байх, жагсагчидтай тохирсон харилцаа үүсгэх, дэмжих-хамтрах-зохицуулах-хянах-сануулах-тараах-хүч хэрэглэх гэсэн дарааллыг баримтлах, Засаг даргын захирамжийг үндэслэн тараадгийг өөрчилж зөвхөн хуульд заасан үндэслэлээр эрх бүхий этгээд албадан тараах, түүнчлэн албадан тараах нөхцөл боломж буюу тодорхой хугацааны өмнө мэдэгдэх, албадан тараасны дараа энэ талаар олон нийтэд мэдээлэл өгөх зэрэг зохицуулалтыг бий болгох шаардлагатай байна.

6. Жагсаал, цуглаан түүнтэй холбоотой мэдээллийг ил тод байхад чиглэсэн арга хэмжээг тусгах шаардлагатай. Тухайлбал, жагсаал цуглааны үйл явц олон нийтэд нээлттэй, ил тод ялангуяа хэвлэл мэдээллийн хэрэгслийг сурвалжлах, оролцогчдын дуу хоолойгоо хүргэх газарт нь хүргүүлэх боломжийг хязгаарлахгүй байх нь зүйтэй.

7. Эрүүгийн хуульд хүний үзэл бодол, итгэл үнэмшлийн төлөө эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүй байхаар заасан байдаг. Засгийн газраас 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гамшгийн үеийн хорио цээрийн дэглэм зөрчсөн гэх үндэслэлээр жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцсон үед оногдуулж байгаа баривчлах шийтгэлийг хасаж боловсруулсан бөгөөд тус хуулийн төсөл болон Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг уялдуулах шаардлагатай.

8. Иргэд үзэл бодлоо илэрхийлэх нэг хэлбэр болох өлсгөлөнгийн зохицуулалт одоо үйлчилж байгаа практикт Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд нарын хамтарсан тушаалаар баталсан "Албадан эмчлэх журам"-ын дагуу зохицуулж хэрэгжүүлж ирсэн. Энэ нь нэг талаар хүний үзэл бодлоо илэрхийлэх эрхийг хүлээн зөвшөөрч байгаа ч нөгөө талаар тухайн этгээдийн эрүүл мэнд, амь насыг хамгаалах нь хүнлэг ёс, төрийн үйл ажиллагааны нэг хэлбэр байх учиртай. Гэвч дээрх журмыг батлах эрх хуулиар олгогдоогүй бөгөөд тус журмаар зохицуулж байгаа хүний эрхэд хязгаарлалт хийж байгаа уг харилцааг хуульд тодорхой тусгаж шийдвэрлэх нь зүйтэй байна.

9.Хүчин төгөлдөр үйлчилж байгаа Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуульд гадаадын иргэн, харьяалалгүй хүн хуулийн дагуу зохион байгуулагдаж байгаа жагсаал, цуглаанд зөвхөн оролцох эрхтэй байх зохицуулалт үйлчилж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван наймдугаар зүйлийн 5 дахь хэсэгт “Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлд заасан Монгол Улсын иргэний үндсэн эрх, эрх чөлөөг тус улсын нутаг дэвсгэрт байгаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнд эдлүүлэхдээ Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд заасан хүний салшгүй эрхээс бусад эрхийн хувьд үндэсний болон хүн амын аюулгүй байдлыг хангах, нийгмийн хэв журмыг хамгаалахын тулд хуулиар зохих хязгаарлал тогтоож болно.” гэж заасан. Даяарчлагдаж байгаа өнөө цагт гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн өөрийн зөрчигдөж буй эрх, эрх чөлөө, ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор үзэл бодлоо илэрхийлэн тайван жагсаал, цуглаан санаачлах, зохион байгуулах эрх нь ардчилсан нийгмийг дээдэлдэг аль ч улсад нээлттэй байх учиртай. Харин тухайн гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хуулиар тодорхой шаардлага тавих замаар хэрэгжүүлэх боломжтой юм.

Жагсаал, цуглаан хийх журмын тухай хуулийн нэрийг иргэдийн үзэл бодлоо илэрхийлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрхийг журамлах агуулгыг өөрчилж Жагсаал, цуглаан хийх эрх чөлөөний тухай гэж боловсруулна.

#### **Хоёр.Хуулийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа**

Хуулийн төсөл нь 4 бүлэг 15 зүйлтэй байх бөгөөд дараах асуудлыг тусган боловсруулна.

Нэгдүгээр бүлэг.Нийтлэг үндэслэл хэсэгт хуулийн зорилт, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль тогтоомж, үйлчлэх хүрээ, жагсаал, цуглааны үйл ажиллагаан дахь зарчим зэргийг тусгана.

Хоёрдугаар бүлэг.Цуглааны талаарх нэр томъёоны тайлбар, цуглааны хэлбэрүүд, жагсаал, цуглаан хийх эрхийн баталгаа, жагсаал, цуглаан зохион байгуулах, оролцох үйл ажиллагаа, жагсаал, цуглаан зохион байгуулах, түүнд оролцох эрхийн баталгааны талаар тусгана.

Гуравдугаар бүлэг.Жагсаал, цуглаан зохион байгуулах хязгаарлалт буюу жагсаал, цуглаан хийхийг хориглох газар, зорилго, агуулга, жагсаал, цуглааны бүртгэл болон бусад хязгаарлалт, зохион байгуулахад мэдэгдэх үйл ажиллагааны зохицуулалт, зохион байгуулагч болон оролцогчийн үүргийг тусгана.

Дөрөвдүгээр бүлэг.Оролцогчийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журмыг хангуулах, жагсаал, цуглаан, түүнд оролцогчдыг хамгаалах, эрх бүхий этгээдээс хариу үзүүлэх, албадан тараах, жагсаал зохион байгуулах үйл явц, нээлттэй ил тод байх.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар**

Хуулийн төсөл батлагдсанаар Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактад заасан иргэдийн тайван хуран цуглах эрх бүрэн хангагдагдаж, зөвхөн хуульд заасан үндэслэлээр энэхүү эрхийг хязгаарлах зохицуулалт баталгаажна.

Цуглааны хэлбэрүүдийг хүлээн зөвшөөрнө. Жагсаал, цуглааны хориглолт, хязгаарлалтын хүрээ хязгаар тодорхой болно. Хуульд зааснаас бусад аливаа хэлбэр, тухайлбал, захиргааны хэм хэмжээний актаар хязгаарлах боломжгүй болно.

Жагсаал, цуглаан зохион байгуулахад зөвшөөрлийн тогтолцоо үйлчилж байгаа байдал хязгаарлагдаж, зөвхөн онцгой нөхцөл байдал, зайлшгүй хориглох цөөн тохиолдлоос бусад тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэл хүргүүлснээр жагсаал, цуглаан зохион байгуулах боломж бүрдэнэ.

Цагдаагийн байгууллагаас олон нийтийн аюулгүй байдлыг хангах, нийгмийн дэг журмыг сахиулахдаа хүний эрхийн зөрчил гаргахгүй байх, хууль ёсоор тайван жагсаал, цуглаанд жагсагч болон цагдаа хамтран ажиллах, хоорондоо идэвхтэй харилцаатай байх, мэдээлэл солилцох, зөвлөн туслах нөхцөл бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаарх санал**

Хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуульд нийцүүлэн боловсруулна.

Хуулийн төсөлтэй холбогдуулан Онц байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Дайны байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дотоодын цэргийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын хилийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Жагсаал, цуглаан хийх журмын тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийг тус тус боловсруулна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ... ны өдөр

Төсөл

Улаанбаатар  
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл нэмсүгэй:

1/7.5, 7.6, 7.7, 7.8 дугаар зүйл:

"7.5 дугаар зүйл. Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээний төрөл

1. Шүүх албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх шаардлагатай гэж үзвэл тухайн этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан уг арга хэмжээний төрлийг сэтгэц эмгэг судлалын шинжээчийн дүгнэлтийг үндэслэн тогтооно.

2. Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ дараах төрөлтэй байна:

- 2.1. хамгаалах зорилгоор тусгаарлан эмчлэх;
- 2.2. сэтгэцийн эмгэг судлаачийн хяналтад эмчлэх;
- 2.3. донтох зуршлын эсрэг эмчилгээ хийх;
- 2.4. сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх.

3. Хамгаалах зорилгоор тусгаарлан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг сэтгэцийн эмгэг, мансуурах, согтуурах донтой байдлын улмаас гэмт хэрэг үйлдсэн хүний сэтгэцийн байдлыг тогтоох, өөртөө болон бусдад аюул учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэг хянан шийдвэрлэх хүртэлх хугацаанд харуул хамгаалалт бүхий эмнэлгийн байгууллагад тусгаарлан байлгах тохиолдолд хэрэглэнэ.

4. Сэтгэцийн эмгэг судлаачийн хяналтад эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг сэтгэцийн эрүүл мэндийн байдал нь тогтвортой, хөнгөн хэлбэрийн сэтгэцийн өвчтэй боловч хэрэг хариуцах чадвартай хүнийг сэтгэцийн эмчийн хяналтад гадуур, эсхүл хорих ангийн байрлалд албадан эмчлэх тохиолдолд хэрэглэнэ.

5. Донтох зуршлын эсрэг эмчилгээ хийх аюулгүй байдлын арга хэмжээг согтуурах, мансуурах донтой хүнийг гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор оногдуулсан ял дээр нэмж хэрэглэнэ.

6. Донтох зуршлын эсрэг эмчилгээг гадуур эсхүл хэвтэн эмчлүүлж хийлгэж болох ба эмгэгийн шинж байдлаас нь хамаарч ердийн, эсхүл тусгай тасагт эмчилж болно.

7. Сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг гэмт этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан тусгай хамгаалалт бүхий нөхцөлд албадан эмчилнэ.

8. Сэтгэцийн эмнэлэгт хэвтүүлэн эмчлэх албадлагын арга хэмжээ нь ердийн болон тусгай тасагтай байна:

8.1. ердийн тасагт хөнгөн гэмт хэрэг үйлдсэн, сэтгэцийн эрүүл мэндийн байдал нь тогтворжсон боловч хэвтүүлэн эмчлэх шаардлагатай хүнийг ердийн хамгаалалт бүхий нөхцөлд албадан эмчилнэ.

8.2. тусгай тасагт гэмт этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан өндөржүүлсэн хамгаалалт бүхий нөхцөлд албадан эмчилнэ.

9. Ердийн болон тусгай тасагт эмчлэхэд тухайн гэмт этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэх, өөртөө болон бусдад аюул учруулах боломжгүй нөхцөлд байлгана.

7.6 дугаар зүйл. Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээний хугацаа

1. Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх шаардлагатай гэж шүүх үзвэл тухайн этгээдийн сэтгэцийн эрүүл мэндийн байдал, үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээг харгалзан сэтгэц эмгэг судлалын шинжээчийн дүгнэлтийг үндэслэн тогтооно.

2. Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэсэн бол нэг жил тутам сэтгэцийн эрүүл мэндийн төв эмнэлгийн магадлан тогтоох комисс өвчний шинж байдлын талаар дүгнэлт гаргаж, шүүх уг дүгнэлтийг харгалзан хугацааг сунгах, өөрчлөх, зогсоох эсэхийг шийдвэрлэнэ.

3. Донтох эмгэг судлалын тасагт албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх хугацаа 12 сар хүртэл байна.

4. Хорих ял шийтгэгдсэний дараа сэтгэцийн өвчний улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон этгээдэд шүүх эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэсэн бол ялтны эдлээгүй үлдсэн хорих ялтай тэнцүү хугацаагаар хэрэглэнэ.

5. Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх дээд хугацаа нь Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан тухайн гэмт хэрэгт оногдуулж болох хорих ялын дээд хэмжээнээс хэтэрч болохгүй.

7.7 дугаар зүйл. Албадан эмчлэх аюулгүй арга хэмжээг өөрчлөх, зогсоох

1.Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээний төрлийг өөрчлөх, зогсоох эсэхийг шүүх шинжээчийн дүгнэлтийг үндэслэн шийдвэрлэнэ.

2.Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсны улмаас албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг арга хэмжээг зогсоох тухай шийдвэр гаргана.

3.Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадвартай байсан боловч хэрэг шалган шийдвэрлэх үед хэрэг хариуцах чадваргүй болсны улмаас албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ авагдсан хүний хэрэг хариуцах чадваргүй байдал арилсан бол шүүхээс уг албадлагын арга хэмжээг зогсоож, ял оногдуулна.

4.Донтох эмгэг судлалын тасагт албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх хугацаа дууссан, эсхүл эмчлэгдсэн бол уг арга хэмжээг зогсооно.

5.Энэ хуулийн 7.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан хугацаа дууссан бол шүүх албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг зогсоох шийдвэр гаргаж, асран хамгаалагч, эсхүл асрамжийн төвд шилжүүлэх шийдвэр гаргана.

6.Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүний сэтгэцийн байдал нь өөртөө, бусдад аюул учруулахааргүй бол шүүх албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, эсхүл асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болно.

#### **7.8 дугаар зүйл.Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэсэн хугацааг тооцох**

1.Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ авагдсан хүн хөөн хэлэлцэх хугацаанд эмчлэгдсэн, хэрэг хариуцах чадваргүй байдал нь арилсан бол шүүхээс түүнд оногдуулсан ялаас албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ авагдсан нэг хоногийг хорих ялын нэг хоногоор тооцон хасаж, үлдсэн ялыг эдлүүлнэ.

2.Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээг ялтны эдлээгүй үлдсэн хорих ялтай тэнцүү хугацаагаар хэрэглэх бөгөөд хэрэг хариуцах чадваргүй байдал уг хугацааны дотор арилсан бол шүүх эдлээгүй үлдсэн хорих ялыг биечлэн эдлүүлэхээр шийдвэрлэнэ.

3.Хорих ял шийтгүүлсэн согтуурах, мансуурах донтой этгээдийн ялын хугацаанд албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн хугацааг оруулан тооцно.

4.Хамгаалах зорилгоор эмчийн хяналтад тусгаарлан эмчилсэн хугацааг хорих ял эдэлсэн болон албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэсэн хугацаанд оруулан тооцно.

5.Хорихоос өөр төрлийн ялтай зэрэгцүүлэн сэтгэцийн эмгэг судлаачийн хяналтад гадуур эмчлэх арга хэмжээ авагдсан этгээдийн эмчилгээний хугацааг шүүхийн шийдвэр гарсан өдрөөс эхлэн тооцно.”

#### **2/29.12 дугаар зүйл:**

#### **“29.12 дугаар зүйл.Хүнийг хүчээр алга болгох**

1.Төрийн албан хаагч, төрөөс эрх олгогдсон, зөвшөөрөл авсан этгээд хүнийг хууль бусаар саатуулсан, баривчилсан, хорьсон, хулгайлсан, хууль бусаар нууж эрх чөлөөг нь хязгаарласан, эсхүл хорьсон, эрх чөлөөг нь хязгаарласан талаарх мэдээллийг нууж, мэдээлэл өгөхөөс татгалзаж эрх чөлөөг нь хязгаарласны улмаас бусдын хууль ёсны эрх, ашиг сонирхолд нь хохирол, хор уршиг учруулсан нь энэ хуулийн тусгай ангид заасан бусад гэмт хэргийн шинжгүй бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг удирдах албан тушаалтан үйлдсэн, тушаал, даалгавар өгсөн, эсхүл доод шатны албан тушаалтан хүнийг хүчээр алга болгох гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үйлдэх гэж байгааг мэдсээр байж үл тоомсорлосон, зохих ёсоор биелүүлээгүй, эсхүл хүчээр алга болгох гэмт хэрэг үйлдэгдэж байгааг эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй бол хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.хүүхэд, биеэ хамгаалж чадахгүй, жирэмсэн эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдгийг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг;

3.2.хоёр, түүнээс олон хүний эсрэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг:

4.1.хохирогчийн эрүүл мэндэд хүнд хохирол учруулж;

4.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5.Энэ гэмт хэргийн улмаас хохирогч нас барсан бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар:-Хууль бусаар саатуулсан, баривчилсан, хорьсон, хулгайлсан, эсхүл хууль бусаар нууж эрх чөлөөг нь хязгаарласан хүнийг сайн дураараа сулласан, суллахад хууль сахиулах байгууллагатай хамтран ажилласан, тусалцаа үзүүлсэн бол эрүүгийн хариуцлагыг хөнгөрүүлэх үндэслэл болно.”

**2 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:**

#### **1/6.3 дугаар зүйл:**

#### **“6.3 дугаар зүйл.Хэрэг хариуцах чадвар**

1.Хэрэг хариуцах чадварыг алдагдуулдаггүй сэтгэцийн эмгэг, түр сэрнилын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанарыг ухамсарлах, үйлдлээ удирдах, жолоодох чадварт тодорхой хэмжээгээр нөлөөлж байгаа сэтгэцийн өөрчлөлтийг хэрэг хариуцах хязгаарлагдмал чадварт тооцно.

2.Хэрэг хариуцах хязгаарлагдмал чадвартай байх үедээ энэ хуульд заасанхүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, энэ хуулийн 10.2 дугаар зүйл, 10.5 дугаар зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахын зэрэгцээ албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэнэ."

**2/6.10 дугаар зүйл:**

**"6.10 дугаар зүйл.Цагдан хоригдсон болон хамгаалах зорилгоор эмчийн хяналтад тусгаарлан эмчилсэн хугацааг тооцох**

1.Шүүх баривчлагдсан, цагдан хоригдсон, хамгаалах зорилгоор эмчийн хяналтад тусгаарлан эмчилсэн хугацааг ялтны эдлэх ял болон албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэсэн хугацаанд оруулан тооцно.

2.Баривчлагдсан, цагдан хоригдсон, хамгаалах зорилгоор эмчийн хяналтад тусгаарлан эмчилсэн нэг хоногийг торгох ялын арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, нийтэд тустай ажил хийлгэх ялын найман цагаар, зорчих эрхийг хязгаарлах ялын нэг хоногоор, хорих ялын нэг хоногоор тооцож эдлэх ялаас хасна."

**3/7.4 дүгээр зүйл:**

**"7.4 дүгээр зүйл.Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх**

1.Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ нь энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нөхцөл байдалд гэмт хэрэг үйлдсэн хүнийг эмчлэх, гэмт хэрэг дахин үйлдэх, өөртөө болон бусдад аюул учруулахаас урьдчилан сэргийлгэх зорилготой байна.

2.Гэмт хэрэг үйлдэх үедээ дор дурдсан нөхцөл байдалд байсан хүн өөртөө болон бусдад аюул учруулахаар бол шүүх албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэх шийдвэр гаргана.

2.1.хэрэг хариуцах чадваргүй, сэтгэцийн хувьд өөрийн үйлдэл, эс үйлдэхүйн бодит аюулын шинж чанарыг бүрэн ухамсарлаж, удирдан жолоодох чадваргүй байсан;

2.2.хэрэг хариуцах чадвартай боловч гэмт хэрэг үйлдэх үедээ сэтгэцийн эмгэг, түр саатлын улмаас өөрийн үйлдлийн бодит мөн чанарыг ойлгож, ухамсарлах чадваргүй байсан;

2.3.гэмт хэрэг үйлдсэний дараа сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй болсон;

2.4.бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг үйлдсэн хүн бэлгийн гаж зан үйлийн эмгэгтэй болох нь шүүх сэтгэц эмгэг судлалын дүгнэлтээр тогтоогдсон;

2.5.согтуурсан, мансуурсан үедээ гэмт хэрэг үйлдсэн хүн согтуурах, мансуурах донтой болох нь шүүх сэтгэц эмгэг судлалын дүгнэлтээр тогтоогдсон.

3.Энэ зүйлийн 2 дахь хэсгийн 2.2, 2.4, 2.5-д заасан нөхцөл байдалд гэмт хэрэг үйлдсэн хүнд ял оногдуулахын зэрэгцээ албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэж болно.

4.Хорих ял шийтгэгдсэний дараа сэтгэцийн өвчний улмаас хэрэг хариуцах чадваргүй болсон этгээдэд шүүх эмнэлгийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэнэ.

5.Албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ авагдсан хүнд оношилгооны болон эмчилгээний туршилт хийхийг хориглоно.

6.Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүний сэтгэцийн байдал нь өөртөө болон бусдад аюул учруулахааргүй бол шүүх албадан эмчлэх аюулгүй байдлын арга хэмжээ хэрэглэхгүйгээр сэтгэцийн эрүүл мэндийн холбогдох байгууллагад эмчлүүлэх, эсхүл асран хамгаалагчид халамжлуулахаар шилжүүлж болно."

**4/13.13 дугаар зүйл:**

**"13.13 дугаар зүйл.Албадан хөдөлмөрлүүлэх**

1.Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж хүсэл зоригийн эсрэг, эсхүл цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: Албадан хөдөлмөрт шүүхийн шийтгэх тогтоолыг үндэслэн гүйцэтгүүлж буй нийтэд тустай ажил хамаарахгүй."

**5/13.4 дүгээр зүйл:**

**"13.4 дүгээр зүйл.Хүнийг хууль бусаар хорих**

1.Хүнийг хууль бусаар хорьсон нь хүнийг хүчээр алга болгох гэмт хэргийн шинжгүй бол нэг мянга гурван зуун тавин нэгжээс арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг:

2.1.бүлэглэж;

2.2.хүч хэрэглэж;

2.3.зэвсэг, зэвсгийн чанартай зүйл хэрэглэж;

2.4.хүүхэд, биеэ хамгаалж чадахгүй, жирэмсэн эмэгтэй, хөгжлийн бэрхшээлтэй хүн гэдгийг мэдсээр байж, эрхшээлдээ байгаа хүний эсрэг;



2.5.хоёр, түүнээс олон хүний эсрэг үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг:

3.1.найм, түүнээс дээш жилийн хугацаагаар хорьсон;  
3.2.зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

#### 6/14.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг:

"2.Энэ гэмт хэргийг:

2.1.боловсролын байгууллагын орчинд;  
2.2.бүлэглэж;  
2.3.цахим сүлжээ ашиглаж үйлдсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

#### 7/21.12 дугаар зүйл:

##### "21.12 дугаар зүйл.Эрүү шүүлт тулгах

1.Төрийн албан хаагч сэжигтэн, яллагдагч, шүүгдэгч, ялтан, хоригдол, хохирогч, гэрч, бусад хүнээс тайлбар, мэдүүлэг авах, мэдээ сэлт гаргуулан авах, хэрэг хүлээлгэх, ял, шийтгэл оногдуулах, айлган сүрдүүлэх, алагчлах зорилгоор өөрөө, эсхүл бусад этгээдийг хатгаж, зөвшөөрөл олгож, эсхүл бусад байдлаар тухайн үйлдлийг хийхийг зөвшөөрч байгаага илэрхийлж бусдын бие махбод, сэтгэл санааг шаналган зовоосон бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ."

3 дугаар зүйл.Эрүүгийн хуулийн 7.5,7.6 дугаар зүйлийн дугаарлалтыг 7.9, 7.10 дугаар зүйл гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Эрүүгийн хуулийн 13.4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг 2024 оны ... сарын ... ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл

Хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх 22 дугаар илтгэлд Эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ ба хүний эрхийн асуудал сэдвээр тусгайлан дүн шинжилгээ хийж, дүгнэлт санал боловсруулсан байна. Ингэхдээ эмнэлгийн чанартай албадагын арга хэмжээ хэрэглэхэд хууль ёсны төлөөлөгчийн оролцоог хангах, төрөл дэглэм, хугацаа тогтоож буй байдлын талаар гаргасан дүгнэлтийг харгалзан үзэж хуулийн төслийг боловсрууллаа.

Түүнчлэн Монгол Улсын нэгдэн орсон Олон улсын гэрээ конвенц, зөвлөмжид:

-Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцийн хэрэгжилттэй холбогдуулан Хүчээр алга болгох асуудал хариуцсан хорооноос Монгол Улсаас хүргүүлсэн тайланг хэлэлцэж 2021 онд өгсөн зөвлөмжид "Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т заасан Хүчээр алга болгох гэмт хэрэг нь Хүчээр алга болгохоос бүх хүнийг хамгаалах тухай конвенцид заасан тодорхойлолт ("Хүчээр алга болгох" гэдэг нь алга болсон аливаа хүний эрх чөлөөг хассан явдлыг хүлээн зөвшөөрөхөөг татгалзсан буюу түүний хувь заяаны талаарх мэдээлэл, эсхүл оршин суугаа газрыг нуусны улмаас тухайн хүнийг хуулийн хамгаалалт эдэлж чадахгүй байдалд хүргэхүйцээр төрийн төлөөлөгчид буюу төрөөс эрх олгогдсон, дэмжлэг буюу зөвшөөрөл авсан этгээдүүд, эсхүл бусад хэлбэрээр эрх чөлөөг нь хасахыг хэлнэ")-оос агуулгын хувьд ихээхэн зөрүүтэй байгааг анхаарч тодорхойлолтыг конвенцид бүрэн нийцүүлэх;

-Эрүүгийн хуульд уг гэмт хэргийн субъект (хүчээр алга болгох үйлдлийг гүйцэтгэсэн, тушаасан, турхирсан буюу өдөөсөн, сэдсэн, оролцсон буюу хамтарч гүйцэтгэсэн, уг үйлдлийг хянаж байсан, эсхүл доод албан тушаалтны үйлдлийг мэдсэн ч зохих арга хэмжээ аваагүй удирдах албан тушаалтан) болон хүндрүүлэх нөхцөлийг дутуу тодорхойлсон байгааг анхаарч конвенцид бүрэн нийцүүлэх; хүчээр алга болгох гэмт хэргийг конвенцийн 5 дугаар зүйлд нийцүүлэн Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэгт тооцохыг хоёрдмол утгагүйгээр хүлээн зөвшөөрөх;"

-Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилттэй холбогдуулан НҮБ-ийн Эрүүдэн шүүхийн эсрэг хорооноос Монгол Улсын тайланд өгсөн зөвлөмжид "Эрүүгийн хуулийн 21.12 дугаар зүйлд заасан Эрүү шүүлт тулгах гэмт хэргийн тодорхойлолтыг конвенцийн 1 дүгээр зүйлд заасан "аливаа байдлаар алагчилж, эсхүл айлган сүрдүүлэх, шахалт үзүүлэх зорилгоор эрүүдэн шүүх, мөн гуравдагч этгээдэд хамааралтай байх гэсэнтэй бүрэн нийцүүлэн тодорхойлох" гэж тус тус зөвлөсөн.

Иймд Эрүүгийн хуулийн зарим зохицуулалтыг олон улсын хүний эрхийн гэрээ конвенцид нийцүүлэх шаардлагаар тухайлбал, Эрүүгийн хуулийн Арван гуравдугаар бүлэгт заасан Халдашгүй чөлөөтэй байхын эсрэг зарим төрлийн гэмт хэргийг

хуульчлах тухайлбал, Арван дөрөвдүгээр бүлэгт заасан Хүний хувийн, улс төрийн эрх, эрх чөлөөний эсрэг зарим төрлийн гэмт хэрэг, тухайлбал, ялгаварлан гадуурхах гэмт хэргийн шинжийг өргөжүүлж, олон улсын конвенцид нийцүүлж, хүчээр алга болгох гэмт хэргийг Хүн төрөлхтний эсрэг гэмт хэрэг гэсэн бүлэгт шилжүүлэн тусгалаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ